

Гүнзгий мэд

MONGOLIAN ECONOMY

2016 ОНЫ 02 САР №04 (106)

mongolianeconomy.mn


Шинэ салхи

Сайн дурын кодекс итгэлцэл бий болгоно

Нэг Хятад, нэг Тайвань




ЭМХЭТГЭЛ 2015





ПЕТРОВИС
ХӨГЖИЛ ТҮГЭЭНЭ
1941 оноос



Mobil 1



**PETRO
MATAD**

*Монгол орны өнцөг булан бүрт
Бид хүрч үйлчилнэ!*



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН



СУРГАМЖ, СОРИЛТ, ШИЙДЭЛ

2016 ОНЫ 3 ДУГААР САРЫН 30-31,
ТӨРИЙН ОРДОН

ЦАХИМ БҮРТГЭЛ

WWW.MEFORUM.MN/REGISTER

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

ВЭБ WWW.MEFORUM.MN
УТАС 11321051

ДЭЛХИЙН ХӨТӨЧ

Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн
“The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.
Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.
ЗОВЛОН ЗҮДГҮҮР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг уг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг. Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904



Нэг Хятад, Нэг Тайвань

Бүх талаараа Тайвань тусгаар тогтносон улс байх эрхтэй. Гэхдээ Цай Ин Вэн улс нь хараахан өнөөдөр тийм болчихож чадахгүй гэдгийг ойлгох ёстой болж байна, хуу 10



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:
Д.Бэжбаяр

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:
Б.Үүрийнтуяа
Б.Энхцэцэг
Г.Орхон
Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:
Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Бариянжав

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, I хороо, Экспресс тауэр. 1101 тоот
Вэб: www.mongolianeconomy.mn
И-мэйл: info@mongolianeconomy.mn
Утас: 976-7011 5476

Борлуулах цэгүүд:
“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетин бүх салбар
“Макс” супермаркетин бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэл” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн:
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр
“Max mall” дахь салбарууд

Эдийн засаг

- 8 Шинэ салхи
- 10 Үйл ажиллагааны сайн дурын кодекс итгэлцэл бий болгоно
- 11 Аржун Балла: Кодексын дагуу компаниудын тайланг олон нийтэд ойлгомжтойгоор мэдээлнэ
- 13 Нэг Хятад, Нэг Тайвань
- 15 Дижитал эдийн засгийн парадигм
- 16 Жинхэнэ мега төслүүд

ЭМХЭТГЭЛ 2015

Эдийн засаг

- 22 Билэгэномикс
- 24 Б.Түвшинтөгс: Институцийг сайжруулснаар эдийн засгийн хүндрэлээс гарна
- 27 Далд хуйвалдаан эдийн засгийг “дарлаж” байна

- 29 Ядуусын амьдралд олон салаа өргөс ургасаар, ужигарсаар
- 33 Хүндрэлийг даван түүлах хөтөлбөрийг тольдохуй
- 34 Барилга өнөөдөр
- 36 Уур амьсгалын өөрчлөлтийн эргэх цэг
- 38 Б.Лакшми: Хөрөнгө оруулагчдад эдийн засаг муу байх нь хамаагүй тогтвортой байх нь л чухал

Бизнес

- 40 Б.Бямбасайхан: Компанийг компани шиг л ажиллуулах хэрэгтэй

Зочин

- 46 Япон, Монголын шинэ түншлэл ба боломж
- 48 “Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч өртөмтгий байна”



Аржун Балла: Кодексын дагуу компаниудын тайланг олон нийтэд ойлгомжтойгоор мэдээлнэ

Монгол бол Олон улсын санхүүгийн корпорацийн хувьд усны менежментийн чиглэлээр кодекс боловсруулж буй анхны улс орон, хуудас 9



Б.Лакшми: Хөрөнгө оруулагчдад эдийн засаг муу байх нь хамаагүй тогтвортой байх нь л чухал

Хөрөнгө оруулагчдаа яг яаж холбох, хэрхэн үйлдээ холбоотой ажиллах талаар хэлэлцэх утгаараа хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт илүү үр дүнтэй юм, хуудас 38



Б.Бямбасайхан: Компанийг компани шиг л ажиллуулах хэрэгтэй

Яагаад олон улсын стандарт шаардлагатай байна вэ?, хуудас 40



“Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч өртөмтгий байна”, хуудас 48



Ядуусын амьдралд олон салаа өргөс ургасаар, ужигарсаар

Дэлхийн банк туйлын ядуурлыг өдөрт нэг ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа, дунд зэргийн ядуурлыг хоёр ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа хэмээн тодорхойлдог. Гэтэл Монголд хоногт зургаахан зүсэм талхаар өл залгаж буй өрх гэрүүд байна, хуудас 29



МОНГОЛД

Санхүү



Санхүүгийн зохицуулах хорооны болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын холбогдох хүмүүс харилцан мэдээлэл солилцох гэрээнд гарын үсэг зурлаа. Тус гэрээний хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо нь ШШГЕГ-ын бүртгэл хяналтын системийн нэгдсэн сангаас, ШШГЕГ нь Санхүүгийн зохицуулах хорооны “Зөвшөөрлийн цахим систем”-ээс мэдээлэл авах юм. Ингэснээр төрөөс учруулж буй хүнд суртлыг багасгах, цаг хугацаа хэмнэх гээд олон давуу талтай аж. Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэг гүйцэтгэгч Э.Батболд хэлэхдээ “Одоогоор СЗХ-ны зөвшөөрлийн цахим системээс мэдээлэл авах хүсэлт ирүүлсэн 90 гаруй байгууллага байна. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь улсын бүртгэлийн байгууллага, татварын байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гээд олон газраас бичиг авдаг байсан бол одоо мэдээллийг шууд солилцдог болсноор энэ хүндрэл байхгүй боллоо” гэдгийг онцоллоо.

Эдийн засаг



Эдийн засгийн зөвлөлийн энэ оны эхний хуралдаан боллоо. Хуралдааны үеэр

Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэлэхдээ “Оюу толгойн гүний уурхайн хөрөнгө оруулалтын ажил эхэлсэн бөгөөд Гацууртын ордыг эргэлтэд оруулах асуудал чуулганаар эцэслэн батлагдлаа. Цаашид Таван толгойн орд газраа эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг шийднэ. Бид хувийн хэвшилд суурилсан эдийн засгийг дэмжих бодлого баримталж, далд эдийн засгийг ил болгоход чиглэсэн олон ажлыг эхлүүлсэн нь үр дүнгээ өгч эхэллээ. Тухайлбал “Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль”-ийг хэрэгжүүлж, хөрөнгө орлогын мэдүүлгийг авч эхэлснээр өнөөдрийн байдлаар 14.4 их наяд төгрөг төвлөрөөд байна. Мөн НӨАТ-ын хоёр хувийг буцаан олгох хуулийг хэрэгжүүлж эхэлснээр далд эдийн засгийг нээлттэй болгоход багагүй үр өгөөжөө өгч эхэлсэн. Засгийн газрын зүгээс хэрэглээний эдийн засгаас хуримтлалын эдийн засагт шилжих бодлогыг баримталж ипотекийн зээл, үйлдвэрлэл дэмжсэн зээл, малчны зээлийг дэмжих бодлого баримталж ажиллана” гэдгийг онцоллоо.

Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр байгуулсантай холбогдуулан Засгийн газрын 2009 оны 88 дугаар тогтоолоор баталсан “Барааны гарал үүслийн дүрэм”-д зарим өөрчлөлт оруулах шаардлагатай болсон байна. Ийнхүү гаалийн тариф болон татварын тухай хуулийг үндэслэн “Барааны гарал үүслийн дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталлаа. Энэхүү дүрэм батлагдсанаар олон улсын гэрээ хэлэлцээр хэрэгжиж, тарифын хөнгөлөлт эдэлснээр гадаад худалдаа эрхлэгчдэд татварын хөнгөлөлттэй тариф хэрэглэх боломж бүрдэх аж.

Зэрэглэл

Энэ оны хоёрдугаар сарын 22-ны байдлаар Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Standard & Poor's /S&P/ болон Fitch агентлаг “B”, Moody's B2 гэж үнэлжээ. Тэд эдийн засгийн өсөлт саарсан, төсвийн алдагдал нэмэгдсэн, өрийн хэмжээ өсч буйгаас шалтгаалан ийнхүү Монголын зээлжих зэрэглэлийг бууруулаад байна. “S&P”, “Fitch” Монгол Улсын зээлжих зэрэглэлийн ирээдүйн төлвийг тогтвортой гэж харж байгаа бол Moody's сөрөг гэв. Тодруулбал, түүхий эдийн зах зээлийн ханшийн уналт болон Хятадын эдийн засгийн удаашралаас үүдэн ирэх 12-18 сард Монголын зэрэглэл илүү хүнд нөхцөл байдалд орно гэж Moody's дүгнэжээ.

Газрын тос



Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэд хилийн үнэ, татвар, төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт, үйл ажиллагааны зардал зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Төр, засгийн зүгээс дээрх татваруудыг өөрчлөх замаар жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтворжуулж ирсэн. Өнгөрөгч оны арванхоёрдугаар сараас эхлэн шатахууны жижиглэнгийн үнийг баруун бүсэд 80-400 төгрөгөөр, зүүн бүсэд 10-230 төгрөгөөр тус тус бууруулсан. Харин энэ сарын 20-оос Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл, Архангай зэрэг аймагт шатахууны үнийг 100-150 төгрөгөөр бууруулахаар болжээ. Мөн энэ сарын 21-ний өдрөөс Улаанбаатар

хотод шатахууны үнэ 80-150 төгрөгөөр буурсан юм.

Хууль



Монгол Улсын ашигт Малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээхтэй холбоотой нийгмийн харилцааг 2009 онд батлагдсан “Хүний хөгжил сангийн тухай” хуулиар зохицуулж ирсэн. Хүний хөгжил сангийн тухай хуульд компанийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагатай холбоотой харилцааг шууд зохицуулсан заалтууд байгаа нь Монгол Улсын компанийн тухай хуулийн зарим зүйл заалттай агуулгын хувьд зөрчилдөж засаглалын ойлгомжгүй бүтцийг бий болгосон. Иймд зөрчилтэй зохицуулалтыг засахаар Хүний хөгжил сангийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулжээ. Энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсанаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж, компанийн удирдлагын зөв бүтцийг Компанийн тухай хуулийн ерөнхий агуулга, зарчим, зохицуулалтын дагуу бүрдүүлж, компанийн ашгийн төлөө, хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн боломж бий болох аж. Харин Хүний хөгжил сангийн хөрөнгийн ерөнхий удирдлага нь Сангийн яаманд хэвээр хадгалагдан үлдэх юм. ▶

ДЭЛХИЙ ДАХИНД

Их Британи ба ЕХ



Лондон хотын захирагч Борис Жонсон ирэх зургадугаар сард болох олон нийтийн санал асуулгаар Европын Холбооноос гарахын төлөө саналаа өгөхийг Их Британийн “The Telegraph” сонинд өгсөн ярилцлагадаа албан ёсоор уриалжээ. Тэрбээр ЕХ-ны төслийг өмнө дэмжиж байсан талаараа дурьдаад “Намайг 1989 онд Брюссельд очиход худалдааны саад тогторыг арилгах гэсэн сайныг санасан албан тушаалтнууд байсан” гэжээ. Гэвч одоо энэхүү төсөл тэр үеийнхээс танигдах аргагүй өөр болсон хэмээн хотын дарга Жонсон үзэж буй аж.

ЕХ-нд үлдэх эсвэл гарах хуваагдмал байр суурийн үндэс нь төвлөрөл болон бүрэн эрхт байдалтай холбоотой юм. Тэрбээр хэлэхдээ “ЕХ өөрийн оролцож буй бүх чиглэлд давуу байдлыг олж авдаг” гэв. ЕХ-г орхих хүсэлтэй британичууд тус холбоо хэтэрхий их дүрэм журамтай бөгөөд энэ нь тэр дундаа бизнест хүндрэл учруулж, Их Британид сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байгаа юм. Түүнчлэн тэдний үзэж буйгаар ЕХ-ны гол зорилго нь Европыг “Европын АНУ” болгож, улмаар ЕХ-ны Засгийн газрыг үндэсний засгийн газруудаас илүү давуу хууль эрх зүйн эрх мэдэлтэй болгох юм хэмээн үзэж буй аж. Харин ЕХ-д үлдэх хэрэгтэй гэж үзэж буй хүмүүс тус холбоог ЕХ-ны бусад улсуудад худалдаа хийхэд амар болгодог бөгөөд шилжин суурьшигчдын

урсгал залуу ажиллах хүч авчирдаг зэрэг тэдэнд олон ашиг тусыг өгдөг хэмээн үзэж байгаа юм. Их Британийн Ерөнхий сайд консерватив үзэлтэн Дэвид Камерон ЕХ-нд үлдэхийг дэмжиж байгаа ч хотын дарга Жонсон зэрэг түүний намын бусад гишүүд өөрсдийн байр суурийг илэрхийлж, бусдыг уриалан дуудах нь чөлөөтэй асуудал юм.

ЕХ-нд үлдэх байр суурийг дэмжиж буй Шотландын Үндэсний намын тэргүүн уг асуудлаар холбоотой мэдэгдэл хийхдээ хэрэв Их Британи ЕХ-ноос гарвал Шотланд санал асуулгаар Их Британиас тусгаар тогтнох асуудал бараг тодорхой болж магадгүй юм хэмээн анхаарууллаа. Ийм ч учраас Их Британийн ЕХ-ноос гарах санал асуулга ЕХ-ны энэ жилийн хамгийн чухал үйл явдал болж байгаа юм.

Бээжингийн агаарын бохирдол



Агаарын урсгалыг сайжруулж, агаарын бохирдолтой тэмцэх үүднээс Бээжин хотноо агааржуулалтын “коридорууд” байгуулагдах нь. Эдгээр коридорууд нь холбогдсон цэцэрлэгт хүрээлэн, гол горхиудаас бүрдэж байгаа бөгөөд агаарын урсгалд саад болж буй цөөхөн давхартай байшингууд болон хурдны замуудыг нураах аж. Хэдийгээр уг төсөлд тодорхой хугацаа заагаагүй байгаа ч 500 метрээс илүү өргөнтэй таван гол коридор болон хэд хэдэн жижиг коридорууд баригдах юм. Хятадын засгийн газар 2020 он гэхэд Бээжин хотын агаарын бохирдлыг 2013 оны түвшнээс 40 хувиар

бууруулах зорилго тавьж байгаа юм. Өнгөрсөн арванхоёрдугаар сард утааны анхны “улаан түгшүүр” зарлагдсанаас хойш агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлт нэмэгдсэн аж.

Хонконг дахь бослого



Хонконг хот Цагаан сарыг эсэргүүцэл жагсаалаар угтлаа. Цуст эсэргүүцэлийн гол шалтгаан нь эрх баригчдад Хонконгийн соёлын нэгээхэн хэсэг болох гудамжны хүнсний худалдаачдыг хөөх төлөвлөгөөт үйл ажиллагаа явуулснаар эхэлжээ. Эрх баригчид тайлбарлахдаа уг үйл ажиллагаа нь гудамжны хүнсний худалдаанд илүү чанга дүрэм журам баримталж эрүүл мэнд болон ариун цэврийг сахихтай холбоотой гэж тайлбарлаж байна. Хонконгийн худалдаа үйлчилгээний зүрхэн цэг хэмээн тооцогддог Монг кок дүүрэгт үймээний гол өрнөл явагдсан юм. Цагдаагийн байгууллага болон олон нийтийн хоорон дахь харилцаа 2014 онд болсон ардчиллын төлөөх “Шүхэрт хувьсгалын хөдөлгөөн”-өөс хойш муудаж байгаа юм. Уг үйл явдлаас хойш Хятадын эсрэг үзэл нэмэгдэж байгаа бөгөөд Мандаринаар дуулж буй гудамжны уран бүтээлчид болон эх газрын Хятад худалдаачдын эсрэг эсэргүүцэл ч нэмэгдсээр байна. Иймэрхүү эсэргүүцлүүд Хонконгод илүү хурцадмал байдал үүсэхийг зөгнөдөг. Их Британийн Хонконг дахь колончлолын үеийн далбааг зүүж, гар аргаар хийсэн зэвсэгтэй эсэргүүцэгчид цагдаа нарын эсрэг тэмцэх байдал улам

ихээр ажиглагдах болж байна. Эдгээр эсэргүүцэгчид Их Британийн далбааг зүүж байгаа нь англичуудад хайртайдаа биш харин Хятадын эрх баригчид болон Коммунист намыг үзэн ядаж буйгаа илэрхийлж буй юм.

Хөрөнгө оруулагчид Африкаас зугтаж байна

Саяхан л хөрөнгө оруулагчид маш ихээр зорьдог байсан Африкаас хөрөнгө оруулагчид олноороо дүрвэх боллоо. Унаж буй түүхий эдийн үнэ, Хятадын удаашрал болон бодлогын асуудлууд зэрэг нь хөрөнгө оруулагчдыг Африкийн хөгжиж буй зах зээлүүдэд хөрөнгө оруулах нь зөв эсэх талаар дахин бодоход хүргэж байгаа аж. Шинэ он эхэлснээс хойш Африкийн хамгийн том эдийн засаг болох Нигерийн үндсэн хөрөнгийн индекс 14 хувиар унасан нь нэг талаараа унаж буй газрын тосны үнэтэй холбоотой юм. Замбийн экспортын орлогын 70 гаруй хувийг зэсийн экспорт бүрдүүлдэг учир тус улс Хятадын эрэлтийн удаашралын нөлөөг хүчтэй мэдэрч байгаа бөгөөд тус улсын “S&P” индекс 45 хувиар буурчээ. Үүнээс гадна Ангол, Нигери болон Экваторын Гвиней зэрэг улсын экспортын орлогын 90 хувийг газрын тосны экспорт эзэлдэг. Сангийн менежерүүд хэлэхдээ Африкийн улсууд сүүлд болсон түүхий эдийн оргил үеийн давуу талыг ашиглаж, үйлдвэржилтэд царцуулж чадаагүйн улмаас хөрөнгө оруулагчид тус бүс нутгийг орхих болж байна гэж байгаа аж. Харин зарим нь чиг хандлагын эсрэг зогсож чадаж байна. Африкийн хамгийн төрөлжсөн эдийн засаг болох Кени болон дэлхийн какаоны топ үйлдвэрлэгч Зааны Ясан эрэг зэрэг улсууд хөрөнгө оруулагчдыг татаж чадсаар байна. ■

Газрын тос

Шинэ салхи



“Газрын тос ба Монгол Улсын эдийн засаг” хурал, 2016.02.04

Г.ОРХОН

Газрын тосны салбарт гэрэл аслаа. Эдийн засагт шинэ салхи салхилах нь. Энэ бол олон жилийн турш дуншсан дотоодод нефть боловсруулах үйлдвэр барихаар болсон тухай Засгийн газрын шийдвэртэй холбоотой нийгэмд түгээд буй сайн мэдээ.

Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолойг Хэнтий аймгийн өмнөд хэсэгт орших Бор-Өндөр суманд барих нь. Эл үйлдвэр жилдээ 2.3 сая тонн түүхий нефть боловсруулах хүчин чадалтай төдийгүй хамгийн багадаа 30 жил ажиллана гэж тооцоолж байна.

Жижиг ч гэсэн өгөөж өгнө

Өдгөө манай улс жилдээ 1.2 сая гаруй тонн шатахуун импортолж байгаа ч үүнтэй дүйцэхүйц хэмжээний түүхий нефть олборлож байна. Тиймээс дотоод дахь түүхий тосоо боловсруулан нефтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болчихвол шатахууны үнэ буурах боломж бий. Бид газрын тосны үнэ өндөр байх үед шатахууны төлбөрт жилд нэг тэрбум гаруй ам.долларыг хил давуулан “цацдаг” байсан бол ханш шалдаа буусан энэ үед ч багаар бодоход 500 орчим сая ам.доллар төлж байна. Аж үйлдвэрийн яамнаас нефтийн үйлдвэр ашиглалтад орсноор гадагш чиглэсэн валютын дээрх урсгалыг сааруулаад зогсохгүй валютын ханшийг 18-25 хувиар бууруулах боломжтой гэх

судалгааг гаргажээ. Ер нь гадагш урсдаг мөнгө дотооддоо эргэлддэг болох нь эдийн засгийн хамгийн том үр ашиг.

Харин энэ салбарт ажиллаж буй зарим хүн, эрдэмтэн судлаачид хоёр сая тоннын хүчин чадалтай үйлдвэр нь эдийн засгийн хувьд тийм ч их ашигтай бус гэдгийг сар шинийн баярын өмнөхөн болсон “Газрын тос ба Монгол Улсын эдийн засаг” сэдэвт хурлын үеэр дуулгасан. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Содном “Орон нутагт барих жижиг үйлдвэрүүд олигтой үр ашигтай байж чадахгүй. Сайн технологи ч нэвтрүүлж чадахгүй. Их ойрхон харж байгаа юм. Аль болох том хүчин чадалтай гүнзгий боловсруулалт хийх технологитой байх хэрэгтэй. Анхан шатны жижиг үйлдвэр баривал гарсан бүтээгдэхүүн нь шаардлага хангаж чадахгүй. Сүүлийн үеийн машин техникүүд их өндөр чанартай дизелийн түлш шаардаж байна шүү дээ” гэсэн. Тиймээс уг үйлдвэрт бусад салбарын орлооног татах тал дээр түлхүү анхаарах хэрэгтэйг тэд зөвлөсөн. Учир нь хүнд үйлдвэрийг дагаж жижиг, дунд үйлдвэр хөгждөг. Үүнийг бид наад зах нь Японы туршлагаас харж болох юм. Автомашин үйлдвэрлэгч “Тоёота” компанийг даган автомашины хаалганы бариул, жолооны хүрд, суудлын бүрээс зэргийг үйлдвэрлэдэг жижиг компаниуд гарч иржээ. “Сод Монгол” группын

ерөнхийлөгч Ц.Анандбазарын хэлснээр нефть боловсруулах үйлдвэрийг дагаад 40 үйлдвэр бий болдог аж.


Бор-Өндөрт барих нефть боловсруулах үйлдвэр нь эдийн засагт төвбанкны үүргийг гүйцэтгэхүйц чухал нөлөө үзүүлнэ гэж байгаа. Тус үйлдвэрийг барьснаар зах зээлд нийлүүлж буй валютын хэмжээ буурч, импортын бараа бүтээгдэхүүний үнэ буурна гэж тооцоолж. Ингэхээр инфляци нам түвшинд хадгалагдаж, эдийн засаг тогтворжих үндэс бүрдэх аж. Салбарын яамны мэргэжилтнүүдийн тооцоолж буйгаар уг үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 15 хувиар өснө. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 40 орчим хувиар, боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 2.5 дахин нэмэгдэнэ гэжээ. Мөн импортын хэмжээ 1.2 тэрбум ам.доллаараар буурч, улсын болон орон нутгийн төсөвт бүх төрлийн татвар хураамж хэлбэрээр жил бүр ойролцоогоор 350 сая ам.доллар төвлөрүүлэх нь. Үйлдвэр ажиллаж эхэлснээр орон нутагт 600 гаруй шууд ажлын байр шинээр бий болно гэж үзэж байна.

Тохироо

Нефть боловсруулах үйлдвэрийг барих шаардлага, цаг үеийн тохироо бүрдсэн гэдэгт салбарынхан тэр дундаа Монголын газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооныхон санал нэгдэж байна. Наандаж металлын үнэ буурч байгаа учир тоног төхөөрөмжийн үнэ буурч магадгүй. Энэ нөхцөлд хөдлөхөд буруудахгүй. Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат “Үнэхээр бид боловсруулах үйлдвэртэй болох цаг нь болсон. Эвлэлдэж нэгдээд, нэг зорилготойгоор энэ ажлыг хийчих юмсан гэх хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс байгаад баяртай байна. Манай улсын үе үеийн ерөнхийлөгч, ерөнхий сайдууд энэ ажлыг хийх гэж хичээж ирсэн. Цаг хугацаа, зах зээлийн нөхцөл байдал, боломж нь тэр бүр гараагүй байх. Харин энэ удаад эдийн засгийн нөхцөл байдал, боломж, өнөөдрийн нефтийн үнэ, өртөг нь Монголд боловсруулах үйлдвэр байгуулах цаг нь болжээ гэдэг дохиог өгсөн” хэмээв.



Харин салбарынхан Засгийн газар 2.3 сая тонн гэх тоог зоригтой тавьж чадсан гэж байх юм. Гэхдээ ийм хэмжээний хүчин чадалтай үйлдвэр барих боломжтойг үгүйсгэсэнгүй. Тэд Бор-Өндөрт барих үйлдвэрийн ▶

талаарх төрийн бодлогыг импортолдог, үйлдвэрлэдэг, экспортолдог гэж харж байна. Бяцхан тооцоолол хийе. Бидний хэрэглээ жилийн 1.2 сая тонн. Бор-Өндөрт уг үйлдвэр ашиглалтад орсноор 2.3 сая тонн түүхий газрын тос боловсруулна. Тэгэхээр дотоодын хэрэглээг бүрэн хангаад үлдсэн газрын тосыг экспортолж таарах нь. Аж үйлдвэрийн яамнаас зарласан импортыг орлох бодлого энд сая биелэлээ олж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн экспортод гаргах боломж бүрдэх нь гэж салбарынхан хүлээж сууна. Гэхдээ импортыг зуун хувь орлоно гэх хориг тавьж болохгүйг сануулав.



“Газрын тос ба Монгол Улсын эдийн засаг” сэдэвт олон улсын хуралд ОХУ-ын “Аргус медиа” компанийн ахлах шинжээч Анастас Гатунок ирж “Газрын тосны боловсруулах үйлдвэрлэл технологийн чиг хандлага” сэдвээр илтгэл тавьсан юм. Түүний ярьснаар нефть боловсруулах үйлдвэрийн технологи олборлолтыг илүү гүнд хийх, хүнд олборлолтыг багасгах талд чиглэж байна. ОХУ-ын нефть боловсруулдаг ихэнх үйлдвэр газар доорх хоолойгоор тээвэрлэлтийн асуудлаа шийддэг аж. Ингэхдээ зөвхөн түүхий эдээ татах биш эцсийн бүтээгдэхүүнээ ч мөн хоолойгоор зөөдөг гэв. Тэд энэ талаар маш олон тооцоо хийсний эцэст дамжуулах хоолой нь хамгийн хямд зардалтайг тогтоож, ийм сонголт хийжээ.

Газрын тосны ханш навс унасан энэ үед тус улсад үйл ажиллагаа явуулж буй нефтийн томоохон компаниуд газрын тосны бүтээгдэхүүнээ экспортлохоос илүүтэй олборлолтоос ашиг хүртэж байгаа аж. Бид шатахууны хэрэглээнийхээ 80-90 хувийг хойд хөршөөс тагаж буй. Хэрэв боловсруулах үйлдвэртэй болвол хоёр улсын газрын тосны салбар дахь өнөөгийн харилцаа зогсоно гэж ойлгож болохгүй. Хэдий Монголын түүхий нефтийн олборлолт 2020 он гэхэд 1.5 сая тоннд хүрч өснө гэж байгаа ч зөвхөн Бор-Өндөрт барих үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахад түүхий эд дутаж таарна. Тиймээс шаардлагатай түүхий эдээ Оросоос авах бүрэн боломж бий. Түүнчлэн үйлдвэр барих барилгын ажил, төсөл хэрэгжүүлэх тал дээр ОХУ-аас туршлага судлан хамтарч ажиллаж болох юм.



Харин урд хөршид нефть хэрэгтэй байгаа бөгөөд тэдний импортолж буй газрын тос 100 сая тоннд хүрчээ. Хэдий Монгол хоёр том зах зээлийн дунд



Тус үйлдвэрээс өмнө Дархан-Уул аймагт жилд хоёр сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай Японы хөрөнгө оруулалттай үйлдвэр барих төсөл байсан. Тус үйлдвэр түүхий эдээ ОХУ-аас татна гэж байсан бөгөөд энэ нь ялгаагүй хараат байдал хэвээр байна гэж үзэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаж зөвлөмж гарснаар уг ажил зогссон юм. Аж үйлдвэрийн яамны зүгээс цаашид говийн болон зүүн бүсэд нефть боловсруулах үйлдвэр барих төлөвлөгөөтэй байгаа аж. Монгол Улс өнөөдрийн байдлаар жилд нэг сая орчим тонн түүхий тос олборлож байна. Үүнд тохирсон жижиг оврын үйлдвэрүүдийг бүс нутгуудад тараан байршуулж барих нь эхний шатны арга хэмжээ гэж үзэж буй. Харин цаашид олборлолт нэмэгдэн жилд гурваас дөрвөн сая тонныг олборлох чадалтай болсон үед томоохон үйлдвэрүүдийг хөгжүүлэх нь зохистой гэж үзэж байгаа тухай Уул уурхайн яамны Түлшний бодлого, зохицуулалтын газрын дарга Л.Раднаасүрэн ярилаа.

байгаа ч энэ нөхцөлд боловсруулах үйлдвэр барих нь ашигтай гэж харж болох юм. Боловсруулах үйлдвэр байгуулснаар дотоодын хэрэглээ ч мөн нэмэгдэхийг Газрын тосны инженер, доктор Ц.Багмид яриу.

Үйлдвэрийг барих хөрөнгө оруулагчийг энэ оны хоёрдугаар улиралд багтаан сонгоно гэж буй. Хөрөнгө оруулагчид нь үндэсний компани оролцсон концерциум байх юм. Өөрөөр хэлбэл, нээлттэй тендер зарлах аж. Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат “Бид хөрөнгө оруулагчдаа дуудах цаг нь болсон. Хамгийн гол нь энэ үйлдвэр цэвэр үндэсний болоод хувийн хөрөнгө оруулалт дээр тулгуурлаж босно. Өөрөөр хэлбэл, төрийн оролцоо байхгүй. Төрийн оролцоо байх ч ёсгүй. Монгол улсын газрын тос боловсруулах үйлдвэр бол ▶

стратегийн ач холбогдолтой. Үндэсний хөрөнгө оруулагчид хамтраад энэ төслөө босгох ёстой. 2020 он гэхэд энэ төслийг дуусгах нь монголчуудын хувьд амин чухал асуудал” гэлээ. Ер нь нефть боловсруулах үйлдвэрийн дэлхийн жишиг ийм аж. Үйлдвэрийн барилгын ажил энэ оны дөрөвдүгээр улиралд эхлэх бөгөөд 2020 оны сүүлийн улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.

Нефть боловсруулах үйлдвэртэй зэрэгцүүлэн дамжуулах хоолой барьж түүхий нефтиэ Дорнод аймгаас татна. Дорнодын Тамсагаас татах дамжуулах хоолой нь 544 км үргэлжилнэ. Үүнийг Концессын гэрээгээр байгуулах аж.

Харин техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийг энэ оны хоёроос гуравдугаар улиралд хийхээр төлөвлөж. Салбарынхан ТЭЗҮ-ийг

олон хувилбараар гаргаж түүнээс Монгол Улсад хамгийн үр ашигтай үйлдвэрийг сонгохыг учирлав. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үр ашиг талаас нь хөрөнгө оруулалтаа нөхөх боломж бүрдсэн ийм сонголтыг хийх ёстой. Харин эдийн засагчид дэлхийн зах зээл дээрх үнэтэй дүйцэхүйц хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх ТЭЗҮ хийх хэрэгтэй гэж байна. ■

Усны менежмент

Үйл ажиллагааны сайн дурын кодекс итгэлцэл бий болгоно



Сайн дурын кодекс т найман компани нэгдэж гарын үсэг зурлаа

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Өмнийн говьд ажилладаг уул уурхайн компаниуд “Үйл ажиллагааны сайн дурын кодекс”-т нэгдэж, гарын үсэг зурах ёслол энэ сарын 4-нд болсон юм. Ёслолд найман компани оролцсоны дотор “Оюу Толгой”, “Эрдэнэс Таван толгой”, “Энержи Ресурс” зэрэг томоохон компаниуд багтаж байлаа.

Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) 2013 оноос хойш Өмнийн говийн бүс нутаг дахь усны менежмент болон орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр уул уурхайн салбартай хамтран ажиллажээ. Энэ хүрээнд “Өмнийн говийн бүсийн ус ба уул уурхай Дугуй ширээний хэлэлцүүлэг” төслийг хэрэгжүүлж уул уурхайн 10 гаруй компанитай хамтран ажиллаж орон нутгийн харилцаа, хамтын

оролцоотой усны хяналт шинжилгээний олон улсын шилдэг туршлага дээр суурилсан Усны нөөцийг хамгаалах, үр ашигтай ил тод хэрэглээг хөхиүлэн дэмжих, зорилготой “Үйл ажиллагааны сайн дурын кодекс”-ыг боловсруулсан нь энэ юм. Дээрх компаниуд тунхаг бичигт нэгдэж гарын үсэг үзэглэснээр оролцоонд суурилсан усны мониторинг боловсруулж хэрэгжүүлэх, усны хэрэглээ, усны чанар, усны түвшин зэрэг усны ашиглалттай холбоотой гол мэдээллүүдийг олон нийт, орон нутгийн иргэдэд ойлгомжтой байдлаар тайлагнах, хүнд үед усны хүртээмжийг сайжруулах, бэлчээрийн талбайд дэд бүтцийг сайжруулах зэрэг 19 үүргийг сайн дураараа хүлээж буй юм.

Энэ бүс нутагт олдсон усны нөөц 2600 литр/сек. Мөн тус бүс нутгийн

нийт усны хэрэглээ 664 литр/сек бөгөөд хорин жилийн дараа 1585 литр/сек болж өснө гэсэн судалгаа бий. Үүнд үндэслэн бүс нутагт орших уул уурхайн үйлдвэрүүд, Тавантолгойн дулааны цахилгаан станц, Даланзадгад, Цогтцэций, Ханбогд зэрэг томоохон хот суурин, үйлдвэрийн газруудын усны хэрэгцээг 2035 он хүртэл хангах боломжтой ажээ. Үүнд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Говийн хөрсний гүн дэх тогтсон усны нөөц нь гурван мянган жилийн турш хуралдсан юм. Эргэн нөхөгдөхөд мөн ижил хугацаа шаардлагатай. Тиймээс л Оюу толгой шиг 60-100 жил ашиглах төслүүдэд усны ариг гамтай хэрэглээ, ухаалаг менежмент хэрэгтэй байгаа юм.

Үйл ажиллагааны сайн дурын кодекс нь зөвхөн уурхайнуудын хэрэглээг зөв зохистой, хүртээмжтэй болгох бус, ▶

орон нутгийн иргэд болон мал амьтны усны хүрэлцээтэй байдлыг хангахад чиглэж байгаа юм. Өмнийн говьд ус бол дундын баялаг, мөн эрсдэл юм гэдэг ухагдахууныг уг кодекс дотроо агуулж буй. Үүнийг кодексыг боловсруулахад гар бие оролцсон 13 компани дор бүрнээ ухаарч байсны илрэл. Олон улсын санхүүгийн корпорацийн Монгол дахь суурин төлөөлөгч Туен Нгуен хэлэхдээ “Олон талын оролцоотой усны менежмент хэрэгжүүлэх нь компани болон орон нутгийн иргэдийн хооронд итгэлцэл бий болж урт хугацаанд үйл ажиллагаа явуулж, амжилттай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ. Компаниуд энэхүү тунхагт нэгдсэнээр усны менежментийн шилдэг арга технологийг нэвтрүүлэх, суралцах боломжийг олгосон, түүнийгээ хэрэгжүүлэх, үүргээ ухамсарлаж, асуудлыг анхаардаг болгосон шинэ дэвшил нэвтэрч байна” хэмээн кодексын ач холбогдлыг тодорхойлсон юм. Энд дурдаж буй олон талын оролцоо гэдэг нь компаниуд хооронд туршлага солилцож байхын дээр тэдний усны менежментэд иргэд хяналт тавьдаг, санал шүүмжлэл хэлдэг, гомдол гаргах боломжтой байх, түүнийг нээлттэй хүлээн авч эргэн хариу мэдэгдэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг тогтолцоог тус сайн дурын кодекс нэгдсэнээрээ компаниуд бий болгох юм.

Гарын үсэг зурах ёслолд хүрэлцэн ирсэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайханы хувьд уг кодекс нэгдсэнээр компаниудын өрсөлдөх чадварт сайнаар нөлөөлнө гэдгийг онцгойлон дурдсан. Ёслолын ажиллагаанд хүрэлцэн ирсэн компани, байгууллагын төлөөллүүдийн санал нэгтэй хэлж байсан нэг зүйл бол кодексыг боловсруулж олон компани нэгдэж, нэгдэхээ илэрхийлж байгаа нь “иргэд, компани хооронд илтгэлцэл бий болох нөхцөл бүрдлээ” гэдэг байв.

Бүс нутагт орших томоохон хот суурин, уурхай, үйлдвэрийн усны хэрэглээ (л/сек)

	2015 он	2035 он
Тавантолгойн уурхай	2.8	371.0
Ухаахудагийн уурхай	138.75	138.75
Тавантолгойн цахилгаан станц	0.0	38.0
Оюутолгойн уурхай	510.5	918.0
Даланзадгад хот	12.0	70.0
Ханбогд сумын төв	0.3	34.9
Цогтцэций сумын төв	0.2	15.0

“Кодексын дагуу компаниудын тайланг олон нийтэд мэдээлнэ”



“Өнөөдөр төслийн хамгийн оргил үе тохиож байна. одоо гол ажил болох кодексийг хэрэгжүүлэх, үр дүнг нь хүртэх зэрэг эхлэнэ” хэмээн уг төслийг удирдсан Аржун Балла гарын үсэг зурах ёслолын үеэр хэлсэн юм. Түүнээс дараах тодруулгыг авлаа.

-Кодекст нэгдсэн компаниудад шинээр ямар шаардлага тавигдах вэ. Тэдний дотор усны менежментээрээ тэргүүлэгч компаниуд ч байна?

-Компаниудын хувьд нэмэлт шаардлага гэвэл хоёр үндсэн зүйл хөндөгдөж байна. Нэг нь бол орон нутгийн иргэдтэй оролцоонд суурилсан усны мониторинг боловсруулах юм. Зарим компанийн хувьд оролцоонд суурилсан мониторинг одоогоор хийхгүй байгаа. Нөгөөх нь устай холбоотой усны хэрэглээ усны чанар, усны түвшин зэрэг тоон үзүүлэлтүүдийг хүмүүст ойлгомжтой дөхөм аргаар тайлагнаж үүргийг кодексын дагуу компаниуд хүлээж байгаа. Хэдийгээр хуулийн дагуу байгаль орчны тайландаа энэ талаар мэдээлдэг боловч олон нийтэд хүртээмж муутай байдаг. Үүнээс гадна зарим компанид иргэдээс гомдол хүлээн авах тогтолцоогүй явж ирсэн. Үүнийг кодекс нэгдсэн бүх компаниуд бий болгохоор тусгасан.

-Монголоос өмнө өөр улсад үйл ажиллагааны кодексыг боловсруулж байсан уу. Яагаад заавал Монгол гэж?

-Монгол бол Олон улсын санхүүгийн корпорацийн хувьд усны менежментийн чиглэлээр кодекс боловсруулж буй анхны улс орон. Харин одоо Перу болон Колумбид кодекс боловсруулахаар ажиллаж байна. Гол шалтгааны нэг

бол ОУСК нь Оюу Толгой төслийн зээл олгогч байгууллагын нэг юм. Оюу Толгой бол Монголын хамгийн том компаниудын нэг бөгөөд бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг бусадкомпаниуд ч үйл ажиллагаа нь усаас хамааралтай байгаа. Тэд бүгд дуу нэгтэйгээр ус бол том асуудал гэдгийг илэрхийлж байсан юм. Бид өмнийн говийн бүсэд үйл ажиллагаа явуулдаг Эрдэнэс Монгол, Энержи Ресурсэс, Терра Энержи зэрэг компаниудтай хамтран ажилладаг. Кодексийг боловсруулахдаа ICMM (Олон улсын уул уурхай болон металын зөвлөл)-ийн усны менежментийн ерөнхий зарчмын загварыг ашигласан. Тэдний хувьд усны менежментийн чиглэлээр олон жилийн туршлагатай, иймэрхүү баримт бичиг боловсруулах талаар чадавхижсан байгууллага. Гэхдээ дотор нь орсон заалтуудыг монгол компаниуд өөр хоорондоо санал солилцож, нөхцөл байдалдаа тохируулж гаргасан.

-Монголын жишээ, ICMM-ийн туршлага хэр зөрүүтэй байсан бэ?

-Мэдээж хэрэг улс орон бүр онцлогтой. ICMM-ийн баримт бичиг бол илүү ерөнхий, суурийг нь тавьж өгснөөрөө ач холбогдолтой юм. Газар нутаг, гидрогеологийн тогтоос гадна, улс орон бүр өөрийн соёл уламжлалтай. Энэ соёлын харилцааг анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал өмнө дурдсанчлан кодекс уул уурхайн компаниуд малчдын усан хангамжийг хамгаалахад тодорхой үүрэг хүлээх заалт оруулж өгсөн.

-Кодекст нэгдсэн компаниудын хувьд том, жижиг олон түвшнийх байна. Кодексийг боловсруулах явцад тэдний хооронд ямар нэгэн зөрчил гарч байсан уу. Яаж зохицуулсан бэ?

-Компаниуд хооронд зөрчил гэхээр зүйл гарч байгаагүй л дээ. Гэхдээ санал бодлын хувьд нэлээд ялгаатай тал бий. Тухайлбал, жижиг компаниуд том компаниудыг гүйцэх хэмжээний санхүүгийн эх үүсвэргүй. Тиймээс кодексийг боловсруулахад энэ хүчин зүйлийг бодож үзсэн. Кодекс хэдийгээр тийм том баримт бичиг биш ч 18 сарын хугацааг зарцуулсан гол шалтгаан нь энэ. Аль болох уян хагана байхыг хичээсэн. Бид кодексийг аль болох бодит байдалд нийцсэн, орон нутгийн иргэдийн санал, ▶

хүлээлтэнд нийцсэн байх ёстой гэдэг зарчим баримталсан. Хэт хагуу, эрх зүйн акт шиг хийх юм бол компаниуд сайн дураараа нэгдэхгүй байх магадлалтай.

Дээрээс нь Монгол Улсын хувьд байгаль орчны хамгааллын чиглэлээр хууль эрхзүйн орчин сайтай. Түүнчлэн компаниуд нь бүгд бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа, усыг хамтын баялаг, зохистой шийдэхгүй бол эрсдэл болно гэдгийг ухамсарласан, энэ чиглэлээр ажиллах хүсэлтэй байгаа болохоор идэвхтэй оролцож, нэгдэж байгаа.

ОУСК-ийн зүгээс компаниудын үйл ажиллагааны тайланг хүлээн авч мэдээллийн сан үүсгэхээр төлөвлөж байгаа. Ингээд компаниуд маань зарчмаа хэр баримталж, ямар үйл ажиллагаа явуулсан бэ гэдгийг эргэж олон нийтэд энгийн ойлгомжтой байдлаар хүргэх ажлыг хийнэ.

-Санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэж

байгаа вэ?

-Гол санхүүжүүлэгч нь Канадын Засгийн газар ба Өмнийн говийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд. Мөн “2030 Усны нөөцийн бүлэг”, “Европын сэргээн босголт хөгжлийн банк”, “Уул уурхай, төмөрлөгийн олон улсын зөвлөл” техникийн экспертиз болон санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Төслийн хүрээнд улирал бүр компаниудтай дугуй ширээний уулзалт зохион байгуулж байна. Бас орон нутгийн иргэд, Засгийн газрын мэргэжилтнүүд, хэвлэл мэдээллийнхэнд гэх зэрэг бүлэг хүмүүст зориулж гүний ус, усны мониторингийн талаарх ойлголт өгөх сургалт зохион байгуулдаг. Төсөл гурван жил үргэлжлэх юм. Нийт санхүүжилтийн дүн нь ойролцоогоор 700 мянга орчим ам.доллар болоод байна.

-Энэ удаад өмнийн говийн бүс нутгийн хүрээг хамарч байна. Улсын хэмжээнд кодексыг мөрдүүлэх төлөвлөгөө бий юу?

-Говийн бүст илүү анхаарч байгаа нь хэт өргөн хүрээг хамарвал бодитой үр дүн гарах нь бага байх болов уу гэдэг үүднээс тодорхой хүрээнд гол анхаарлаа хандуулж байгаа юм. Гэхдээ компаниуд өөрсдөө судалж, танилцаад нэгдэх сонирхлоо илэрхийлэх юм бол бид эхлүүлсэн ажлаа илүү өргөжүүлэхийг хүснэ. Олон улсын санхүүгийн корпорацийн хувьд энэ төслийг байнга авч явахгүй. 2017 оны зургадугаар сард төслийн хугацаа дуусна. Тэр үед кодексийн дагуу компаниудын тайлан хүлээн авч олон нийтэд мэдээлдэг, бүрдсэн мэдээллийн санг улам баяжуулж авч явах дотоодын байгууллагад ажлаа шилжүүлж, цааш үргэлжлүүлэхэд нь хамтарч ажиллана. ■

Сонголт

Нэг Хятад, нэг Тайвань

Б.ЭНХЦЭЦЭГ

Бүх талаараа Тайвань тусгаар тогтносон улс байх эрхтэй. Гэхдээ Цай Ин Вэн улс нь харахан өнөөдөр тийм болчихож чадахгүй гэдгийг ойлгох ёстой болж байна

Хятадыг би энэ хуруугаараа чичлэнэ хэмээн долоовоор хуруугаа гозойлгон орилж байсан Цай Ин Вэнийг ерөнхийлөгч болсон гэх мэдээ ил болмогц сэтгэлээ барьж ядах маш олон тайвань хүн баярын нулимс унагасан нь энэ сонгуулийн үр дүнгийн тайлал.

Өрсөлдөгчдөө хол орхисон Цай Ин Вэн болон түүний намын сонгуулийн ялалт нь эргэлзээгүй үнэхээр гайхам байв. Кампанит ажлын байлдан дагуулалт, залуу сонгогчдын оролцоо, хүч чадлын алгуур шилжилт, улс төрийн угшилгүй гэр бүлээс гаралтай Азийн анхны эмэгтэй ерөнхийлөгч гээд магтах, тодотгох зүйл ихтэй сонгууль нэгдүгээр сард Тайваньд зохион байгуулагдсан. Дарангуйллын засаглал нь төлөвшсөн ардчилал руу ийнхүү алхан орж чадлаа. Нэг хүнд ногдох орлогын хэмжээгээр дэлхийд 33 дугаарт жагсдаг мөн Португал, Грекээс харьцангуй баян энэ улс тогтвортой тогтолцоотой, сүрдмээр чинээлэг.

ТОВЧХОН



- **УЛС ТӨР** Тайвань нь 1990 оны эхээр ардчилал руу шилжихээс өмнө нэг намын тогтолцоотой байсан
- **ЭДИЙН ЗАСАГ** Компьютерийн хэрэгслийн гол үйлдвэрлэгч: Тайванийн бүтээгдэхүүний гол экспортын зах зээл нь Хятад
- **ОЛОН УЛС** Тайвань нь цөөн хэдэн дипломат холбоо сүлбээтэй: Хятадтай тогтоосон харилцаа 2008 оноос хойш сайжирсан ч тусгаар тогтнолыг дэмжигч Цай Ин Вэн ерөнхийлөгчөөр сонгогдсноор хүндрэлүүдтэй тулгарч байна

Манай “Mongolian Economy” сэтгүүлийн Монгол дахь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхтэйгээр гаргасан “The Economist” сэтгүүлийн “Дэлхий 2016” хөтөч дугаарын “Хятад хүчин зүйл” нийтлэлд Цай Ин Вэн болон түүний Ардчилсан дэвшилтэт намыг ялах нь гарцаагүй хэмээн хэлсэн нь ийнхүү биеллээ оллоо. Цаашлаад тус нийтлэлд “Ардчилсан дэвшилтэт намын ялалт нь БНХАУ-ын “Нэг Хятад” бодлого бүтэлгүйтэж байгааг тодотгоно” гэж бичсэн нь мөн л байгаа онох замдаа ороод байна.

Шавилхан биедээ ахадсан гэмээр үүрэг хариуцлага өвөртөлж буй 59 настай Цай Ин Вэнийг дэлхийн хэвлэл мэдээлэл “Бяцхан Ин” хэмээн хочилж байна. Есөн хүүхэдтэй гэр бүлд төрсөн тэрбээр Тайванийн өмнөд хэсгийн Пинтун хэмээх тосгонд өссөн бөгөөд улмаар өсвөр насандаа хотын хүүхэд болжээ. Цай Тайванийн Үндэсний их сургууль, цаашлаад Корнелл, Лондоны Эдийн засгийн сургуулийг тус тус дүүргэжээ. Түүнийг өмнөх ерөнхийлөгчдөөс илүү өндөр боловсролтой, өргөн хүрээнд сэтгэж асуудалд ханддаг гэдэг.

Тайванийг эх нутагтайгаа эргэж нэгдэх ёстой тэрслүү бүс нутаг агаад шаардлагатай тохиолдолд хүчээр нэгтгэнэ гэдэг Хятадаас бусад бүх хөрш нь хатагтай Цайд яаран баяр хүргэсэн. Хятад Тайванийг өөрийн нэг хэсэг хэмээн зүтгэдэг бол Тайвань иргэний дайнаас хойш өөрийгөө жинхэнэ Хятад бол бид гэсээр ирсэн. Хатагтай Цайгийн өөрийнх нь нам ч албан ёсны ▶

Хятад Ард Улс /ROC/

Нийслэл: Тайбэй

Хүн ам 23.3 сая**Газар нутаг** 36.188 ам. км**Гол харилцах хэл**

Мандарин Хятад (албан ёсны) Мин Нан Хятад (Тайвань хэл), Хакка

Дундаж наслалт

76.2 жил (эр) 82.7 (эм)

Мөнгөний нэгж

Шинэ Тайвань доллар

ДНБ

529.6 тэрбум \$

Нэг хүнд ногдох ДНБ

22.598 \$

Эх сурвалж: НУБ, ДБ

тэтгэврийн тогтолцоог хямралаас гаргах, цалингийн доод түвшинг нэмэгдүүлэх зэрэг юм.

Бардамналаа залги хатагтай Цай

Хатагтай Цай нэгмөсөн Хятадтай харилцах харилцаагаа үл ойшоож чадахгүй. Учир нь Хятад өөрсдөө түүний ерөнхийлөгчийн эрх ямбыг тодорхойлолцож хамтран барилцахаар дөхөж мэдэх. Хятад бол Тайванийн хамгийн том худалдааны хамтрагч. Хатагтай Цай худалдаа, хөрөнгө оруулалтын хэлцлүүд дээр ил тод байдлыг бий болгоно гэж бардам амласан.

Урьдын КМТ намын нууцлаг байдал хоёр жилийн өмнө тэмцэгчдийг тэсрэхэд хүргэж, нөхөрсөг Ма Ен Жөү ерөнхийлөгчийн нэр хүндийг үлэмж доош чирсэн. Харин дараагийн Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх түүний залгамжлагч намынхаа ард байдаг нууцлаг эрхмүүдэд гэрээ хэлцлүүд ил тод байх нь тус намыг тайваньчуудыг дахин байлдан дагуулахад хүргэх талтайг ойлгуулах арга замыг олох ёстой болж буй. Харин хатагтай Цайгийн Америк хөтөлгөөтэй чөлөөт худалдааны бүсэд гишүүнээр элсэх амлалтын тухайд харах юм бол тэрбээр Хятадыг мөн тус клубэд хослон элсэхийг уриалах хэрэгтэй болж буй. Хятад Тайвань хоёр Дэлхийн худалдааны байгууллагад 2002 онд яг энэ байдлаар элсэн орсон билээ.

Эрт, орой Хятад улсын зүгээс Цайд “нэг Хятад” хэмээх тус хоёр улс өөрсдөө ч хувь, хувьдаа ямар утгаар ойлгох вэ гэдэг дээр зөрөлддөг асуудалд хариулт нэхнэ. Өөрсдийгөө хятадууд бус тайваньчууд гэх эх оронч үзэл давамгайлж буй энэ үед Цайд хариулт олох амаргүй байх болов уу. Гэхдээ тэрбээр өмнөх ерөнхийлөгчийн үед эхлүүлсэн хоёр улсын учраа олж зохицох оролдлыг үргэжлүүлэх ёстой гэж мэргэжилтнүүд үзэж байна. Тавдугаар сард ажил үүргээ хүлээж авах ёслолынхоо өмнө тэрбээр ямар ч урьдчилсан нөхцөл хүлээлтгүйгээр Си Жинпингтэй уулзах санал гаргаж болох юм. Гэхдээ ингэж уулзалт түүнээс гарах үг өгүүлбэр их л тэвчээр заасан шинжтэй байх хэрэгтэй болно. Өнөөдрийн хүний эрхийг хязгаарлагч, тэмцэгчдийг боомилгогч Хятад илүү чөлөөт улс болон хувьсах үед л Тайванийн цаасан дээрх тусгаар тогтнол бодит хөрсөн дээр бууж ирэх болов уу. Хятад чөлөөт ардчилсан улс болно гэдэг боломжгүй гэх хүмүүс олон. Гэхдээ Тайвань дөнгөж сая боломжтой гэдгийг харуулчихлаа. ■

тусгаар тогтнол гэсэн тэмүүлэлтэй. Шинэ ерөнхийлөгч Тайванийн хүсэл тэмүүлэл болон түүний сонголтуудыг түүх боомилж буйг ойлгох ёстой. Ингэхгүй аваас Тайванийн ирээдүй болон бүсийн энхтайвны асуудалд амаргүй байдал үүсэх болно.

1949 оны Хятадын иргэний дайны үед Хятадын Коммунист нам Хятадын гол газар нутгийг эрх мэдэлдээ оруулж БНХАУ-ыг байгуулсан. Харин тухайн үеийн ялагдсан тал болох Хятад Ард улсын үндсэрхэг үзэлтнүүд Тайвань руу зугатаж тэндээ Засгийн газар байгуулж, өөрсдийгөө хууль ёсны эрх бүхий Хятад улс гэж үзэх болсон нь өдийг хүртэл түүхэн маргааныг дагуулсаар ирсэн.

Хатагтай Цайд саналаа өгсөн тайваньчуудын ихэнх нь “Нэг Хятад” гэх асуултад хариулна гэдэг үүднээс нь бус амьдралынх нь түвшинг сайжруулна гэдэг утгаараа түүнийг сонгосон. 2008 оноос өмнө 70 жил төр барьсан Үндэсний нам Куоминтаныг /КМТ/ төвийн тоглогчийн байр сууриас түлхсэн Ардчилсан Дэвшилтэт нам /АДН/ нь тусгаар тогтнолоо бүрэн зарлахын төлөө зүтгэдэг. Энэ намыг хоёр дахь удаагаа төрд залж, намын тэргүүнийг ерөнхийлөгчийн суудалд суулгана гэдэг тайваньчууд Бээжинг өөрсдөөсөө хол байлгах сонголт хийсэн гэсэн үг.

2008 оны ерөнхийлөгчийн сонгуульд АДН нь хүндхэн ялалттай анх удаа нүүр

тулсаны дараа худалдааны хуулиар мэргэшсэн “номындуу” Цай намын даргаар орж ирсэн билээ. Үүнээс хойш КМТ намын үед хавчигдаж байсан хүний эрхийн идэвхтэй тэмцэгчдийн байгуулсан АДН орон нутгуудад өөрсдийгөө харуулж, нэр хүнд нь өсч эхэлсэн билээ. Улс төрийн үзэл суртлаараа бус авьяас чадлаараа КМТ-ын 70 жил цоожилж ирсэн хаалгыг онгойлж чадсан юм. Танил тал, мөнгөн дээр бий болж, үүн дээрээ тогтож ирсэн аварга механизм КМТ цаашлах замгүй болж, орчин үетэй хөл нийлүүлэх замаар өөрсдийгөө дахин нээх, шинэчлэх шаардлага ургасан. Өнгөрсөн нэгдүгээр сард болсон ерөнхийлөгчийн сонгуульд КМТ-ы нэр дэвшигч 31 хувийн саналтай байсан бол АДН-ын Цай Ин Вэн 56 хувийн санал авч чадсан.

Хуучин эрх баригч асан КМТ намтай харилцахдаа илүү таатай ханддаг байсан Хятадын Коммунист намд дээрх үр дүн тааламжгүй байсан нь илэрхий. Гэхдээ ядаж л хятадууд юу юугүй тачигнаад, үүнийгээ илтгээр илэрхийлсэнгүй. “Ерөнхийлөгч Си Жинпинд хатагтай Цай өөрийнх нь гол анхаарал хандуулж буй талбар нь хоёр улсын хоорондох асуудлыг хүндрүүлэн тэнцвэрт байдлыг алдагдуулах бус дотоодынхоо асуудлыг шийдэх гэдгийг сайн ойлгуулах хэрэгтэй” хэмээн “The Economist” сэтгүүл бичжээ. Дотоодын асуудлууд гэдэг нь тухайлбал хямд өртөгтэй орон сууц бий болгох,

Статистик

2016 оны нэгдүгээр сарын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулав.



Макро эдийн засгийн үзүүлэлт, 2016 оны нэгдүгээр сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Үзэл бодол

Жинхэнэ мега төслүүд



Л.ХАНГАЙ

Сүүлийн үед манай зарим улс төрч, эдийн засагчид мега төсөл гэж их ярих, бичих боллоо. Жишээлбэл, Таван толгойн нүүрсний ордыг түшиглэн барих болон Нийслэлд барих V дулааны цахилгаан станцуудыг мега төсөл гэж нэрлэж байна. Эдгээр төсөл нь манай орны хувьд гарцаагүй том төслүүд, гэхдээ зөвхөн Монголын мега төслүүд гэж хэлж болох байх. Харин олон улсад тогтсон практикаар бол тухайн улс, бүс нутгийн хөгжилд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх, хэдэн тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардсан төслүүдийг ийнхүү нэрлэдэг юм билээ.

Манай орны хувьд бол хоёр хөрш гүрэнтэй буюу ОХУ, БНХАУ-тай холбоотой дэд бүтцийн төслүүд жинхэнэ мега төслүүд юм. Дэд бүтцийн төслүүд нь өртөг өндөртэй, тэдгээрийг бүрэн босгоход урт хугацаа шаардлагатайгаас гадна олон арван жил, тэр ч бүүхэл хэдэн зуун жил ч ашиглагдаж улс орон, бүс нутгийн амьдралд чухал нөлөө үзүүлдэг, бүр тодруулбал геостратегийн шинжтэй байдгаараа онцлогтой. Петербург-Москвага холбосон төмөр замыг найман жил барьж 1851 онд, 9300 километр урттай Транссибирийн төмөр замыг 1891-1903 онд буюу 12 жил барьж ашиглалтад оруулснаас хойш одоо хүртэл ашиглагдаж байгаа бөгөөд цаашид ч удаан хугацаанд ашиглагдаж таарна. Эдгээр төмөр замгүйгээр Орос орныг төсөөлөх аргагүй. Мега төслүүдийн орчин цагийн тод жишээ гэх юм бол Орос, Хятадыг холбох хийн болон нефтийн хоолойн төслүүд байна. Мөн сүүлийн үед “Шинэ торгоны зам”, “Эдийн засгийн коридор”, “Талын зам” гэх мэт нэртэй цогц төслүүдийн талаар

ярих болсныг онцлох хэрэгтэй юм.

Ингээд манай оронтой холбоотой ямар мега төслүүд байж болох вэ гэдгийг авч үзье.

- Төмөр зам. Хоёр хөршийг холбосон шинэ төмөр зам барих, одоо байгаа “Улаанбаатар” төмөр замыг шинэчлэх (хос замтай болгох, цахилгаанжуулах) төслүүдийг юуны өмнө дурьдах хэрэгтэй байх (тодорхой ордуудыг ашиглахтай холбоотой учраас Таван толгой, Нарийн сухайтаас улсын хил хүртэлх төмөр замуудыг энд орохгүй гэж бодож байна.)

Төмөр зам барих, шинэчлэхэд хамгийн чухал нь тээвэрлэх ачаа, ачааны урсгал байгаа эсэхийг тодорхойлох явдал юм. Зөвх ачаа нь жилд 30-40 сая тоннд хүрсэн тохиолдолд төмөр замыг хос болгох, 100 сая тонн хүрсэн тохиолдолд цахилгаанжуулсан хос зам болгох жишээтэй. Иймээс “Улаанбаатар” төмөр замыг хэзээ хос замтай, хэзээнээс цахилгаанжуулсан хос замтай болгох нь ачааны урсгалаас хамаарна. Уг төмөр замын хувьд хамгийн ашигтай нь Орос-Хятадын хоорон дахь транзит тээвэр учраас түүнийг нэмэгдүүлэхийн тулд манай нутгаар тээвэрлэх болон хилийн боомтууд дээр зогсох хугацааг багасгах, дээр нь өрсөлдөж чадахуйц уян хатан тарифтай байх чиглэлээр анхаарч ажиллах хэрэгтэй байгаа юм. Ингэснээр ачаа илгээгч, хүлээн авагчийн сонирхол бий болж улмаар өрсөлдөх чадвар нь нэмэгдэнэ. ОХУ болон БНХАУ-ын хоорондын бараа эргэлтийг 2020 он гэхэд 200 тэрбум ам.долларт хүргэнэ гэж байгаа. ОХУ-аас мэдээж байгалийн хий, нефть голлон нийлүүлж таарна, гэхдээ цаана нь байгалийн баялгаас гадна мод, бордоо зэрэг овор ихтэй

ачаа нийлүүлдэг тул тэдгээрийг гарцаагүй төмөр замаар тээвэрлэх болно. Харин БНХАУ-аас ОХУ болон Европын орнууд руу гол төлөв аж үйлдвэрийн болоод хүнсний бараа бүхий чингэлгүүд тээвэрлэдэг. Чухам эдгээр бараа ачаанаас л манай нутгаар тээвэрлэх хэмжээг нэмэгдүүлэхийг эрмэлзэх нь чухал. Оросууд Хятадаас Европ руу чиглэсэн ачааг Монголын нутгаар тээвэрлэх сонирхолтой гэж бодож байна. Учир нь, манай нутгаар тээвэрлэж Транссибирийн төмөр замд хүргэснээр түүний ачаалал нэмэгдэхээс гадна “Улаанбаатар” төмөр зам нь хоёр орны хамтарсан аж ахуйн нэгж.

“Улаанбаатар” төмөр замыг шинэчлэх төслөөс гадна Монгол орны баруун, зүүн хэсгээр хоёр хөрш орныг холбосон төмөр зам барих төслүүд яригддаг. Манай орны баруун хойд хэсгээр хиллэдэг ОХУ-ын Тувад сайн чанарын чулуун нүүрсний томоохон орд бий. Оросууд уг ордоос нүүрсийг БНХАУ руу гаргах талаар нэлээд идэвхтэй ярьж, судалж байна. ОХУ-ын Кызыл хотоос манай Улаангом, Ховд, Булганыг дайруулаад Хятадын Өрөмч хот хүртэл 1800 километр төмөр зам барих урьдчилсан ТЭЗҮ хийсэн байна лээ. Үүнээс Монголын нутгаар өнгөрөх урт нь 800 километр. Мөн Кызылээс Эрдэнэт хүртэл төмөр зам тавих тухай бас яригдаж байна. Өнөөдрийн байдлаар “Northern Railways” компани Эрдэнэтээс Овоот хүртэл 547 километр зам барих зөвшөөрөл аваад энэ онд ажлаа эхлүүлэхээр бэлтгэлээ хангаад байна. Хэрэв Овоот хүртэл төмөр зам тавигдах юм бол Монгол-Оросын хилийн Арцсуурь боомт хүртэл 230 километр, цаашаагаа Кызыл хүртэл 300 гаруй километр юм. Кызыл-Эрдэнэтийн төмөр зам тавигдвал манай “Улаанбаатар” төмөр замын ачаалал үлэмж нэмэгдэх сайн талтай. Харин зүүн чиглэлийн замаар ямар хэмжээний ямар ачаа тээвэрлэх нь одоогоор тодорхойгүй байна.

- Автозам. Монголын “Chinggis international Group” нэртэй компани Алтанбулагаас Замын-Үүд хүртэл, өөрөөр хэлбэл манай нутгаар дайруулан Орос-Хятадыг холбосон хурдны авто зам барих төсөл боловсруулаад байна. Мянга гаруй километр урттай уг замын нийт өртөг нь 10-12 тэрбум ам.доллар байх юм гэсэн. Хэрэв энэ төсөл хэрэгжиж эхэлбэл яах аргагүй мега төсөл болно. Энд харин хурдны авто зам ▶

Дижитал эдийн засаг нь хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний өөрийн өртөг, хуваарилалтын талаарх бидний ойлголтыг эрс өөрчилж, эдийн засгийн өсөлт, баялаг болоод ажил эрхлэлтийг эрс өргөжүүлэх, шинээр ажлын байрыг буй болгох гол хөдөлгүүр гэж Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (APEC) үйл явц онцлон тэмдэглэсэн байна. 2013, 2015 оны Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын салбар хуралдаанаар «e-World: Towards Globalization» «The Future of the Digital Economy» сэдэвт олон улсын томоохон хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Энэ үеэр


үйлдвэрлэлийн бодит бүтээмжийг дараагийн түвшинд буй болгох болно” гэжээ. Аж үйлдвэрийн дөрөв дэх үеийн хувьсгалын гол тулгуур нь мэдээллийн технологи, дижитал эдийн засаг юм.

Олон улсын эдийн засагт дижитал эдийн засаг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж өндөр технологийн үйлдвэр, олон улсын тээвэр, авто машин болон программын удирдлагатай суурь машины үйлдвэр, олон улсын төлбөр тооцоо, олон улсын банк, санхүү, хөрөнгийн миграци, хөрөнгийн бирж бүхэлдээ дижитал системд суурилж байна.

“Korea Telecom”-ын мэдээлснээр өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд тулгуурласан мэдээллийн суурь

бизнесийн хувьсгал ажлын байрны зах зээлийг эрс өргөжүүлж, нэмэгдсэн өртөг илүү өндөр шингээсэн бизнес, ажил үйлчилгээг буй болгов. Цахим худалдаа буюу e-business олон улсын бизнес болон өдөр тутмын худалдаанд өргөн нэвтэрлээ. Өндөр хурдны сүлжээнд суурилсан on-line эмнэлгийн үйлчилгээ амьдралын чанарыг эрхгүй өөрчилж буй ажээ. Тийнхүү шинэ мянганы эрин үеийн эхнээс e-society-г байгуулж байгаа ажээ.

АНУ-ын ҮНО (GNI-Gross National Income)-д эзлэх дижитал эдийн засгийн байр суурь тасралтгүй өсөн нэмэгдсээр байна. 2013 онд АНУ-д дижитал эдийн засгийн салбарт 300 тэрбум ам. долларын бүтээгдэхүүн, үйлчилгээг буй болгосон байх бөгөөд ойрын 10 жилд энэ үзүүлэлт 6.1 их наяд ам. доллараар хэмжигдэх юм. McKinsey and Co-гийн судалгаагаар АНУ-ын 10 доллар тутмын нэг нь биет мөнгөн хэлбэрт байгаа бөгөөд үлдсэн ес нь цахим хэлбэртэй байдаг байна. АНУ-ын глобал бодлогод эдийн засгийн үүрэг эрс нэмэгдэж байгааг онцолж гадаад бодлогоо тодорхойлохдоо: e-economics of power буюу хүчний эдийн засаг, power of e-economics буюу эдийн засгийн хүч гэсэн хоёр зарчмыг баримталж байна. Хэнд хүч чадал (мэдээж мэдлэг болон технологигжсон эдийн засаг) байна тэнд манлайлал байдаг нь нэн тодорхой.



тэмдэглэж байсан гол санал дүгнэлт бол “Дэлхий ертөнц дижитал хувьсгалын үр дүнд үйлдвэрлэл технологийн хөдөлгөгч хүч, хуваарилалт болон кибер ертөнцийн үйл явцыг хувирган өөрчлөөд зогсохгүй хүмүүсийн өдөр тутмын амьдралын чанар, хэв маягийг ч үндсээр нь өөрчилж байна”, «Глобал эдийн засаг, үйлдвэрлэлийг үндсээр нь өөрчилж буй гол хүчин зүйл, динамик нь e-revolution болж байна», “e-manufacturing гэдэг нь мэдээллийн технологид суурилсан e-моделиар жолоодон тухайлбал, аварга том цахилгаан станцын үйлдвэрлэлийг ч энэхүү хувьсгалын үр дүнд кибер орчинд буй болгосон цагт, үлэмж том

бүтэц, дэд байгууламжийг цогцоор нь бүрдүүлж байгаа нь хүмүүсийн амьдралын чанарыг үндсээр нь өөрчилж байна. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд интеграцлагдсан төрийн институци e-government-ийг нэгэнт буй болгож, энэ нь хамгийн хурдан шуурхай засаглалын үйлчилгээг иргэдэд санал болгож байна. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд холбогдсон дунд, их, дээд сургууль өндөр зэрэглэлийн чанартай e-education тогтолцоог буй болгожээ. Жижиг, дунд үйлдвэрлэгчид дижиталчлагдсан системд холбогдон e-commerce-г суурилсан b-to-b-гийн (business-2-business) гарцтай болсон. Мэдээллийн технологид үндэслэсэн

Швед, Сингапур дижитал эдийн засагтай орнуудын хамгийн хүчтэй өрсөлдөгчид гэдгийг 2015 оны Дэлхийн эдийн засгийн форумын салбар хуралдаанд танилцуулсан судалгаа харуулж байна.

Тиймээс Монгол Улсад дижитал эдийн засгийн хөгжлийн шинэ чиг хандлагын судалгаа, дүн шинжилгээ нэн чухал тулгамдсан асуудал болж байна. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэж үндэсний аюулгүй байдлыг хангах хамгийн гол зорилт нь мэдлэг болон технологид суурилсан, солонгорсон тоон эдийн засгийн бүтэцтэй байх явдал мөн. ■

Дэлхийн эдийн засаг

Дижитал эдийн засгийн парадигм

Д.УЛАМБАЯР (Доктор, профессор)

Хүн төрөлхтөн дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицохоос гадна, олон туйлт дэлхийн шинэ бодлого, түүнчлэн дижитал ертөнцөд хэрхэн дасан зохицох тухай асуудал шинээр дэвшигдэн тавигдаж байна.

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай. Мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь бүтэц, дэд байгууламж, нэг хүнд ногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернэтийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграцлал, инновацичлал улс орны хөгжлийн гол хэмжүүр болов.

Орчин үеийн эдийн засгийн өсөлтийг сонгодог эдийн засгийн өсөлтийн онолоор тайлбарлахад ихээхэн учир дутагдалтай боллоо. Уламжлалт эдийн засгийн онолоор үйлдвэрлэл нь капитал, хөдөлмөрөөс шууд хамаарч, мэдээлэл, мэдлэг, технологи зэргийг гадаад хүчин зүйл гэж үзэж байв. Харин даяаршлын шинэ үед эдийн засаг, үйлдвэрлэлд мэдлэг, мэдээлэл болон мэдлэгт оруулсан хөрөнгө оруулалт шийдвэрлэх нөлөө үзүүлж байна.

XXI зууны эхнээс глобал эдийн засгийн харилцаанд бүтцийн шинэчлэл явагдаж дижитал эдийн засаг голлох үүрэг гүйцэтгэж, глобал шинж чанартай өөрчлөлтүүд маш хурдацтай явагдах болов.

Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, эдийн засгийн шинжлэх ухааны хуучин тодорхойлолтууд шинэчлэгдэж, энэ нь эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, цаг хугацааны алдагдлыг үлэмж бууруулах болов. Нэг талаас

дэлхий дахины худалдаа-эдийн засаг, зах зээлийн харилцаанд мөнгө, санхүү, хөрөнгө, ажиллах хүчний асар өргөн шилжилт хөдөлгөөн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдлэг, мэдээлэлийн хил хязгааргүй урсгал явагдаж, улс орнуудын харилцан хамаарал урьд өмнө байгаагүйгээр гүнзгийрч, түүнд суурилсан даяаршсан макро шинэ ертөнц буй болж, нөгөө талд кибер хэмээх цоо шинэ орон зай, орчин буй болж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлөөс үүдэн мэдээллийн ертөнцөд томоохон өөрчлөлтүүд гарч, мэдээллийн аюулгүй байдал хэмээх шинэ ойлголт буй болов.

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний нэг том нээлт нь амьдрах гео-орон зайгаа цоо шинээр “тэлсэн” явдал юм. Энэ шинэ орон зайг цахим орон зай буюу cyber space гэх агаад хүний оюуны бүтээл болсон энэ орон зай хүн төрөлхтний амьдралд онцгой өөрчлөлт гаргаж, цаашид ч олон өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой байна. Хүн төрөлхтөн материаллаг зүйлээс хамаарах нь эрс багасч, бодит биш жишээлбэл, интернэт банк, виртуаль эмнэлэг гэх мэт буй болж, цахим мөнгөөр гүйлгээ хийж, цахим дуудлага худалдаанд оролцож, маш өргөн сонголт бүхий шинэ төрлийн “new market”-д ороод байна. Бодит биет бүхий ертөнц цахим ертөнцөд биет биш болж байгаа нь түүний хамгийн түгээмэл шинж юм. Кибер технологийн

хурдацтай хөгжлийн үр дагавараар дэлхий нийтийн аюулгүй байдал улам их эрсдэлтэй болж, санамсаргүй байдлаар өчүүхэн зүйлээс ч асар их хор хөнөөл учирч болзошгүй байдал мөн үүсээд буй.

Улс орны дотоод, гадаад бодлогын зааг ялгаа багасч, үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болов. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнэ больж, хил хязгааргүй эдийн засгийн талбар болсон байна. Өөр өөр соёл иргэншил, эдийн засаг, эрхзүйн тогтолцоотой 180 гаруй улс гүрэн интернетэд холбогдож, цахим сүлжээ нь бизнес, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, татвар, мэдээлэл, боловсрол, теле холбоо, ажил эрхлэлт, эрүүл мэнд энтертаймент гээд нийгмийн бүхий л харилцааг өөртөө нэгтгэж байна. Сүүлийн жилүүдэд 3D, 4G, Cloud Computing, nano зэрэг шинэ эдийн засгүүд эрчимтэй хөгжих болов.

Мэдлэг нь өнөө үед тоон хэлбэрт шилжсэн ба дижитал эдийн засаг гэдэг нь тоон технологит суурилсан программчлагдсан хийгээд цахим үйлдвэрлэл, цахим үйлчилгээ, цахим менежмент, цахим маркетингийн үйл явцад тулгуурласан эдийн засаг бөгөөд Internet Economy, New Economy, Knowledge Economy, Smart Economy, үүнээс салбарлан 3D Printing Economy, Web Economy гэх зэргээр янз бүрээр нэрлэж буй ч шинж чанар нь адилхан ажгуу. ▶

ДИЖИТАЛ ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТОЛЦОО



уул уурхайн гаралтай биш, гол төлөв зорчигч, аж үйлдвэрийн болон хүнсний бараа тээвэрлэхэд зориулагддаг гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

● Хийн ба нефть дамжуулах хоолой. ОХУ байгалийн хий болоод нефтийн асар их баялагтай орон. Тус улс төсвийн орлогынхоо дийлэнх хувийг чухамхүү байгалийн хий, нефтийн борлуулалтаас бүрдүүлдэг. ОХУ хийн болон нефтийн хоолойн өргөн сүлжээгээр Европын олон оронд хий, нефть нийлүүлдэг бөгөөд сүүлийн үед Азийн орнуудад нийлүүлэх талаар идэвхтэй ажиллаж байна.

Байгалийн хийн хувьд гэвэл 2014 онд ОХУ-ын “Газпром” БНХАУ-ын CNPC-тай хий нийлүүлэх талаар хэлэлцээр байгуулсан. Хийг баруун болон зүүн чиглэлээр нийлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд зүүн чиглэлээр тавих хийн хоолойгоо (“Сила Сибири” гэж нэрлээд байгаа) барьж эхлээд байна. Харин баруун чиглэлээр хоолой тавих маршрутаа өнөөдрийн байдлаар эцэслэн тохироогүй байна. Хэрэв хоолойг Монголын нутгаар явуулбал илүү дөт учраас тэр хэмжээгээр хямд болж, барих хугацаа нь богиносно гэдгийг манай тал ойлгуулах талаар идэвхтэй ажиллах хэрэгтэй байгаа юм. Өнгөрсөн оны сүүлээр Бээжин хотноо БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооны албаны хүмүүстэй уулзахад тэд хэрэв Оросын тал зөвшөөрвөл хийн хоолойг Монголын нутгаар дайруулахад татгалзах зүйлгүй гэж ярьж байсан.

Нефтийн хоолойн хувьд гэвэл ОХУ-ын Сквородиногоос БНХАУ-ын Дачин хүртэлх хоолойг 2011 онд ашиглалтад оруулсан. Иймээс манайхаар дамжуулж нефтийн шинэ хоолой тавих асуудлыг ойрын үед бараг л ярихгүй болов уу. Харин төмөр замаар нефть нийлүүлэх сонирхолтой байгаа. “Роснефть” компани 2016 онд “Улаанбаатар” төмөр замаар 3 сая тонн түүхий нефть БНХАУ руу тээвэрлэхээр захиалга өгөөд байна.

● Эрчим хүчний шугам. Оросын Зүүн Сибирь эрчим хүчний илүүдэлтэй байдаг. Эрхүүгийн, Братскийн, Усть-Илимийн, Богучаны гэсэн дөрвөн аварга усан цахилгаан станц, манай ТЭЦ-IV –өөс илүү том арваад дулааны цахилгаан станцтай “Иркутскэнерго” компани илүүдэл эрчим хүчээ Монголоор дамжуулан БНХАУ-д нийлүүлэх талаар олон жил ярьж байна.

Гэтэл манайх өөрсдийн нүүрсний ордуудаа түшиглэн дулааны цахилгаан станцууд барьж бас БНХАУ-д эрчим хүч нийлүүлэх сонирхолтой байдаг. Өнгөц харвал Орос, манай хоёрын сонирхол давхцаж байгаа мэт боловч хэрэв гурван орныг холбосон эрчим хүчний шугам тавигдах юм бол Зүүн Хойд Азийн эрчим хүчний нэгдсэн системийн бүрэлдэхүүн хэсэг нь болж аль алиндаа ашигтай байх болно гэж мэргэжлийн хүмүүс ярих юм билээ. Ер нь энэ талаар илүү тодорхой судалгаа хэрэгтэй байгаа юм.

● Бусад төслийн тухайд. Монголоор дайруулан холбооны шинэ шугам тавих, агаарын шинэ зам нээх зэрэг төслүүдийн талаар ярьдаг. Эдгээр нь ач холбогдол, хөрөнгө оруулалтаараа мега төслийн хэмжээнд хүрэхгүй гэж бодож байна. Гэхдээ энэ бол хувь хүний л бодол.

Монгол, Орос, Хятадыг хамарсан дэд бүтцийн эдгээр төсөл нь заавал гурван талын оролцоо шаардах тул төслүүдийг судлах, эхлүүлэх дараалал, хугацааг тодорхойлох, санхүүжүүлэх эх үүсвэрийг нь тохирох, гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч байгууллагуудыг сонгох зэрэг үүрэг бүхий гурван орны хамтарсан Олон улсын төсөл, хөрөнгө оруулалтын судалгааны төв байгуулах хэрэгтэй юм.

Судалгааны ийм төв байгуулах тухай санааг Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өнгөрсөн онд ОХУ-ын Уфа хотноо болсон хөрш гурван орны төрийн тэргүүн нарын уулзалтын үеэр дэвшүүлсэн. Нэгэнт манай Ерөнхийлөгч анх санааг нь гаргасан учраас уг төвийг байгуулах баримт бичгийн төслийг боловсруулан бэлтгэж гурван тэргүүний дараагийн уулзалтын үеэр гарын үсэг зурах ажлыг Гадаад хэргийн яам бэлтгэж байгаа гэж найдаж байна. Мөн манай Гадаад хэргийн сайд ОХУ болон БНХАУ-тай эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссуудыг ахалдаг гэдгийг дурьдах хэрэгтэй.

Төслүүд янз бүрийн салбарт хамаарагдах учраас тодорхой яам, агентлаг биш (төрийн байгууллага нь бас нэг шат дамжлага болж хувирдаг аюултайг анхаарах хэрэгтэй), харин банк-санхүүгийн байгууллага эсхүл олон талт үйл ажиллагаа явуулдаг төрийн оролцоотой корпораци байвал

илүү зохимжтой гэж үзэж байна. Жишээ нь, манай улсаас Хөгжлийн банк эсхүл “Эрдэнэс МГЛ” корпораци, Оросын болоод Хятадын талаас эдгээртэй ижил төрлийн байгууллага байж болох юм. Хэрвээ нарийн тооцоо бүхий судалгаатай төсөл боловсруулж, хэрэгжүүлэх сонирхогчийг нь олох юм бол Азийн хөгжлийн банк (дүрмийн сан нь 55 тэрбум ам.доллар), шинээр байгуулагдсан Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (дүрмийн сан нь 100 тэрбум ам.доллар), “Торгоны зам” сан (40 тэрбум ам.доллартай) зэрэг банк-санхүүгийн байгууллагуудад санхүүжилтийн талаар хандах боломжтой гэж бодож байна.

Монголыг дайран өнгөрөх дэд бүтцийн төслүүдэд хоёр хөршийн буюу Орос, Хятадын оролцоо, хөрөнгө оруулалт заавал байх ёстой гэж бодогдог. Ингэснээр эдгээр төсөл үр ашигтай байх баталгаа бий болно. Өөрөөр хэлбэл ачаа илгээгч болон ачаа хүлээн авагч буюу худалдагч болон худалдан авагчийн оролцоо байх юм бол тэд төслийг аль болох ашигтай байлгахыг зайлшгүй эрмэлзэж таарна.

Дэд бүтцийн эдгээр мега төслийг хэрэгжүүлэх нь манай орны нийгэм-эдийн засгийн амьдралд онцгой ач холбогдолтой учраас сонгуульд орох гэж байгаа улс төрийн намууд, сонгуулийн үр дүнд байгуулагдах Засгийн газар хөтөлбөртөө энэ талаар авах арга хэмжээний талаар тодорхой үе шаттай заалт оруулах нь зүйтэй юм.

Эцэст нь дурьдахад Орос, Хятадтай харилцах харилцаа нь манай орны хөгжил, аюулгүй байдалтай амин холбоотой учраас энэ хоёр оронтой харилцах харилцааны асуудлыг өргөн цар хүрээтэйгээр алс хэтийн (арав, хорь, магадгүй тавин жилийн дараах) төлөвийг тодорхойлон судалж байх хэрэгтэй юм. Ийнхүү томоор харж судалдаг хүн, байгууллага байдаг эсэхийг мэдэхгүй учраас ингэж бичиж байгаа юм. Хэрэв ийм судалгаа хийгддэггүй бол ҮАБЗ, ГХЯ, ШУА-ийн зохих бүтцүүд үүнийг системтэй ажил болгох ёстой гэж бодогдож байна. ■

ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САН гэж юу вэ?



Ажилтны нэр дээрх дансанд байгууллага тухайн ажилтантай хамтран урамшууллын систем хэлбэрээр хуримтлал үүсгэнэ.

Тэтгэврийн сан уг дансан дахь мөнгөн хөрөнгийг удирдаж, эргэлтэнд оруулснаар ажилтны хуримтлалыг үнэ цэнийн бууралтаас хамгаалж, өсгөхийн зэрэгцээ хуримтлагдсан эх үүсвэрийг эргэлтэнд оруулснаар эдийн засгийн хөгжилд томоохон дэмжлэг үзүүлдэг.

ЭМХЭТГЭЛ 2015

Бид энэ дугаартаа өнгөрсөн оны сэтгүүлүүдээсээ он цагийн түүхийг бичиглэсэн онцлох нийтлэл болон нэхэн уншихад хэрэг болохуйц зарим ярилцлагыг түүвэрлэн хүргэж байна.

Захиалагчдад маань манай бүтэн жилийн сэтгүүл эрийтэл өрөөтэй байж болох ч 14 хоног тутам хос хэл дээр гардаг учраас толгой эргэм олон дугаар гардаг. Тиймээс зарим хэрэг болсон нийтлэл, материалыг эргэн харах гэхээр бид өөрсдөө ч шууд тэр дугаарт гарсан гэж санахгүй будилах тохиолдол бий. Энэ утгаар нь бид жилийн 24 дугаарынхаа гол нийтлэл, ярилцлагын эмхтгэлийг гаргаж байх юм. Харин хэдийд байх вэ гэдгийг одоогоор хараахан шийдээгүй байна. Учир нь, бид эмхтгэл дугаараа жил бүрийн эцэст гаргаж байх бодолтойгоор 2014 оны төгсгөлд 2011-2014 оны бүх дугаарын онцлох ярилцлага, нийтлэлүүдээс бүтсэн зузаан гэгч тусгай дугаарыг гаргаж байсан билээ. Гэтэл манайх энэ оноос эхлэн жил бүрийн төгсгөлд Английн “The Economist” сэтгүүлийн Жилийн тусгай дугаар “The World in 2016” сэтгүүлийг Монгол Улс дахь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувиар худалдаанд гаргаж эхлээд буй юм. Энэ нь манай “Mongolian Economy” сэтгүүлийн эмхтгэл дугаар оройтож хүрэх шалтгаан болсон юм. Тиймээс бид энэхүү өөрийн сэтгүүлийн эмхтгэлээ ирэх жилүүдэд хэзээ, хэрхэн гаргах вэ гэдэг цаг хугацааг тодорхой болгоно.

Манай сэтгүүл өнгөрсөн онд улсын болоод Улаанбаатар хотын хөгжил, эдийн засаг, бизнес, аж үйлдвэрлэл, Оюутолгойн тухай олонтаа бичжээ. Ялангуяа хүндэрсэн эдийн засгийг хөдөлгөхийн тулд Оюутолгойн далд уурхайн санхүүжилттэй холбоотой асуудлыг олон талаас нь хөндсөн. Бүр зөвхөн энэ сэдвээр тусгай дугаар хүртэл гаргасан. Түүнчлэн Улаанбаатар хотын хөгжил цэцэглэлттэй холбоотой асуудлаар хоёр ч тусгай дугаар бэлтгэсэн байх жишээтэй.

Бидний бэлтгэсэн шинэ, хуучин мэдээллийг шимтэн уншина уу.







“Тэжээнэ, тэтгэнэ” гэж амалсаар ирсэн төрийн бодлогыг хүртээмжтэй, хүртээлтэй болгоно гэх Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогыг манай сэтгүүлийн зүгээс “Билэгэномикс” гэж нэрлэлээ

Засаглал

Билэгэномикс

Оросын эдийн засаг хямраад эхэлжээ. Гэсэн ч төрийн тэргүүн нь “ОХУ-ыг хэн ч хэзээ ч ганцаардуулж, гацаанд оруулж чадахгүй” хэмээн олон улсад зарлаад авсан. Урд хөршийн удирдагч ч мөн удааширч буй эдийн засгаа унахаас нь өмнө аврахаар өсөх боломж нь өөдөө орнуудыг өөртөө урвуулан “Түнш” гэсэн шошгоор баталгаажуулахаар ажиллаж байна. Тухайлбал, Өмнөд Америкийн нөлөө бүхий улсуудын чухал гэсэн төлөөлөгчдийг эх орондоо урьж хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тал дээр тал засаад эхэлснийг харж болно. Дэлхийн эдийн засаг тийм ч таатай бус байгаа энэ үед хөршүүд маань хэдийнэ хөдлөөд эхэлсэн. Манай улсын хувьд ч шийдлийн Засгийн газар байгуулж, шинэ Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн багийг хэрхэн ажиллахыг харж, хүлээж сууна.

Эдийн засагч, шинжээчдийн үзэж буйгаар Монгол Улс эдийн засгийн хямралд бус хүнд үед орсон гэх. Гэвч дөнгөн данган өдрийн хоолтойгоо залгах иргэдийн тоо нь боломжтой хэсгээсээ хавьгүй илүү учраас хүндрэл хямрал руу халтирахад тун ч амархан. Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөхтэй адил хямраад ирэхээрээ “Хавтгайрсан халамжаас боллоо. Үргүй зардлаас үүдэлтэй” гээд халаглах хүн олон бий. Мөнгө модонд ургадаг мэт сэтгэж хоосон амлалтаар иргэдийг “худалдах” гэсэн улс төрийн явуургүй ролдлогууд өнөөгийн эдийн засгийн хүндрэлийг үүсгэсэн. Ерөнхий сайд Сайханбилэг хэлэхдээ “Энэ удаагийн хямралын үр үндсийг бид нэлээд хэдэн жилийн хугацаанд өөрсдөө бий болголоо. Дан ганц том төслийн хөрөнгө оруулалт, түүхий эдийн үнийн өсөлтөөс орж ирсэн орлогыг бэлнээр

нь тараагаад, дутууг нь арилжааны зээлээр гүйцээх нь эдийн засгийн битгий хэл улс төрийн хүссэн үр дүн авчирдаггүйг өнгөрсөн сонгуулиуд харуулсан. Бонд, зээл хэчнээн босгосон ч, байдгаараа эдийн засгаа тэлэх гэж оролдсон ч бодлогоо зөв гаргаж, үр өгөөжөө зөв төлөвлөхгүй бол эдийн засаг хүссэнээр өсөхгүй байгааг бид харлаа” хэмээсэн. Мөн тэрбээр “Хасья, багасгая, тэсье, гэвчье гэдэг зүйлсийг ярих нь байтугай бодох хүсэлтэй улстөрч лав байхгүй. Тэр тусмаа ийм зүйл хийх хүсэлтэй Ерөнхий сайд байна гэдэг нугаад яахав хүсээд байх зүйл биш. Гэхдээ гашуун ч гэсэн эм. Гачлантай хяслантай ч гарцаагүй хийх ёстой ажлыг барьж авахаас өөр сонголт энэ удаагийн Ерөнхий сайдад, Засгийн газарт байхгүй” гэдгийг УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанд хэлсэн үгэндээ онцолсон. ▶

Түүний зөв. Улсынхаа эдийн засгийг элгээр нь эвхрүүлэхгүйн тулд хэмнээд, гамнаад явахад буруудах зүйл үгүй. Нэгдсэн төсөвтэй болж орлого, зарлагаа зөв тооцохоос эхлээд төсөв нэртэй “хүслийн жагсаалт” батлахаа болих цаг ирсэн. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх бус, хүрч чадахгүй амлалтуудаар улс төрд үлдэх гэсэн өрсөлдөөнийг халах нь хүндрэлээс гарах эхний алхам гэх түүний үгтэй санал нийлэх нь олон буй за.

Мөн Тэрбээр төсвийн хэмнэлтийн хатуу бодлого явуулах ч халамжийг зорилтод бүлэгт нь чиглүүлнэ. Өрийн хэмжээг өсгөнө. Ингэхдээ арилжааны зээл биш, урт хугацаатай/30-40 жил/, бага хүүтэй тусламжийн зээл хөөцөлдөж олно. Ингэснээр хувийн хэвшлийг дэмжиж, тэднийг зээл авахад нь Засгийн газрын баталгаа гаргадаг болох хэрэгтэй гэж үзэв. Мөн төрийн албан хаагчдын орон тоог 15 хувиар бууруулна. Хөрөнгийн татварын тухай хууль хэрэгжүүлнэ. Ерөнхий сайдын албаа хүлээн аваад эдийн засгаа дапуурахаас нь өмнө авах арга хэмжээнүүдээ тэрбээр ийн багцаллаа. Товчхондоо, монголчууд үрэлгэн зангаасаа татгалзаж, хүний гар харж амьдрахаа болих нь ээ. Сайханбилэг сайдын эдийн засгийн бодлого монголчуудад “Хүний эрхэнд жаргахаар өөрийн эрхэнд зов” гэсэн сургаалийг суулгаж өгөх бололтой. “Тэжээнэ, тэтгэнэ” гэж амалсаар ирсэн төрийн бодлогыг хүртээмжтэй, хүртээлтэй болгоно гэх Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогыг манай сэтгүүлийн зүгээс “Билэгэномикс” гэж нэрлэлээ. Энэ нь олон улсад нэртэй Абэномикс, Обаманомикс гээд цөхөрсөн эдийн засгаа хөлд оруулсан эрхмүүдийн амжилт лугаа биелээсэй гэсэн далд хүсэлт тээсэн хэрэг.

Өнгөрсөн хоёр жилд ХАХНХЯ-аас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Монгол Улсын бүх хүн ам, өрхийн судалгааны дүнд Монгол төр монгол хүнээ таньдаг болсон гэх. Ингэснээр халамжийг хавтгайруулах биш хэнд хэрэгтэй түүнд хүртээнэ гэсэн зарчим үйлчлэх болж байгаа аж. Данхар төр, давхар дээлээ ярьсаар буй улстөрчид өөрчлөлтийг өөрсдөөсөө бус иргэдийн халааснаас хэмнэж эхэлсэнд ард олон тус бүрийн байр суурьтай байна. Халамж, хангамж шаардлагагүй гэж үзээд “Монгол Улсын УИХ-ын гишүүдийн төсөв” гэгдэх жилийн 90 сая төгрөгөөсөө

татгалзах УИХ-ын гишүүн байна. Гэвч энэ талаар цөөн хэдэн гишүүнээс бусад нь ам ангайх дургүй байгаа нь “хоосон шоу” явуулаад байна гэх хардлагыг төрүүлж байгаа юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн Г.Баярсайхан “Туслахуудын цалин, бинзен, унааны мөнгө, утасны төлбөр гээд гишүүдэд зарцуулах төсөв гэж байдаг. Миний хувьд гишүүнийхээ цалинг аваад явж болж байна. 15 мянган төрийн албан хаагчийг халж чадаж байгаа юм чинь УИХ өөрөөсөө хэмнэлт хийж болно шүү дээ” хэмээн ярьжээ.

Хэдийгээр Засгийн газрын зардлыг танахаар яригдаж байгаа ч хэрхэн гүйцэлдүүлэх нь тодорхойгүй хэвээр. Тэгсэн атлаа иргэдэд хүртээх мөнгөн халамжийг хасах нэг бус хувилбар хэдийнэ бэлэн болжээ. Хүн бүр халамж хүсэлгүй амьдралаа залгуулаад явсан он жилүүд бидэнд бий. Гэнэт хаслаа, таналаа гээд ирэхээр иргэд ч таатай хүлээж авахгүй нь мэдээж. Гэхдээ халамжийн уршигаар бэлэнчлэх сэтгэлгээ сууж, хөдөлмөрлөх ч хүсэлгүй болсон иргэдийн тоо олширсоор буйг хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн тоо гэрчлэх. Халамжийн бодлогыг өөгшүүлж ирсэн нь төр. Тэд алдаагаа засах гэж оролдож буй ч хүндрэл хямрал болоод байгаа энэ үед хүүхэд, хөгшид, нярайлсан эсвэл нярайлах гэж буй эхчүүдийг бүсээ чангал гэж “зарлигдах” нь хэнд хэрэгтэй түүнд хүртээнэ гэх ярианд нь хэр нийцэж буйг эргэн бодох хэрэгтэй. Хүүхдийн, ээжүүдийн одонгийн мөнгийг яригдаж буй хэмнэлтийн горимд шижүүлснээр 28.6 тэрбум орчим төгрөг хэмнэхээр байгаа аж. Гэтэл сүүлийн гурван жилд 300 орчим тэрбум төгрөгийг тэтгэлэг нэрээр Монгол Улсад сурч буй бүх оюутанд тараасан нь “Сурч байгаад баярлалаа” гэсэн халамж болж хувирсантай “70-д дуртай” оюутнууд ч санал нэг буй.

2015 оны төсвийн тодотголын эхний хэлэлцүүлэг УИХ-аар халуухан хэлэлцэгдэж буй энэ үед Төсвийн урсгал зардлыг 518 тэрбум төгрөгөөр танаж байгаа нь олзуурхах зүйл. Нэг тэрбум төгрөгөөр яригддаг төсвийн хөрөнгө оруулалт 320 тэрбумаас дээшлэхгүй болсон энэ цагт тэвчиж болох хөрөнгө оруулалтыг эцэст нь тулгал царцаахаас аргагүй. Шийдлийн Засгийн газар таналтыг тулгал нь хийнэ гэж байгаа ч цөөнгүй аймгийн хэд хэдэн сумын Хөгжимт драмын театр, соёлын төвийг барихад энэ онд тус бүр 1-2

тэрбум төгрөг төсвийн төсөлд туссан байх жишээтэй. Сургууль, цэцэрлэгийн барилга л биш бол эдгээрийг энэ жилдээ зогсоход юу нь болохгүй байх билээ. 2011 оноос төсвөөс хөрөнгө татаж эхэлсэн дээрх Хөгжимт драмын театруудын нэг сумынх нь театрын нийт төсөв л гэхэд 8-9 тэрбум төгрөг шаардлагатай аж. Хэдэн он дамнасан засвар шинэчлэлд хямралтай жил нэг тэрбум төгрөг тавиад ч дуусахгүйгээс хойш хөрөнгө оруулалтыг хойшлуулахад буруудахгүй.

Мөн оюутны 70 мянгыг бүр болиулах боломж харагдаж буй. Сургалтын төлбөртөө нэмэрлэдэг оюутан мэр сэр бий л байх. Гэхдээ Засгийн газар тэднийг бэдэн мөнгөөр “эрхлүүлж” байгаа нь оюутан залуусын тансаглал хэрээс хэтэрч байгааг илтгэсэн баримт нотолгоо ч багагүй сонсогдох болсон. Тэгээд ч эх, хүүхдийн халамжийн хэдэн төгрөгийг хоёр, гурван сараар нааш цааш татаж, гавьтай мөнгө хэмнэхгүй зүйлээр оролдож, иргэдийг бухимдуулж байхаар нь оюутны тэтгэлэг гэгдэх 90 тэрбумыг онилоход гэмгүй. Засгийн газрын тусгай сангуудыг цөөлж 10 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан шигээ л үзэх хэрэгтэй. Түүнчлэн Засгийн газраас Хөрөнгийн татварын тухай хууль санаачлан /автомашин, орон сууц, буу, малын хөлийн татвар/ гэсэн дөрвөн төрлийн татварыг нэмэгдүүлэх хуулийн төсөл чуулганаар хэлэлцүүлж байна. Хэдийгээр хямралтай үед иргэдийг татвараар дарамталж болохгүй гэх яриа Төрийн ордонд их ч бэлчээр доройтож, зарим нутагт худаг уснаас болж дайн дэгдэх нь холгүй болж буй энэ үед малын хөлийн татварын асуудлыг ярихад буруудах юун.

Эдийн засаг хүндрэлтэйн сацуу сонгуулийн өмнөх жилийн төсвөөс санасан хэмжээний хэмнэлт гаргахад бэрх. Гэхдээ юуны тулд шийдлийн гэсэн тодотголтой засаг билээ бодлого, зорилгоо илүү тодорхой байлгаж, шийдвэртэй, зоримог хандахаас аргагүй.

Ямартай ч Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн хэмнэлтийн Засгийн газарт амжилт хүсье. Яаарвал даарах. Тэгэхээр зөв, буруу гэж дүгнээд яахав. Билэгэномиксийн бүсээ чанагалах арга зам нь хэр их хэмнэлт авчрахыг, ямар үр дүнд хүрэхийг харж, хамтаараа тунгаан бодъё. ■

Мэргэжлийн хүний үг

Б.Түвшинтөгс: Институцийг сайжруулснаар эдийн засгийн хүндрэлээс гарна

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, дэд профессор Б.Түвшинтөгстэй ярилцлаа. Эдийн засгийн хүндрэлийг хэрхэн даван туулах, цаашид ямар бодлого барьж ажиллавал үр дүнтэй талаар бидний яриа өрнөсөн юм. Түүний удирддаг байгууллага эдийн засгийн “өвчин”-ийг онилох чиглэлийн судалгаа хийдэг учир одоогийн нөхцөлд байр суурь нь жин дарна гэж үзэж байна. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн /ERI/ нь 2010 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн дэргэд байгуулагдсан.

-Монголын эдийн засгийн дунд болон урт хугацааны хэтийн төлөв байдлыг та хэрхэн харж байна вэ?

-Асар их өсөх боломжтой эдийн засаг хэвээрээ шүү дээ. Тиймээс дунд болон урт хугацааны хөгжлийн эдийн засгийг өөдрөг харж байгаа. Үүний баталгаа нь газрын хэвлий дор буй байгалийн баялаг. Энэхүү эдийн засгийн боломжийг нийт хүн амынхаа амьжиргааг сайжруулахад чиглүүлэх нь л хамгийн чухал асуудал. Энэ нь Засгийн газруудын толгойны өвчин байх ёстой. Хэдий эдийн засаг хүндрэлтэй байгаа ч ерөнхий утгаар нь аваад үзэхэд дунд болон урт хугацаанд өсөлттэй байна. Ийм хүлээлт ч хүн болгонд бий. Түр зуурын хүндрэл, хямралд итгэл унах учиргүй.

-Шинэ Ерөнхий сайд Монголын эдийн засаг хямарсан гэж УИХ-ын чуулганд хэлсэн үгэндээ онцолсон. Эдийн засгийн өнөөгийн хүндрэлийг 2009 оны хямралтай адилтгаж болох уу?

-Хүндрэл, хямрал харилцан адилгүй ойлголт. Тиймээс 2009 оны нөхцөл байдалтай одоог жиших нь өрөөсгөл. Эдийн засагт үүссэн шинж тэмдгээ бид зөв олж тогтоох ёстой. Ер нь дэлхийн улсууд ажилгүйдлийн өсөлт, ДНБ-ийхээ бууралтаар эдийн засгаа хямралаа тодорхойлсон байх нь элбэг. Манай улсын эдийн засгийн өсөлт саарсан



ч одоогоор долоон хувь байна. Ийм эдийн засгийг хямралд автсан гэж хэлэх нь өрөөсгөл. Учир нь зөвхөн ДНБ-ий өсөлт буурах үзүүлэлтээр нийт эдийн засгийг дүгнэж болохгүй. Өнөөдөр эдийн засаг маш төвөгтэй байдалд байгаа нь төсвийн алдагдал, инфляцийн түвшин, ханшийн сулралт, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны нөхцөл зэрэг үзүүлэлтүүдээс харж болно. Хэрвээ эдгээр хүндрэлүүд засал авахгүй удаан явбал хямрал болно.

-Хүндрэлд хөтөлсөн шалтгаан юу байсан юм бэ?

-Эдийн засгийн өнөөгийн тулгамдсан асуудлууд хэд хэдэн шалтгаантай. Нэгдүгээрт, өнгөрсөн хоёр жилийн хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом унасан. Энэ нь нэг талаас манай гол экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ буурсантай холбоотой ч нөгөө талаас сүүлийн үеийн Засгийн газрын гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой гаргасан сөрөг шийдвэрүүд мөн нөлөөлсөн. Үүнийг ерөнхийд нь төлбөрийн тэнцлийн хүндрэл үүсчээ гэж хэлж байгаа. Хоёрдугаарт, төсвийн алдагдал нэлээд өндөр гарахаар хүлээгдэж байна. Төсвийн орлогын тасалдал асар өндөр гарахаар байгаа

нь алдагдлыг ийнхүү өндөр гаргахад хүргэж байна. Уг нь хуулийн заалтаар бол алдагдал тодорхой хязгаарт байх ёстой. Гуравдугаарт, инфляцийн түвшин зорилтот түвшнээс өндөр байгаа. Энэ нь сүүлийн хоёр жилд баримталж ирсэн мөнгөний болоод төсөв, сангийн тэлсэн бодлогоор дамжуулан нийт эрэлтийг өсгөсөнтэй холбоотой.

-Төгрөгийн ханш суларсаар байна. Үүнд мөнгөний тэлэх бодлого нөлөөлсөн үү?

-Байнга орж гарч эргэлдэж байсан гадаад валютын эргэлт татарч хомсдол үүссэн нь төгрөгийн ханшид дарамт үзүүлж байгаа. Тэр утгаараа төлбөрийн тэнцлийн хүндрэлд Монгол Улс орсон. Орох нь бага, гарах нь их байгаа тул гадаад валютын ханш улам чангарч байна. Монголбанкны валютын нөөц хязгаарлагдмал. Нөгөө талаас, мөнгөний тэлэх бодлого явагдсан нь энэхүү дарамтыг улам өсгөсөн. Ийм нөхцөлд ханш тогтвортой байна гэдэг бэрх. Үүнийгээ бид төлбөрийн тэнцлийн хүндрэл гэж нэрлээд байгаа.

-Цаашид анхаарал татах асуудал юу байна вэ?

-Үл хөдлөх хөрөнгийн зах зээл хэрхэх нь анхаарал нэлээд татах ▶

учиртай. Иргэд болон бизнесүүдийн худалдан авах чадвар, сонирхол буурч байна. Нэгэнт зах зээлд худалдан авагч цөөн учраас үнийн өсөлт саарч эхэллээ. Зарим тохиолдолд одоогийн байгаа түвшнээс үнэ нэлээн буурах хандлага ажиглагдаж байна. Мэдээж тухайн хүн, компани эдийн засаг өснө гэж тооцоод их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байж таарна. Гэтэл үл хөдлөх хөрөнгийн үнэ буугаад байвал хөрөнгө оруулсан хүмүүс төлбөр тооцооны хүндрэлд орно. Энэ нь санхүүгийн системдээ сөргөөр нөлөөлдөг талтай. Бусад орнуудын туршлагаас ч энэхүү зүй тогтлыг харж болно. Ер нь нийгэмд төдийгүй бизнесийн орчинд хүлээлтийн асар их зөрүү гарч байгаа нь эдийн засгийг улам эмзэг болгож байгаа том суваг юм байна гэж хэлж болохоор байна.

Валютын ханш нь Төв банкаар биш зах зээлийн зарчмаар тодорхойлогдох учиртай. Өөрөөр хэлбэл, гадаад худалдааны тэнцэл, эдийн засгийн өсөлт, валютын урсгал, валютуудын өгөөж, эрсдэл зэрэг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд ханшийг тодорхойлдог.

-Сүүлийн жилүүдэд өндөр хүлээлтэйгээр төсвөө баталдаг болсон. Дараа нь түүндээ хүрэхгүй болоод ирэхээр тодотгол хийдэг.

-Монголын Засгийн газар хэчнээн хүслээ ч өөрийн эдийн засгийн нөөц боломжоосоо илүү гарч чадахгүй. Гэхдээ төсвийг байнга тодотгоод байвал буруу жишиг тогтоно. Аль болох тодотгол хийхгүй байхаар төсвөө батлах ёстой. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд өндөр хүлээлтэйгээр төсвөө баталдаг болсон. Дараа нь түүндээ хүрэхгүй болоод ирэхээр тодотгол хийдэг зуршил бий болж байна.

-2015 оны төсөв цаг хугацааны шахалтад орсон. УИХ-ын зарим гишүүн тодотгол хийнэ гэсэн үгтэйгээр кнопоо дарцгаасан. Энэ оны төсөвт цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2.5 дахин нэмэгдүүлэх боломж байна уу?

-Энэ оны төсөв буруу жишиг тогтоосон. Үүнд эдийн засгийн нөхцөл

байдал гэхээс улс төрийн тогтворгүй байдал нөлөөлсөн. Манай улсад жил бүр төсөв өсөлттэй гардаг. Сүүлийн 10 жилийг эргээд харахад Монгол Улсын төсөв гурван жил тутам нугарсан байдаг. Тиймээс орлого, зарлага өсөх нь шинэ зүйл биш. Гол нь орлого төлөвлөлт хэр байхаас л төсвийн нөхцөл байдалд шууд шалтгаална. Өнөөгийн Засгийн газарт төсвийн алдагдлыг зээлээр санхүүжүүлэх орон зай хязгаарлагдмал. 2015 оны эдийн засгийн нөхцөл байдлыг өнөөдрийн өнцгөөс харахад сайнгүй харагдаж байна. Аль болох уламжлалаа хадгалсан төсөв байх хэрэгтэй. Энэ нь амьдралд ойрхон гэсэн үг. Өндөр хүлээлттэй, амьдралаас хол баталвал дахиад л тодотгол хийх болно.

-Хуулийн засаглал сул, түүнийг хэрэгжүүлэх идэвх зүтгэл тааруу байснаас эдийн засгийн хүндрэл нь үүссэн гэж зарим хүмүүс ярьж байна. Энэ тухайд?

-Хуулийн засаглал гэхээсээ илүүтэй институцын чанар гэж бид их ярьдаг. Үүнд хуулиа мөрдөхийн зэргэцээ хуулийн үзэл баримтлалдаа үнэнч байх асуудлууд багтдаг. Ер нь бодлогын тууштай байдал алдагдаж байгааг бид анхаарах ёстой. УИХ, Засгийн газар өөрсдөө баталсан хуулиа үгүйсгэх, түүнийхээ хэм хэмжээнд төсвөө баталж, сахилга батаа сайжруулаагүй. Бид институцын чанараа сайжруулж чадахгүй бол эдийн засгийн хүндрэл, хямралаас өөрсдийгөө хамгаалж чадахгүй. Үүнийг өнөөгийн эдийн засгийн хүндрэл нотолж байна. Бид 2008-2009 онд сургамж авсан гэж бодсон ч 2014 онд буцаад хуучин байран дээрээ ирсэн. Эдийн засаг хүндрэхгүй, дахиж хямрахгүй юм шиг бүгдээрээ бодож, хүлээж бодлого явуулж ирсэн нь өнөөгийн байдалд хүргэсэн гэсэн үг.

-Эдийн засгийн өнөөгийн хүндрэлээс гарахад төсөв, мөнгөний бодлогын үзүүлэх нөлөө хэр байх бол?

-Төсөв, мөнгөний бодлого сүүлийн жилүүдэд харилцан адилгүй тэлж ирсэн. Эдийн засаг хүндрэлд ороход тэлэх бодлогоор хямралыг давах ёстой. Харамсалтай нь одоогийн нөхцөлд ийм боломж хомс. Эдийн засгийг тодорхойлох хоёр бодлогын хувьд орон зай хязгаарлагдмал байна. Мөнгөний бодлогын хүрээнд инфляци зорилтот түвшнээс өндөр байгаагаас мөнгөний нийлүүлэлтийг илүү өсгөх боломж багатай. Нөгөө талаас төсвийн бодлогоо аваад үзэхэд улсын өрийн хэмжээ ДНБ-

тэй харьцуулахад хуулийн хязгаараасаа давсан. Тэр утгаараа төсөв тэлэх боломжгүй. Төсөв, сангийн бодлогоор дамжиж эдийн засгийн удаашралаас гарах бололцоо хязгаарлагдмал байна.

-Бодлогын нөлөөлөл эдийн засгийн хүндрэлийг давахад хүчтэй нөлөө үзүүлэхгүй гэсэн үг үү?

-Аль аль бодлого дээрээ аваад үзсэн ч эдийн засгийн хүндрэлтэй тулахад түүнийг сөрөх зэр зэвсэг муутай байна. Бидний үргэлж ярьдаг байсан макро эдийн засгийн тогтвортой байдал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа тууштай баримтлах байдал эргээд бидэнд асуулга тавьж байна. Хуулийнхаа үзэл баримтлалыг ягштал мөрдсөн бол өнөөдрийн түвшнээс хамаагүй дээр байх байсан гэдгийг үйл явдал тодхон харууллаа.

-Эдийн засагт үүссэн хямралын эсрэг шинэ Засгийн газар ямар бодлого хэрэгжүүлбэл оновчтой байх вэ?

-Эргээд хүндрэл бий болгож буй гурван сувгаа харах хэрэгтэй. Энэ сувгуудаар орж ирж буй хүндрэлийг хаах эсвэл эргүүлэх боломжийг эрэлхийлэх. Нүүрс, зэс, алт гээд манай гол экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ дэлхийн зах зээлийн үнээр тодорхойлогдож байгаа учраас үүний эсрэг юу ч хийж чадахгүй. Уул уурхайгаас ойрын хугацаанд хараат байгаа нь түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий болгосон.

Харин, хийж чадах зүйл гэвэл гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг сайжруулах замаар төлбөрийн тэнцлийн хүндрэлээс ангижирах явдал. Ер нь Засгийн газар өөрчлөгдөх үед бодлого дагаад эргэдэг. Гэтэл бодлогын залгамж чанар хадгалагдах ёстой гэсэн зарчим давхар үйлчилж байх ёстой. Уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай орнуудын хамгийн зөв туршлагыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар гаргаж ирсэн. Энэ нь өсөж байгаа үед нь хадгалаад, унах үед нь хадгаламжаасаа зарцуулах тэр боломжийг олгох юм. Харамсалтай нь гаргаж ирсэн ганц арга хэрэгслээ хэрэгжүүлэхгүй, тууштай авч явж чадахгүй байгаа нь өнөөгийн хүндрэлийг үүсгэсэн. Ороод ирсэн гадаадын хөрөнгө оруулалттай төслүүдэд үүссэн хүндрэлийг нэн даруй шийдвэл тустай. Үүнийг ч эдийн засгийн өнөөгийн байдал шаардаж байна. Гэхдээ арга хэмжээ авлаа ч шинэ ▶

хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байх вий гэсэн айдас бий. Шинэ бодлого, шинэ ёс зүй, шинэ уур амьсгал оруулж ирэх ёстой.

-Төвбанкны гол зорилго нь валютын ханш уу, инфляци уу?

-Төвбанкны гол зорилго бол инфляци. Ер нь эдийн засгийн хүндрэлтэй үед мөнгөний хатуу бодлого явуулбал харамсалтай. Учир нь банкны системээс зээл болоод гарах ёстой байсан нөөцийг Төвбанк өөр дээрээ татан төвлөрүүлнэ гэсэн үг шүү дээ. Гэтэл инфляци зорилгог түвшнээс өндөр байгаа тул хатууруулах бодлого нөгөө талаас шаардана. Эдийн засаг хэт халалттай байгаа учраас мөнгийг нь татаж тэр халууныг нь дарах ёстой. Тийм учраас мөнгөний бодлогын хувьд одоо салаа замын уулзвар дээр ирээд байна. Бидний хувьд чангаруулах уу эсвэл хэвээр үлдээх үү гэсэн сонголттой тулгараад байгаа.

-Иргэдийн дунд харилцан адилгүй ойлголт байдаг.

-Ер нь Монголбанк ганцхан мандаттай байх ёстой гэж боддог. Тэр нь инфляци. Олон нийт валютын ханшийг онилох, удирдах нь зүйтэй гэх нь элбэг сонсогддог. Валютын ханш нь Төв банкаар биш зах зээлийн зарчмаар тодорхойлогдох учиртай. Өөрөөр хэлбэл, гадаад худалдааны тэнцэл, эдийн засгийн өсөлт, валютын урсгал, валютуудын өгөөж, эрсдэл зэрэг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд ханшийг тодорхойлдог. Ганцхан тохиолдолд буюу Монголбанк гадаад валютын асар их нөөцтэй үед л ханшийг удирдах боломжтой. Ер нь Монгол Улс ханшаа удирдах хэмжээний нөөцтэй байсан тохиолдолд үгүй. Тиймээс Монголбанкны мандат бол инфляци. Монголбанк инфляци хангалттай нам түвшинд орсон гэж үзвэл дараагийн асуудал нь эдийн засгийн идэвхжлийг сайжруулах, өсөлтийг бий болгох, олон тулгуур суурьтай болгох талдаа байж болно. Энэ талаас нь аваад үзвэл мөнгөний бодлого дээр ярьсан салаа зам дээр ирээд байгаа гэж бодож байна.

-Эдийн засгийг төрөлжүүлэх

талаар байнга ярьдаг. Харамсалтай нь эдийн засаг ганц хөлтэй буюу уулзурхайгаас хамаарсан хэвээр байна.

-Нөхцөл байдал одоогийнхоос илүү сайн байхад ч төрөлжүүлэх тухай ярьж

бидэнд илүү сонирхолтой.

-Ашигтай төслүүдийг хэн гаргаж ирэх вэ?

-Хувийн хэвшил. Үүнийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Хувийн ашиг сонирхол, ашгийн төлөөх эрэлхийлэл нь бидний хүсээд буй ашигтай салбаруудыг гаргаж ирдэг. Төрийн үүрэг гэвэл хувийн хэвшлийн эрэлхийллийг аль болох зардал багатай байлгах учиртай. Тухайлбал, хүнд суртлыг багасгах, авлигыг халах, дэд бүтцээр хангаж өгөх хэрэгтэй. Институцийн чанарыг сайжруулах, лиценз, зөвшөөрөл, гэрчилгээ ойлгомжтой, цэгцтэй байх нь чухал. Ийм таатай орчинг бүрдүүлсэнээр дараагийн асуудлыг ярих хэрэгтэй. Манайхан их туйлшрамтгай. Үүндээ ч хэт автдаг. Тиймээс өрсөлдөх чадвар, зах зээлийн нөөц боломжоо сайн тооцоолж үзэх ёстой.

-Монголд Хятадын "Bank of China" салбараа нээх тухай асуудлыг та хэрхэн хүлээн авсан бэ?

-Гаднын том банк салбараа нээх асуудлыг манайхан эмзэг хүлээж авах шиг болсон. Заавал Монгол эзэнтэй, Монголын банк байх нь хуучирсан ойлголт төдийгүй туйлширсан хэрэг. Манай дотоодын санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал. Нэг төслийг санхүүжүүлэх хэмжээ тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиар хязгаарлагддаг. Томоохон төслүүдийг санхүүжүүлж чадахгүй байгаа нэг шалтгаан нь арилжааны банкны цар хүрээ хязгаарлагдмал байгаа явдал. Гаднын банкны салбар орж ирлээ гэхэд тэр хязгаарлалт суларч, хүрээ нь тэлнэ. Одоогийн босгож байгаа хөрөнгөнөөс илүү бага зардалтай санхүүгийн эх үүсвэр орж ирэх боломжтой. Тэр утгаараа огт болохгүй зүйл гэж үзэж болохгүй. Нөгөө талдаа эдийн засаг дахь гадаадын банкны оролцоо, цар хүрээг нь хязгаарлах зохицуулалт дүрэм, журмынхаа хүрээнд хийж болно. Тиймээс огт болохгүй гэсэн хатуу байр суурь надад байхгүй. ■



байсан. Ер нь эдийн засагт байнгын сэдэв болсон. Төрөлжүүлэх нь өнөөдөр импортыг орлох болж хувирсан. Импортыг орлуулах санаа 60, 70-аад онуудад их хүчтэй явж байсан ч амжилт олсон нь маш цөөхөн. Гэтэл сүүлийн үед өндөр хөгжсөн орнуудын туршлагаас харахад импортыг орлох гэхээсээ экспортыг дэмжих нь илүү өндөр үр ашигтай, тогтвортой гэж үздэг. Энэ нь ч онолын үндэслэлтэй.

-Эдийн засгийн өсөлт иргэдийн амьдралд наалдацгүй байгааг олон нийтийн зүгээс шүүмжлэх болсон.

-Монголын нийт баялагийн гуравны хоёр нь 35 хүнд төвлөрсөн талаар өгүүлсэн илтгэл саяхан гарсан байсан. Энэ нь орлогын тэгш бус хуваарилалт, өсөлт өгөөжгүй байгааг харуулж байгаа. Дээрх тоо нь шинжлэх ухааны аргаар гаргасан тоо биш ч нөхцөл байдал ямар түвшинд хүрээд байгааг нэг талаар илтгэн харуулж байна. Ер нь өндөр хөгжсөн орнуудад ч мөн адил хөгжлийн эхэн үед орлогын тэгш бус хуваарилалт байдаг. Тэдний хүн амынхаа амьжиргааны түвшинг хэрхэн сайжруулж чадсан түүх л өнөөдөр

Тэгш оролцоо

Далд хуйвалдаан эдийн засгийг “дарлаж” байна



Өсөлт гээчийг хүсэл болгоод дэлхийн эдийн засаг нэлээд удаан явчихлаа. Харин хүсээд буй өсөлт, түүнд хүрэх арга зам нь тун энгийн болохыг Олон улсын валютын сангийн захирал Кристин Лагард ийн сийрүүлжээ.

Эмэгтэйчүүдийн эсрэг “далд хуйвалдаан” дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгааг Кристин Лагард онцлов. Тэрбээр жишээ татан хэлэхдээ “Эмэгтэйчүүдийн

хөдөлмөр эрхлэх боломжийг хууль эрх зүйн хүрээнд буюу “далд хуйвалдаанаар” хааж байгаа нь дэлхийн зарим орон ДНБ-ийхээ 30 хүртэлх хувьтай дүйх өсөлтийг сайн дураараа булшилж буй хэрэг болж байна” гэв. Тодруулбал, Энэтхэг, Турк, Пакистан, Египт зэрэг улсад эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг болоод улс төрийн оролцоог түгтэлзүүлж байгаа нь дээрх дүгнэлтийг гаргах энгийн жишээ аж. Олон улсын валютын сангаас гаргасан

саяхны судалгаанд үндэслэн Кристин Лагард “Эмэгтэйчүүдийг дэлхийн хэмжээнд тоглолт хийх боломжоор хангаснаар найдаж болохуйц өөрчлөлт авчирна” хэмээв. Эр, эм гэж ялгах нь тухайн улсад орох хэдэн тэрбум ам.долларын боломжит урсгалыг боож байгаа хэрэг гэдгийг ч тэрбээр тайлбарласан байна.

Нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, нэмэгдүүлэх нь зөвхөн жендерийн эрх тэгшийн асуудал биш аж. Тэднийг амжилтын тавцанд гаргаж ирэх нь эрчүүдийн ноёрхолыг дарах гэсэн үг огтоос биш, харин тэдэнд хүч нэмэх түлхэц болох тухай тус сангийн захирал цохон тэмдэглэсэн байгаа юм. Лагардын үзэж буйгаар эмэгтэйчүүдийн оролцоо гэдгийн гүн утга эдийн засагт дэмжлэг болоход орших ажээ. Үүний хамгийн энгийн илрэл нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт гэж. Олон улсын валютын сангийн захирал “Харамсалтай нь, гартаа буй таатай боломжийг эргэцүүлэн бодохоос татгалзаж, түүний боломжит үр дүнг нээн илрүүлэхэд анхаарлаа хандуулахгүй байна” хэмээн өөрийн блогтоо нийтэлсэн байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хязгаарлаж буй нь өнөөдөр дэлхий нийтэд хамгийн их хэрэгтэй байгаа эдийн засгийн өсөлтийг хойш чангааж байгааг тус сангийн судлаачид мөн баримтжуулсан байна.

Дэлхийн банкнаас гаргасан статистик үзүүлэлтүүдэд суурилан Олон улсын валютын сангийн судлаач, шинжээчид эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлээс ангид байлгах нь сөрөг нөлөө ихтэй болохыг судлан тооцоолжээ. Тухайлбал, эдийн засгийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд эмэгтэйчүүдийн оролцоо дутмаг байгаа явдал татвар төлөлт, банк санхүүгээс эхлээд хадгаламжийн данс эзэмших гээд энгийн хэдий ч өсөлт чангаах томоохон хүчин зүйл болж байгааг дурьдсан юм. Түүнчлэн тус сангийн зүгээс дэлхийн 40 ▶

гаруй орон, тэдгээрийн дийлэнх болох Их 20-ийн орнуудад эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхтэй оролцоо хязгаарлагдмал байгаа нь тэдгээр улсад туйлын хэрэгтэй байгаа өсөлтөд нэмэр болох хувь хэмжээг багасгаж байна гэсэн юм. Ингэснээр эдийн засагт эерэгээр нөлөөлөх 15 орчим хувийн өсөлт замхарч байгаа аж. Тодруулж хэлбэл, Катар, Оман, Иран зэрэг улсад эмэгтэйчүүдийн оролцоо аль ч салбарт тун бага байдаг нь дээрх орнууд ДНБ-ийхээ 30 орчим хувьтай тэнцэх хөгжлийн боломжоо сайн дураараа “гээж” байна гэсэн үг.

Кристин Лагард “Эмэгтэйчүүдийн эсрэг далд хуйвалдаан эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байна” нийтлэлдээ Перу улсыг онцлон жишээлсэн байна. Перу улс 1993 онд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулснаар тус улсад эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэлтээр эрчүүдийн адил хүлээн зөвшөөрөгдөх боломжтой болсон. Ийнхүү таван жилийн дотор Перу улсын хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо 15 хувиар өссөн байна. Перугийн дээрх “хувьсгал” тус асуудалд чиглэсэн өөрчлөлтүүд

дахь идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж, судалгаа нь аль нэг улсын зан заншил, соёл хийгээд шашны үзэлд халдах зорилго агуулаагүй болно” хэмээн албан ёсоор мэдэгджээ.

Эдийн засгийн хямрал зарим орны хувьд хөдөлгөгч хүч болж мэдэх юм. Тухайлбал, эмэгтэйчүүдийн эдийн засагт оруулах хувь нэмрийг үнэлэн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ингэхийн тулд хориг, саад учруулж буй хууль, дүрэмд өөрчлөлт оруулах, зарим тохиолдолд цуцлах арга хэмжээ авах хэрэгтэй гэдгийг Кристин Лагард онцолсоор буй. Тэрбээр “Эмэгтэйчүүд эдийн засгийн өсөлтөд нэмэр болоход саад болж буй хэтэрхий олон хууль, заалт хэтэрхий олон оронд хэрэгжиж байна. Өсөлтийн замаа олоход эмэгтэйчүүд “луужин” нь болно. Гэвч тэдэнд боломж хэрэгтэй. Энэ тохиолдолд тэдний оролцоо биелэлээ олно” гэсэн байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эсрэг явуулж байгаа “ажиллагаа”, түүний хэлснээр хуйвалдаан, хямралаас гарах бус харин хямрал руу гулсах эрсдэлийг нэмэгдүүлнэ гэдгийг Лагард нийтлэлдээ дурьдсан.

Кристин Лагард Олон улсын

аргументууд итгэл төрүүлэхүйц байж болох. Учир нь хүн ам нь хөгширсөөр буй Япон тэргүүтэй орнуудад хөдөлмөрийн салбараа эмэгтэйчүүдээр “тоноглох” сонголт үргэлж нээлттэй байгааг олон улсын судалгааны байгууллагууд сануулдаг. Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан дэлхийн хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт аль ч улсад хангалтгүй байгаа нь дээрх эдийн засгууд хурдацтай уруудаж байгаагийн нэгэн илрэл байх талтай ажээ.

Олон улсын шинжээчид Олон улсын валютын сангийн захирал дэвшүүлж буй санаагаа эдийн засгийн үндэслэлээр нотлох хэрэгтэй гэсэн. Тэгвэл сангийн зүгээс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлснээр АНУ-ын эдийн засаг таван хувиар, Японы өсөлт есөн хувиар тус тус нэмэгдэнэ хэмээн судалгаагаар нотолсон тухайгаа мэдээлсэн байна. Мөн эмэгтэйчүүдийн нийгэм дэх оролцоо “гэрийн боол”-ын түвшинд байна гэгддэг Египт улсын хувьд эмэгтэйчүүд эдийн засагтаа 34 хувийн өсөлт нэмэрлэх боломжтой болохыг дээрх судалгаанд нийтэлжээ.

Өнгөрсөн сарын сүүлээр дүгнэлтийг танилцуулсан тус сангийн нэгэн судалгаанд “Хэдийгээр жендерийн тэгш оролцоог хангах үйл явцын үр дүн сайжирч буй ч дэлхийн орнуудын 90 орчим хувьд хүйсийн ялгаанд үндэслэн хууль батлах асуудал түгээмэл хэвээр байна. Тодруулж хөндвөл, дэлхийн 28 улсад 10 болон түүнээс дээш ийм төрлийн хууль хэрэгжиж байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн үл хөдлөх хөрөнгө эзэмших эрх, мэргэжил эзэмших боломж зэргийг хааж, хязгаарлах боломжийг нээлттэй болгож буй хуулийн баримт бичгийг баталсаар байгаа нь эмэгтэйчүүдийг эдийн засгийн чадавхгүй эсвэл сул хэвээр байлгах гэсэн оролдлого” хэмээн тайлагнасан ажээ.

Тодорхой тооны оронд хуулиар “хуйвалдаан” хийж байна. Гэсэн ч нийгмийн сэтгэхгүй өөрчлөгдөн асуудалд илүү нээлттэй, олон ургальч хандах болсон нь Перу тэргүүтэй орнуудын жишээ үлгэрлэн харуулж байгааг онцлохгүй байхын аргагүй билээ. ■

Эдийн засаг дахь хүйсийн тэгш бүс оролцоо /ДНБ-д үзүүлж буй алдагдлын хэмжээ



хууль эрх зүйн гэхээсээ илүүтэй нийгмийн сэтгэлгээтэй холбоотой саад, бэрхшээл, хүндрэлүүдтэй тулгардаг болохыг харуулсан гэдэг. Ийм агуулга бүхий дүгнэлтийг хийхдээ Олон улсын валютын сан “Манай сангийн зүгээс эмэгтэйчүүдийн эдийн засаг

валютын санг удирдаж буй анхны эмэгтэй бөгөөд дэлхийн хэмжээний санхүүгийн байгууллагын түвшинд эдийн засагт үзүүлэх эмэгтэйчүүдийн нөлөөг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг идэвхтэй явуулах болсон. Өсөлт саарсаар буй өнөө үед Лагардын



Өдрийн сурвалжлага

Ядуусын амьдралд олон салаа өргөс ургасаар, ужгирсаар

Дэлхийн банк туйлын ядуурлыг өдөрт нэг ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа, дунд зэргийн ядуурлыг хоёр ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа хэмээн тодорхойлдог. Гэтэл Монголд хоногт зургаахан зүсэм талхаар өл залгаж буй өрх гэрүүд байна.

Ядуу хүний зовлонг ядуу хүн л мэддэг гэх үнэн үг бий. Бидний амьдралд эрхэлсэн ажилгүй, мөнгөгүйгээс үүдэн өчнөөн зовлонг зүйл урган гарч байна. Манай сэтгүүл ядууралд байнга анхаарлаа хандуулдаг. Ингэхдээ зөвхөн статистикийг үндэслэх биш, бодит байдлаас сурвалжлан гаргахыг чухалчилдаг. Энэхүү сурвалжлагаа бэлтгэх явцдаа бидэнтэй хамт нэг нарны дор, нийслэлийнхээ хаяанд зүдүүхэн аж төрж буй хэсэг

хүний амьдралтай танилцан, нүдээрээ харж, сэтгэлдээ тунасан бүхнээ уншигч тантай хуваалцаж буй нь энэ билээ. “Ядуурал гэж хүний амьдралын чанарыг тодорхойлогч буюу энгийнээр өдөр тутамд хэрэгтэй хүнс тэжээл, хувцас, гэр орон зэрэг ердийн хэрэгцээний дутагдал гачигдлыг хэлнэ” хэмээн тодорхойлдог. Миний уулзаж ярилцсан хүн бүрт наад зах нь хоол хүнсний дутагдал туйлдаа хүрчихэж гээд хэлэхэд нэг их хазайхааргүй байна. Зургаан

хүүхэдтэй эх хүн хүүхдүүдээ хоногт тус бүр зургаахан зүсэм талхаар хооллож, өөрөө хоосон хонох үе энүүхэнд хэмээн ярьж сууна. Манай улсын нийт хүн амын 40 гаруй хувь нь суурьшиж буй нийслэлд ядуурал өмнөх жилүүдээс буураагүй байна. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд тэдний амьдрал улам туйлдаа хүрч буйг дараах баримтуудаар бататган уламжилъя.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны “Алтан овоо 39”-ын задгай гэх хаягтай газар оршин суух П.Батбаярын гэр бүл. Задгай гэхийн учир нь эднийх өөрийн гэсэн хашаагүй. Ам бүл зургаа бөгөөд дээрх зурган дээрх ганц охин нь дөрвөн ▶

настай. Биднийг очиход 15 настай том хүү нь гэрийнхээ баруун орон дээр унтаж байв. Үе үе зовиурлах түүнийг хараад, өр өвдөж ээжээс нь “Бие нь өвдөө юү” гэтэл С.Цацралтуяа “Үгүй ээ, хүү маань сургуулиасаа гарчихсан. Гэртээ байгаа юм. Өглөөдөө жаахан унтдаг юм” гэлээ. 40 насыг дөнгөж гарч яваа энэ хоёрын амьдрал бүрхэг байна. Эднийх хүнсний талоньг эс тооцвол төрөөс халамжийн мөнгө огт авдаггүй. Бичиг баримтын асуудалтай тул хүүхдийн мөнгөө ч авч чаддаггүй аж. Бидэнтэй хамт явсан хэсгийн ахлагч Х.Оюунгэрэл “Хүүхдийн мөнгөө хурдан хөөцөлдөөч” хэмээн уцаарлангуй хэлээд амжив. Засгийн газраас хэрэгжүүлж буй Хүнсний хөтөлбөрийн хүрээнд нэн ядуу өрхийн насанд хүрэгчдэд 10 мянга, хүүхдэд таван мянган төгрөгийг сар бүр олгодог бөгөөд эдний гэр бүл сардаа нийт 40 мянган төгрөг авдаг. Түүгээрээ нэг сарын хоол хүнсээ базаана. Үндсэндээ өрхийн сарын орлого нь энэ юм. Нөхөр П.Батбаяр нь өдөрт Улаанчулуутын хогийн цэг рүү гарч, мөнгө болгох юухныг түүн, борлуулж өдөртөө 5-10 мянган төгрөг олдог. “Энэ хогийн цэг байгаа нөхцөлд арай ч нэг юм хоол ундаар тасрахгүй л байна даа” хэмээн эхнэр Цацралтуяа ярилаа. Сүүлийн үед төмөр худалдан авахаа байж, зэс, гууль зэрэг зарим түүхий эдийн үнэ унасан нь Батбаярын гэр бүлд хүндхэн дарамт болж байгаа аж. Тухайлбал, нэг кг хуванцар савны үнэ өнгөрсөн онд 300 төгрөг байснаа 200 болж буурсан бол зэсийнх 1500 төгрөгөөр уруудаж 4000 төгрөг болжээ. Арай их үнээр борлуулдаг хог нь архины шил, хамгийн их олддог нь ундааны хуванцар сав аж. Нэг шилийг 100 төгрөгөөр борлуулдаг ч саяхнаас зарим шар айрагны шилийг чөжжүүд худалдан авахаа байжээ. Гэрийн эзэгтэйн хэлж буйгаар ганцхан төрлийн шилийг худалдаж авахаа байхад өрхийн орлогод нь их нөлөөлдөг байна. Гэрийн эзэн уушгины өвчтэй учир тогтсон ажил хийж чаддаггүй бөгөөд бие нь өвдсөн үедээ хогийн цэг рүүгээ ч гарах тэнхэлгүй өнжих нь

бий. Хогийн цэгийн утаа, үнс, тоос шороо түүний биеийг улам муутгадаг гэнэ. Эхнэрийнх нь хөл өвддөг учир хог түүж чадахгүй. Эмнэлэгт үзүүлэх гэхээр даатгал байхгүй, бас л мөнгөний асуудлаас болж эмчилгээ хийлгэж чаддаггүй гэнэ. Өдөрт хүүхдээ харж, нөхрийнхээ хогийн цэг дээрээс олж ирсэн сонины тасархайг олзуурхан уншиж өдрийг өнгөрөөдөг байна. Цацралтуяагийн нэг хөл нь өнгөрсөн жилээс хойш өвдөж, нарийссаар бараг гарынх нь шуу шиг болжээ. Дунд хоёр хүү нь “Эзний хайр ивээл” асрамжийн газарт амьдарч, хорооныхоо 62 дугаар сургуульд суралцдаг. Хоёр хүүгийнх нь нэг нь төрөлхийн харааны согогтой, нөгөө хүүгийнх нь нүд гэнэт солир болж асрамжийн газрынхаа зардлаар Сингапур явж хагалгаа хийлгэжээ. Эднийх түлээгээ хогийн цэг дээрээс базаадаг ч тэр хавьд байдаг хувийн худгаас нэг литр усыг таван төгрөгөөр авч байна. Арын хашааныхаа айлаас тог цахилгаан авах гэсэн боловч цахилгааны утас нь дутчихаад байгаа гэнэ.

Хогийн цэггүй бол хоол үгүй



П.Батбаярын хажуухан талд айл байсан бололтой гэрийн буурин дээр навсар буйдан, хуучин муу хэдэн хувцас хөглөрнө. Цацралтуяагийн хэлж буйгаар эднийх шиг л ядруухан айл байж байгаад эхнэр нөхөр хоёр салсан бололтой. Ядруухан амьдралд айл гэрийн хоёр гэлтгүй, хогийн цэг дээр хогоо булаацалдан муудалцах явдал ч их. Батбаярын гэр бүлийн адил Улаанчулуутын хогийн цэг дээрээс амьдралаа зогоож буй өчнөөн өрх бий. Тухайлбал, эднийхээс зүүн урагшаа хоёр гудамж өнгөрөөд байх Р.Улаанбандийнх ам бүл долуулаа. Дөрвөн хүүхдээс гадна эхнэрийнх нь дүү хамт амьдардаг. 2004 онд Баянхонгор аймгаас нийслэлд нүүж иржээ. Гэрийн эзэн, эхнэр хоёр 32 настай ч одоогоор хоёул эрхэлсэн ажилгүй. Барилгын ажил эхлэхээр ажилд орох санаатай гэнэ. Тэд өдөртөө мөн л Улаанчулуутын хогийн цэгтэй нөхөрлөдөг. Улаанбанди ганцаараа ажиллаад өдөрт 7000-8000 төгрөг олдог бол хоёулаа гарахаараа хоёр дахин ихийг олдог аж. Гэрийн эзэн нуруу, нугасны өвчтэй, төдийлэн хүнд хүчир ажил хийж чаддаггүй. Гэр бүлийн сарын үндсэн орлого дөрвөн хүүхдийнх нь 80 мянган төгрөг. Хогийн цэг дээрээс олсон хэдийгээ тэр өдөртөө хоол унданд зарцуулчихаар цааш нь хадгалах юм үлддэггүй байна. Эхнэр Д.Батсайхан “Мөнгө цаас болжээ. Өмнөх жил давс 500 төгрөг байсан бол өнөөдөр 700 төгрөг. Юмны үнэ тэнгэрт хадаж” хэмээн сууна. Тэрбээр одонгийн мөнгө гэж жилд 100 мянган төгрөг авдаг. Хамгийн бага хүүхэд нь гурван настай. Цэцэрлэгт өгөх гэхээр цэцэрлэг олддоггүй. “Өөрөө ажил хийе гэхээр нас, өнгө зүс заахчаар гологдох юм” гэлээ. Ажил хайхаар ихэвчлэн цайны газарт угаагч, цэвэрлэгчийн ажил л олддог аж. Гэрийн эзэгтэй өнгөрсөн зун барилга дээр ажиллаад хамгийн дээд тал нь 300 гаруй мянган төгрөг авч байсан тухайгаа дуу өндөр ярилаа. Гэхдээ цалингаа өгөхгүй удах гээд асуудал мундахгүй. Харин энэ хогийн цэг дээр бол хүний гар харахгүй, мөнгөө өгөх болов уу үгүй юу гэх айдас байхгүй гэж байна. Энэ өрх хоногт нэг шуудай нүүрс хэрэглэнэ. Өвөлдөө шуудай илүүтэй. Тог цахилгааны төлбөрт ▶

сардаа төслийн зуухны хөнгөлөлттэй нөхцөлд тавин хувь хямдруулж төлж байсан бол одоо 50 орчим мянгыг төлж байгаа аж. Энэ долоон хүн өдөрт хэмнэж, гамнаад 10-20 мянган төгрөг зарцуулдаг байна.

Дэлхийн банк туйлын ядуурлыг өдөрт нэг ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа, дунд зэргийн ядуурлыг хоёр ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа хэмээн тодорхойлдог байна. Энэ нь төгрөгөөр 1994-4000 орчим /2015.03.25-ны Монголбанкны ханшаар/ болно. Гэтэл манайд хоногт зургаахан зүсэм талхаар голоо зогоож буй өрхүүд байна.

Тэдний нэг бол Б.Бауваржаны гэр бүл. Эднийх Чингэлтэй дүүргийн арванхоёрдугаар хорооны 15 дугаар хэсгийн “Булгийн 20”-ийн 1110А тоот хашаанд таван ханатай гэрт есүүлээ амьдардаг. Хамгийн бага нь хоёр ойтой, том нь 16 настай хүү гээд зургаан хүүхэдтэй бөгөөд эхнэр Б.Саруулцэцэгийнхээ ээжийн гэрт толгой хоргоддог. Өдгөө нас сүүдэр 60 гарч яваа ээж нь тэдэнтэй хамт амьдардаг. Эднийх Төв аймгаас шилжиж ирээд 15 жил болж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд амьдрал нь улам л хэцүүхэн болж байгаа тухай Саруулцэцэг ярилаа. Энэ есөн хүн эмээгийнхээ тэтгэвэр, хүүхдийн мөнгөөр амьдарч байна. Саруулцэцэг жилд нэг удаа эхийн одонгийн 100 мянган төгрөг авдаг. Түүний хэлж буйгаар ээж нь Цагаан сарын үеэр тэтгэврийн зээл авчихсан. Нөхөр нь барилгын нэг жижиг компанид ажиллаж байсан боловч компани нь дампуурчихсан, одоогоор ажилгүй байгаа аж. Ганц оюутныхаа төлбөрийг амьтан хүнээс зээлээд төлчихсөн. Саяхан бас хоёр “Портер” нүүрс зээлж авчихаад байгаа гэнэ. “Хүүхдийн мөнгө буухаар л жаахан юм авч бэлддэг” хэмээн гэрийн эзэгтэй сулхан дуугарав. Эднийд 25 кг-ын нэг шуудай гурил сар хүүрэхгүй хугацаанд дуусчихна. Махгүй үедээ гурилаараа талх, боорцог хийж өдөр, шөнөгүй хэрэглэдэг учраас тэр. Хүнсний ногоо барагтай л авдаггүй. Гэрийн эзэгтэйн зөвшөөрлөөр хөргөгчийг нь нээж харгал хэдэн том гялгар уут, хоёр гурван түнтгэр өөхнөөс өөр юу ч алга байлаа. Саруулцэцэг “Одоо гурилгүй болчихоод үлдсэн ганц ширхэг талхаа гамнаж идээрэй гээд сууж байна. Хүүхдүүдээ өглөө, өдөр, оройдоо хоёр хоёр зүсэм талх өгчихөөд

л бид хэд цайгаа уугаад унтаад өгдөг дөө” хэмээн ичингүйрэн хүүрнэлээ. Сарын сүүлээр ийм үе олонтаа тохиох ч эднийх боломжтой үедээ ихэвчлэн шөлтэй хоол хийж иддэг байна. Малын дайвар бүтээгдэхүүн (гэдэс дотор) худалдаж авахаар дотор нь идчихээр олигтой юм байдаггүй. Өөх голдуу. Идэж байгаа нь уушги, элэг. Зарим нь зүрх,

буйгаар настай хүмүүс тэтгэвэр авна, оюутнууд урамшууллаа авчихна. Харин хүүхдүүд ээж ааваасаа л мөнгө нэхнэ. Мөн тэрбээр “Ээжүүд улсад хөдөлмөр хийж өгч байна гэдэг ч гэртээ хүүхдээ харж байгаа ээж урамшуулал авсан юм алга. Би ажил хийвэл хиймээр л байна. Хүүхдүүдээ яах юм. Ямаа, маланд урамшуулал олгоод байдаг ч эцсийн



СХД-ийн 26 дугаар хорооны “Алтан овоо 39”-ын задгай гэх хаягтай газар оршин суугаа П.Батбаярын гэр бүл. 2015.03.20

бөөртэй. Хүүхдүүдээ зүрх, бөөрөөр нь бантан хийж өгчихөөд, хоёр ойтой бага хүүхэд нь мөөмөө идээд унтдаг аж. Гэтэл өлмөн зэлмүүн, дээр нь хөл нь өвддөг ээжийнх нь хөхөнд сүү байгаа гэж итгэхэд бэрх санагдав. Тэрбээр “Манай хүүхдүүд хувь заяатайгаа эвлэрч байх шиг байна. Хаа очиж бие нь өвдлөө гэдэггүй. Юм мэдэхгүйгээрээ энэ бага маань л өлсөөд байна гэдэг юм” хэмээн ярих. Мөнгө хомс, амьдрал тарчиг үед өвчин зовлон холуур байгаа нь сайн хэрэг. Огт мөнгөгүй үедээ ойр хавийн дэлгүүрүүдээс зээл авдаг аж. Ихэвчлэн ганц, хоёр кг будаа, талх, сүү зэрэг бага багаар зээлсээр эцэстээ төлж барахааргүй өр болдог гэнэ. Заримдаа ч арга тасарч байх үед ашгүй оюутан хүүгийнх нь 70 мянган төгрөг буудаг гэнэ. Ойр хавьд нь хамаатан садан айлууд байдаг ч тэдний амьдрал эднийхээс нэг их дээрдэхгүй гэнэ. Нэгнийх нь гэрийнхээ гадаа гурил буулгаж байвал нөгөө хэдэн айлын эхнэрүүд сав суулгаа бариад очдог байна. Тог цахилгааны мөнгө сардаа дүүгийнхтэйгээ нийлээд 40 гаруй мянган төгрөг төлдөг. Үүнийг мөн л эмээ нь өгнө. 41 настай Саруулцэцэг “Дунд сургуулийн хүүхдүүдээс автобусанд мөнгө авахаа болимоор юм” хэмээн ярилаа. Түүний хэлж



эцэст ямаа Монголыг хөгжүүлэх үү” хэмээв. Хүүхдүүдийн сургуулиас анги засвар, тийм ч юмны мөнгө гээд татаас мундахгүй. Гэвч эднийх эдийн саван, угаалгын нунтаг ч авч дийлэхгүй үе олонтаа. Нөхөр Бауваржан хоёр ч газар ажил хийсэн боловч цалингаа авч чадалгүй “буяны ажил” хийчихээд сууж байна. Уулзсан айл бүрт “буяны ажил” хийсэн хүн таарах. Тэд үүнийг эдийн засгийн хүндрэлтэй холбон тайлбарлаж байна. Өмнө нь жижиг компаниудад барилгын ажил хийдэг байсан ч арай ч ▶

энэ жилийнх шиг мөнгөө авч чадахгүй байдаггүй байжээ.

Тэтгэврийн мөнгө нь эмнээс илүү гардаггүй

СХД-ийн долдугаар хорооны ч одоо 26-р хорооны “Алтан овоо-44”-ийн 18 тоот албан байгууллагын хашаа манаж суугаа Н.Чагдарсүрэнгийн ам бүл дөрвүүлээ, өөрийн эзэмшлийн газаргүй, айл айлын хашаа дамжан амьдарч буй. Энэ хоёр хөгшин ганц охинтой. 25 настай Ундрах охин нь дөрвөн настай хүүтэй. Чагдарсүрэн гуай өдгөө 77 нас зооглож яваа бөгөөд Баянхонгор аймгаас нийслэлд шилжин ирээд есөн жил болж буй. Тэрбээр залуудаа барилга дээр ажиллаж, аж ахуй эрхэлж, сүүлд мал маллаж байгаад ганц охиноо сургууль соёлтой болгох гэж хотод иржээ. Гэтэл өнөөдөр охин нь сурсан сургууль ч үгүй, наймдугаар ангиа л төгссөн аж. Охин нь 2008 оноос аав ээжийгээ асарч байгаа. Чагдарсүрэн гуайн хөгшин нь даралт харваад долоон жил болж буй. Одоо биеийнх нь нэг тал мэдээгүй, хүний хэлж ярьж байгааг ойлгох нь байтугай гэрийнхнийгээ ч таньдаггүй. Өндийж ч чаддаггүй. Өдөрт нэлээд унтана. Сэрэхээрээ орилж хашгирна. Өвгөн өөрөө зүрх муу, даралт өндөртэй. Эл өрхийн сарын орлого зөвхөн хоёр хөгшний тэтгэврийн 400 мянган төгрөг. Ч.Ундрах хүүгийнхээ 20 мянган төгрөг хүүхэддээ л зарцуулна. Эднийх өдөр тутмын хэрэглээнээс гадна эм тариа их хэрэглэдэг болохоор арав хоногт 200 мянган төгрөг өлхөн зарцуулдаг байна. Огт мөнгөгүй болох үедээ зээлнэ. Даралтны эм л гэхэд 10 ширхэгийг нь 10 мянган төгрөгөөр авна. Асаргаа, эм тариа, группын мөнгө огт авдаггүй. Охин нь саяхан эмч нарын зөвлөлгөөний хурлаар ээжийгээ оруулахад асаргааны мөнгийг шийдэж өгөх юм хэлсэн гэлээ. Цахилгааны төлбөр нь сард 10 мянган төгрөг. Харин хашааны эзэн манаачийн цалин гэж хоёр “Портер” машин нүүрс буулгаж өгчээ. Тэдэнд энэ их дэм болж. Биднийг очиход Ч.Ундрах худгаас ус авч ирээд байв. Тэрбээр ийн ярьж байна.

“Энэ хоёр маань заримдаа зэрэгцэж, бас цуварч айлгана. Хамгийн ойрхон үйлчилгээ түргэн л байна даа. Түргэн тусламжийн эмч нар зөвлөгөө өгөөд л явдаг. Хүүхэд маань удахгүй сургуульд орно. Чадвал ирэх есдүгээр сараас цэцэрлэгт явуулна. Энэ жил их

хямралтай байгаа. Талх 800 төгрөгийн үнэтэй байсан бол одоо 1050 болчихоод байна. Ээж маань өндийж чаддаггүй болохоор байнга живх хэрэглэнэ. 17 мянган төгрөгөөр 10 ширхэг живх аваад 10 хоногт л хэрэглэдэг. Хоолгүй хонох үе зөндөө. Ер нь би найз нөхөдтэйгээ уулздаггүй. Хүүгийн аав хааяа залгаж ярьдаг ч уулздаггүй. Манайд бараг хүн орж ирэхгүй. Хааяадаа хамаатны ах эгч нар орж ирнэ. Тэд нар ч бид дөрвийг нэг их тоодоггүй юм” хэмээв.

Чагдарсүрэн гуай тэтгэврээ буухаар өвчин намдаах болон толгой, даралтны эмээ базаадаг. Мөнгөний гачигдалд орохоороо аль болох өөрийнхөө нэр дээр зээл авч, энүүхэндээ хөгшинөө бодон, алс хэт арга ядахад зээл авна хэмээн эмгэнийхээ нэр дээр тэтгэврийн зээл авдаггүй байна. Гэхдээ бие гайгүй шиг болохоор мөнгөө хэмнэж, хайрлаад эм авдаггүй гэлээ. Байгаа хэдээрээ амьдралаа болгох гэж аав охин хоёр нэлээд тооцоотой ханддаг нь ярианаас нь илт. Чагдарсүрэн өөрөө санхүүгээ барьж охиндоо бага багаар хэдэн төгрөг өгч явуулж хоол ундны юм авдаг байна. Охин “Ийм байдалтай байгаа хоёр хүнийг орхиод яаж ч ажил хийхэв дээ. Би анх хотод орж ирээд олдсон ажлыг голлолгүй хийдэг байсан” хэмээлээ. Мөнгөний хэрэгцээгээ харахаар ажил хиймээр байдаг ч тэрбээр аав ээжийнхээ ачыг хариулах гэж хичээж буй нь энэ гэсэн юм. Ундрах хааяадаа энэ гуравтаа бууз хийж өгнө. Түүнээс биш эднийх байнга гурилтай шөл иддэг бөгөөд саяхнаас ээж нь огт юм идэхээ байжээ. “Уйллаа гээд амьдрал шийдэгдчихгүй юм хойно ингэж л энэ хоёрынхоо ачыг хариулна даа” хэмээн хоолой зангиран ярих тэрбээр 25 насандаа хоолой дээр тулах зовлон бүхнийг хойш залгин амьдарч байна. “Насаараа хөдөлмөр эрхэлчихээд насны эцэст ингэж ч амьдарч байх гэж” хэмээх хоног өнгөрөөн суугаа Чагдарсүрэн гуайн эцэг хүний шаналал гаансных нь утаа адил гэр дүүргэх шиг.

Сүүлчийн баримт

Үндэсний статистикийн хорооны судалгааны тайлангаас харахад 2010-2012 онд ядуурлын хэмжээ буурч 38-27.4 хувьд хүрчээ. Тус хорооноос хамгийн сүүлд олон нийтэд мэдээлсэн дүн нь энэ бөгөөд удахгүй дөрөвдүгээр сард шинэ тайлан гаргах гэж байгаа гэсэн юм. НҮБ-ын Мянганы хөгжлийн

хөтөлбөрийн хүрээнд ядуурлын хэмжээ буурч байгаа ч хөтөлбөрийн хүрээнд энэ онд ядуурлыг 2000 оныхоос хоёр дахин бууруулна гэх зорилт тавьсан. Хэдий ядуурлын талаар нааштай үзүүлэлттэй гарч байгаа ч тус хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт одоогоор хангалтгүй байгаа талаар НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын мэргэжилтэн А.Цэцэгмаа ярилаа.

Манай улс энэ онд ядуурлын хэмжээг нэг оронтой тоонд оруулна гэх том зорилт тавиад буй. Гэтэл ядуурал буурах биш өсчээ. Ялангуяа Улаанбаатар хотод ядуурлын түвшин өнгөрсөн оны аравдугаар сартай харьцуулахад одоогийн байдлаар бараг хоёр дахин өсч 40 хувьд хүрсэн байна. Тус дүнг МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор Б.Алтанцэцэгийн “Хэрэглэгчийн итгэлийн индекс” судалгаанаас харж болно. Түүний хэлж буйгаар ийм төрлийн өмнөх судалгаануудтай харьцуулахад Улаанбаатар хотын ядуурлын түвшин олон өрхийн орлого, улсын эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлаас хамааралтай байгаа нь ажиглагджээ. “Эдийн засгийн байдал ялимгүй муудахад ядуу өрхүүдийн амьдрал түрүүлж дорддог. Тэгэхээр энэ нь ядуурлын түвшинг нэмэгдүүлж байна” хэмээн МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор Б.Алтанцэцэг хэллээ. Ялангуяа өрхийн орлого тун бага, өрх толгойлсон эмэгтэй, эдгээр өрхийн ядуурлын түвшин тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдлаас илүү их хамааралтай байдаг байна. Ядуу өрхүүд ч гэлтгүй хаа сайгүй бизнес эрхлэгчид бараа, бүтээгдэхүүндээ хямдрал зарлаад буй. Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хороонд нэг ой зургаахан сартай охиноос гадна дунд сургуулийн сурагч дөрвөн хүүхдийн аав С.Энхбаяр учраа олохгүй тэвдэж сууна. Том хүү нь 18 настай жудо бөхөөр хичээллэдэг. Түүний гэр бүлийн хүн хөхний хорт хавдраар бурхан болоод дөнгөж арав хонож буй. “Одоохоондоо ханийн маань буяны ажилд цугласан хэдэн төгрөгөөр болж л байна. Цаашид яаж амьдрах учраа нэг л олохгүй байна. Амьд яваа цагт болох л байх даа. Хэдэн хүүхдээ өлсгөхгүй, дааруулахгүй бол ч боллоо доо” хэмээн санаашрах. Энхбаярын гэр бүлийн сарын орлого таван хүүхдийнх нь 100 мянган төгрөг. Өмнө нь эхнэртэйгээ хамт дулааны улиралд барилга дээр ажиллаж сард таваас зургаан зуун мянган төгрөг олдог байж. Харин тэр одоо ганцаараа.

Хөдөлмөр эрхлэх гэхээр үр хүүхдээ ▶

орхиж болдоггүй, ажил хайхаар олдох нь ховор, ажил хийж байгаа нэгэн нь цалингаа бүтэн авах нь асуудалтай бас маргаантай ийм л олон салаа өргөс ядуусын амьдралд ургасаар, ужигарсаар. Зүгээр суухаар өлсөх, ядуурах бас туйлдахын цондон болох. Их хотын амьдрал ёстой л эрээнтэй бараантай, ядуу гэх өрхүүд зутруухан амьдарч байна. Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны Засаг дарга Ж.Оюунцэцэг “Халамжийг хавтгайруулж олгосноос болж иргэд бэлэнчлэх сэтгэлгээтэй, амьдралынхаа төлөө тэмцэх ухамсаргүй болж байна” хэмээн ярих. Ийм хүмүүс ч бий. Гэтэл халамжийн мөнгөгүй бол өлсөж үхэхээр амьдралтай хүн олон байна. Дахин хэлье. Улаанбаатарт ядуу амьдралтай иргэд туйлдаж, ийм өрхийн эгнээ өдрөөс өдөрт

өргөжсөөр. Зүдрүүхэн эдийн засгийг зүлгүүрдэх хүч нь ажиллах хүчин, хөдөлмөр эрхлэлт гэдэг нь үнэн аж. Улсын маань ажиллах хүчин, иргэдийн амьдралын өнөөдрийн дүр төрх цаашид хэр удаан үргэлжлэх юм бол оо. Магад улсын эдийн засаг сэргэх тэр үед амьдрал арай дээрдэх учиртай. Маргаашийн нар манддагаараа л мандана. Өнөөдөр гэдэс хонхонзон суугаа хэсэг хүүхэд маргааш хоолтой хонохыг мөрөөдөн сууна. Ядуугийн зовлонгоос улбаалж хөгшин, залуугүй өвчилж байна. Саяхан нэг сургалт дээр Төвбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалын хэлж байсан үг санаанд тод тусав. “Монгол Улсын иргэд ажилгүй болвол нүх рүү унана” гэж. ■

2015 оны 03 сар. №086, 087

Хөтөлбөр

Хүндрэлийг даван туулах хөтөлбөрийг тольдохуй


2016 онд суурь асуудлууд нь шийдэгдээд хөрөнгө оруулалтын орчин сайжирлаа гэхэд тэр олон том төслийг нэгэн зэрэг эхлэх шийдвэр гарах нь бас эргэлзээтэй юм. 2015 оны хувьд төрийн банкны бонд ганцаараа эдийн засгийг аврахад хангалтгүй учраас Дэлхийн банк болон ОУВС орж ирэх үү гэдэг л байна.

Эрдэс баялгийн олон улсын зах зээл дээрх ханшийн уналт болон хөрөнгө оруулалтын их хэмжээний бууралтаас үндэстэй одоогийн эдийн засаг, санхүүгийн хүндрэлийг даван туулахын тулд эрх баригчид өнгөрсөн Цагаан сарын битүүний өдөр “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээ”-ний төлөвлөгөөг баталсан. Тус хөтөлбөр нь 2015-2016 оны хүрээнд төсвийн хүндрэл, гадаад хөрөнгө оруулалтын орчин, гадаадын худалдааны тэнцэл болон санхүүгийн секторыг сайжруулахад чиглэгдсэн. Ерөнхийдөө, энэхүү төлөвлөгөөнүүд нь эдийн засгаа аль болох хумихгүйгээр мега төслүүдийг эхлүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг таган, мөн дотоод дахь үйлдвэрлэлээ дэмжих зорилготой харагдаж байна. Гэвч одоогийн байдлаар энэ ондоо багтан мөнгө авчрах хөтөлбөр нь төрийн банкны

300 сая ам долларын бонд байгаа бөгөөд нэг бус мега төслийг нэгэн зэрэг 2016 онд багтаан эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах: Монгол Улсад итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээн гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилго бий. 2012 оны тавдугаар сард батлагдсан Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай (СААНХО) хуулиас шалтгаалан анх бууж эхэлсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оны долдугаар сард гарсан Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалтыг зогсоох шийдвэр гарснаар маш эрчимтэй унаж энэ оны эхний сарын байлдаар бүүр хасах дүнтэй гарсан. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд 2016 он гэхэд Оюу Толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын асуудлыг эцэслэж, V цахилгаан станцын ажлыг эхлүүлэн, төрийн банкны бондыг босгохоор шийдвэрлэжээ. Үүнээс цахилгаан станцуудын хөрөнгө оруулалтыг гацааж байсан үнэ тарифыг чөлөөлөх асуудал эрчимтэй яригдаж байгаа бөгөөд төрийн банк бонд босгох зөвшөөрлөө авчихаад байна. Эдгээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээнүүд амжилттай болвол 2016 оны эцэс гэхэд доод тал нь 1,7 тэрбум долларын хөрөнгө оруулалт орж ирнэ хэмээн хөтөлбөрийг боловсруулсан мэргэжилтнүүд үзэж байна. Энэхүү дүн нь 2013 оны нийт хөрөнгө оруулалтын дүнтэй ойролцоо боловч 2011-2012 оных шиг их хэмжээний биш юм. Оюутолгой, Тавантолгойн хоёр том төслийн асуудал шийдэгдсэнээр хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэн бусад төслүүдийн хөрөнгө оруулалт дагаад нэмэгдэх боломж бүрдэнэ. Ялангуяа дэд бүтцийн томоохон төслүүдийн ажлууд эхлэх боломжтой болох юм. ▶

Дэд бүтцийн төлөвлөгдсөн төслүүд



► Дэд бүтцийн төслүүдийг эхлүүлэх: Дэд бүтцийн томоохон төслүүдийн хувьд богино хугацаандаа V цахилгаан станц, Тавантолгойн цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлэх зорилт тавин 2016 он гэхэд төслийн бэлтгэл ажил нь хангагдан барилгын ажил нь эхэлсэн байхаар тусгасан байна. Түүнчлэн Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг 2015 оны хоёрдугаар хагасаас эхлүүлэх зорилготой байна. Харин дунд хугацаанд үр дүн нь гарах газрын зураг дээр тэмдэглэгдсэн авто зам, төмөр зам, цахилгаан станцын төслүүдийг 2016 он гэхэд концессийн гэрээ байгуулан төсөл болон барилгын ажлыг нь эхлүүлчихсэн байх юм байна. Эдгээр дэд бүтцийн төслийг хэрэгжүүлж дуусахад доод тал нь 5 тэрбум долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Тиймээс хөрөнгө оруулагчдын итгэл буцаж сэргэсний дараагаар л тус төслүүд нь хэрэгжиж эхлэх боломжтой юм. Мөн цахилгааны үнийн тарифийн чөлөөлөлт нэлээд үүрэг гүйцэтгэнэ.

Импортыг давсан экспорт: Гадаад худалдааны тэнцлээ сайжруулахын тулд уул уурхайн экспортын хүчин чадал, үйлдвэрлэлийг нэмэхээс гадна уул уурхайн бус экспорт (ноос, ноолуур, оёдол) болон импортыг орлуулах (цемент, арьс ширээр хийсэн бэлэн бүтээгдэхүүн) үйлдвэрлэлд хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл (~500 сая доллар) олгон зарим бүтээгдэхүүний импортын гаалийн татварыг нэмэх зэргээр дэмжлэг үзүүлэхээр тусгажээ. Үүнээс гадна энэ хүрээнд нэлээд хэдэн мега төслүүд 2015-2016 онд эхлэхээр төлөвлөгдсөн байна. Цагаан суваргын орд, Зэс хайлуулах үйлдвэр, Нүүрснээс шингэн болон хийн түлш гарган авах үйлдвэр болон Газрын тос боловсруулах үйлдвэр. Эдгээр нь маш их хөрөнгө оруулалт шаардагдах том төслүүд бөгөөд гадаад хөрөнгө оруулалтын орчин болон Хятад, Орос болон Япон улстай хийж буй гэрээ хэлцлүүдээс ихээхэн хамаарахаар байна. Мөн 2016 он гэхэд алтны үйлдвэрлэлийг 2014 оныхоос гурав дахин, төмрийн хүдрийн экспортыг хоёр дахин нэмэгдүүлнэ гэж байгаа нь дэлхийн зах зээл дээрх үнэ унаад байвал эсрэгээрээ алдагдал ч авчрах магадлалтай юм.

Улсын төсвийн тогтвортой байдлыг дэмжих: 2015 оны багтагдсан төсвөөс гадуурх зардлыг багтаасан нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх таван хувийг 2016 онд багасгаж дөрвөн хувь болгон ДНБ-ий 58,3 хувь байгаа улсын өрийн хэмжээг 55% болгож бууруулна

гэсэн зорилт тавин ажиллахаар болсон. Үүн дээр нэмээд төсвийн тогтвортой байдлыг хангахаар тогтворжуулалтын сангийн хөрөнгийг нэмэгдүүлж, дээрээс нь ирээдүй хойчдоо зориулагсах баялагийн санг 2015 оны сүүлээс эхлэн 2016 ондоо багтаан шийдвэрлэхээр болсон байна. Өрийн таазын тухайд энэ нь боломжтой зүйл юм. Учир нь өрийн удирдлагын тухай хуулиар засгийн газрын баталгаа болон төрийн өмчит байгууллагуудын өрийг улсын өрөөс хасахаар болсон. Тиймээс энэ нь аль хэдийн улсын өрийн ДНБ-н 55%-аас буулгасан төдийгүй бүүр нэмэлт өр босгох боломжийг олгосон. Харин Хөгжлийн банкны зардыг багтаасан төсвийн алдагдлын хэмжээг 2015 онд 5%, 2016 онд 4%-д байлгах нь асуудалтай байж болох юм. Учир нь энэхүү хөтөлбөрийн хүрээнд ажилгүйдлийн түвшинг 6.9% (2014 оны байдлаар 7,7% байсан), ядуурлын түвшинг 26.0% (2012 оны тооцооллоор 27,4% байсан) болгох зорилтот бүлэгт чиглэгдсэн нийгмийн халамжийн бодлого багтсанаас гадна хөгжлийн банкны зээлээр дамжуулан уул уурхайн бус экспорт болон импортыг орлох төслүүдийг дэмжихээр болсон байна. Харин 2015-2016 онд тогтворжуулалтын сан болон баялагийн сангийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн ч мөнгө цугларах эсэх нь эрдэс баялгийн олон улсын зах зээл дээрх үнээс илүү хамааралтай. Түүнчлэн энэхүү хөтөлбөрийн хүрээнд эдийн засаг дахь төрийн оролцоог багасан, төрийн өмчит байгууллагуудыг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах болсон заалтууд орсон нь урт хугацаандаа

эдийн засгийн өсөлтөд сайнаар нөлөөлөх юм.

Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх: Богино хугацаанд үр дүн нь гарах хөтөлбөрүүдийн хувьд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалан, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулна. Мөн төрийн банкны 300 сая ам долларын бондыг энэ оны 2,3-р улирлаас гурван жилийн хугацаатай босгохоор зөвшөөрлөө авчихсан байна. Харин дунд хугацаанд үр дүнгээ өгөх хөтөлбөрүүдийн хувьд хөрөнгө оруулалтын сан, Засгийн газрын баталгаа болон Зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг нь өргөжүүлэх төлөвлөгөөтэй.

Ерөнхийдөө, энэхүү эдийн засгийн хүндрэлээс гарах төлөвлөгөөнүүдийн суурь нь Оюу Толгой болон Таван Толгойн хэлэлцээр байгаа мэт харагдаж байна. Хөтөлбөрийн ихэнх төлөвлөгөөний хэрэгжилт нь энэ ондоо багтаж эхлэх нь эргэлзээтэй байгаа бөгөөд мөнгө босгох арга нь Төрийн банкны бондыг түрүүлж босгох. Мөн цахилгааны үнийг чөлөөлөх тал дээр хэлэлцээр явагдаж байна. Харин 2016 онд суурь асуудлууд нь шийдэгдээд хөрөнгө оруулалтын орчин сайжирлаа гэхэд тэр олон том төслийг нэгэн зэрэг эхлэх шийдвэр гарах нь бас эргэлзээтэй юм. 2015 оны хувьд төрийн банкны бонд ганцаараа эдийн засгийг аврахад хангалтгүй учраас Дэлхийн банк болон ОУВС орж ирэх үү гэдэг л байна. ■

2015 оны 03 сар. №086, 087

Үл хөдлөх хөрөнгө

Барилга өнөөдөр

Барилгын салбарынхан “Энэ жил-дээ манай салбар өөдлөхгүй нь. Сонгуулийн маргаашнаас л хөдөлгөөнд орж магадгүй” хэмээн ярилцаж сууна. Учир нь төр засаг хөдөлж, улсын эдийн засаг сэргэвэл энэ салбар хямралаас гарна гэх. Улсын бүтээн байгуулалтын ажилд 80 мянган хүн ажиллаж байгаа бөгөөд дагалдах салбарт 130 мянган ажлын байр бий болдог аж. Гэтэл эдийн засгийн хүндрэл энэ салбарт

нөлөөлж, нийт ажилтны 40 гаруй хувь нь цомхотголд орсныг Монголын барилгын үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Г.Түмэнжаргал хэлэв. Мөн дагалдах салбарт ажиллаж байгаа болон тэдгээрийн ар гэрийнхнийг тооцвол 300-гаад мянган хүний орлого эрс буурах хандлага ажиглагдаж байгаа аж. Эдийн засаг энэ хэвээр үргэлжилбэл барилгын салбарт ихээхэн хүндрэл гарч, салбарын татвар төлөлт их хэмжээгээр буурч, барилгын материалын ►

► худалдааны байгууллагуудын хооронд өрийн сүлжээ үүсэх зэрэг хүндрэл үүсэхээр байгааг ч Г.Түмэнжаргал анхааруулаа.

Харин Монголын барилгачдын холбооны ерөнхийлөгч М.Батбаатар “Барилгын салбар бусад салбараа татах эрсдэлтэй. Амьдрал дээр улсын төсвийн ажлыг гүйцэтгээд мөнгөө авч, зээлээ төлж чадахгүй байдалтай байна. Манай салбарын бүтээн байгуулалт яваад л байна. Хөгжил зогссон юм байхгүй” гэлээ. Барилгын компаниуд өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан ажиллаж байгаа ч барилга нь эргээд борлогдох нь хүнд байна.

Өнгөрсөн онд ашиглалтад орсон орон сууцны 7000 гаруй нь борлогдолгүй он дамжсан. Энэ онд 25 мянга орчим айлын орон сууц ашиглалтад орно гэж буй. Тэгэхээр зах зээлд 30 гаруй мянган айлын орон сууц байна гэсэн үг. Хэдий орон сууцны нийлүүлэлт хангалттай ч худалдан авалт муу байгааг салбарынхан ярьж байна. Тэдний хэлж буйгаар улсын эдийн засгийн “цусны эргэлт”-ийг сайжруулахын тулд дулааны улиралд барилгын салбарыг хөдөлгөөнд оруулах хэрэгтэй гэнэ. Үүний тулд зах зээл дээр эзнээ хүлээж буй хэдэн мянган орон сууцыг борлуулах шаардлага тулгарна. Гэвч улсын хэмжээнд хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн 1.8 хувь, чанаргүй зээл 0.5 хувийг эзэлж байгаа нь зээлийн чанарт 97.7 хувьтай буюу өндөр үзүүлэлт гэдгийг Ерөнхий сайд Ч.Сайханбилэг тодотгосон. Нэг үгээр, иргэдийн худалдан авах чадвар сул байгаа төдийгүй авсан зээлээ төлөх тэнхээ алга гэхэд хилсдэхгүй. Иймээс эдийн засгийн өнөөгийн байдалд төрөөс барилгын салбарыг дэмжих зайлшгүй шаардлага тулгарсныг

албаныхан учирлаж байна. Эл асуудлаар Ерөнхий сайд “Засгийн газар энэ арга хэмжээний эхлэл болгон ипотекийн зээлийг тогтвортой, урт хугацаанд үргэлжлүүлэхийн тулд “Засгийн газрын Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-д урьдчилгаа төлбөрийн хэмжээг 10-30 хувь байхаар тусгасан ч 2013-2014 онд 30 хувиар хангагдаж ирсэн. Энэ төлбөрийн 20 хүртэл хувьд нь Засгийн газар баталгаа гаргаснаар банкны хувьд эрсдэлгүй, иргэд 10 хувийг төлөөд урт хугацаанд үлдсэн 20 хувийг төлөх боломж бүрдэнэ. УИХ бодлогын хувьд дэмжлэг үзүүлбэл Засгийн газар урьдчилгаа төлбөрийг бууруулах бололцоотой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” хэмэсэн.

Мөн тус зээлд хамрагдахад орон сууцны талбайн 80 ам.метр босгыг чөлөөлж, нээлттэй болгоно гэж буй. Ипотекийн зээл олгож эхэлснээс хойш нийт 67612 иргэнд 2957.85 тэрбум төгрөгийн зээл олгож, 1657 иргэнд 57.75 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлжээ.

Энэ онд Барилга, хот байгуулалтын яамны зүгээс эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан салбартаа хоёр чиглэл барьж ажиллана гэдгийг салбарын сайд хэлсэн. Нэгдүгээрт, барилгын бизнесүүдээ дэмжинэ. Энэ хүрээнд захиргааны чанартай хүнд суртлын дарамтыг багасгаж, бизнес орчныг нь сайжруулахыг чухалчилж байгаа гэлээ. Мөн ипотекийн зээлийг үргэлжлүүлж, нөхцөлийг нь хөнгөвчлөх нөөц боломжийг эрэлхийлж буй. Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар “Энэ удаа эрэлт талаа түлхүү дэмжиж, санхүүжилтийн шинэ нөөц боломжуудыг судалж, хөөцөлдөж байна. Дотоодын нөөц боломж нэгэнт нимгэрсэн тул


Он	Төслийн тоо	Айлын тоо	Жигнэсэн дундаж үнэ
2015 оны 2-р улирал	21	4350	2230.776
2015 оны 3-р улирал	17	8625	2,057.631
2015 оны 4-р улирал	19	9095	2,468.080
2016 он	6	1472	3,645.805

гадаадын хөрөнгө оруулалтыг татахад ач холбогдол өгнө” хэмээв. Хоёрдугаарт, эл салбарын урт хугацааны ерөнхий хөгжлийг бодолцсон алхмуудыг хийнэ гэж байна. Ингэхдээ салбарынхаа хөгжлийг “хүн-хэрэглэгч төв”-тэй болгохыг зорьж байгаа аж. Хүн төвтэй болгоно гэдэг нь хэрэглэгчийг дээдлэх, ажиллагсдын аюулгүй байдлыг эрхэмлэх, ард иргэдийн аюулгүй байдлыг хүндэтгэх гэсэн гурван зарчимд тулгуурлах юм байна.

Барилгын салбарын ирээдүйг төсөөлөхөд улсын эдийн засгийн байдалтай холбож үзэх хэрэгтэйг салбарынхан хэлж байна. Жилдээ л энэ салбарын хөрөнгө оруулалт 4.4 хувиар өссөн гэх тоо барим бий. Хөрөнгө оруулалт хийгдээд байгаа хэрнээ хөгжихгүй байна гэх асуудал урган гарч ирж байгаа юм. Харин орон сууцны зах зээлд сүүлийн хоёр жилд 4.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийнхэн хийсэн судалгаа байна. Салбар хөгжихийн хэрээр хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа гэсэн үг.

Гүйцэтгэж байгаа барилга угсралтын ажлыг жилийн хэмжээнд нь аваад үзэхэд 2001 оноос хойш дунджаар 10-15 хувиар өссөн үзүүлэлт байх. Хувийн хэвшлийнхний оруулж буй хөрөнгө оруулалт нэлээд хувийг эзэлж байна. Гэвч хөрөнгө оруулагчид барилга барилаа гэхэд эргээд тэд худалдан авалтын батгалгаад эргэлзэж байгааг Монголын барилгын үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал хэллээ. Нөгөө талаас, зарим төслийн барилгын ажилд хөрөнгө оруулалт нь цаг алдаж ордог, мэргэжлийн боловсон хүчин дутмаг зэрэг нь саад болдог аж.

Хөрөнгө оруулалт, санхүүжилт талаас нь харахад хөгжил удааширсан мэт харагдаж байгааг Монголын барилгачдын холбооны Ерөнхийлөгч М.Батбаатар ярьсан. Гэхдээ салбарынхан өөрсдийн бололцоондоо бүтээн байгуулалтын ажлаа явуулсаар байгаа аж. ■





Дэлхийн чуулган

Уур амьсгалын өөрчлөлтийн эргэх цэг

Уур амьсгалын өөрчлөлтийн Суурь конвенцийн 21 дэх чуулга уулзалт Парис хотноо энэ оны арваннэгдүгээр сарын 30-наас арванхоёрдугаар сарын 12-ны хооронд амжилттай болж өндөрлөлөө. Талуудын 21-р чуулганд 195 орны Засгийн газрын төлөөлөл, иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэлийн төлөөлөгч зэрэг нийт 50 мянга орчим төлөөлөгч оролцсон юм. Чуулганы үйл ажиллагаа, яриа хэлэлцээ энэ сарын 11-ний өдөр дуусах байсан ч хэлэлцэгчид цогц гэрээ байгуулахыг хүсэж байсан тул нэг өдрөөр сунгасан.

Бүтэн хоёр долоо хоногийн турш эрчимтэй хэлэлцээр хийсний үр дүнд дэлхийн дулаарлын өсөлтийн хэмжээг 2 градусаас бага хэмжээнд барих гэрээнд бараг 200 гаруй улс нэгдэн батлаж чадлаа. Энэхүү гэрээ нь нүүрс хүчлийн хийг бууруулах зорилгод дэлхийн бүх улс орнуудыг хамруулж чадсан анхны гэрээ болж байгаа юм.

Сүүлийн хэдэн жилийн турш уур амьсгалын гэрээ хийхээр Энэтхэг болон Хятад улстай нягт ажилласаар ирсэн АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри “Манай гаригийг шинэ замналд оруулж чадахуйц гэрээнд дэлхийн нийт хүрч чадлаа” гэж хэлэв.

Хятадын талаас цаг уурын өөрчлөлтийн хэлэлцээрт оролцсон ахлах мэргэжилтэн Си Жэнхуа “Энэхүү гэрээ төгс биш, сайжруулах шаардлагатай зарим зүйлс байгаа. Гэвч энэ нь биднийг энэхүү түүхэн замналын дагуу явахад саад болохгүй” гэж хэлжээ. Ноён Си уг гэрээг шдарга, ойлгомжтой, тэнцвэртэй, маш их амбицтай бөгөөд үр дүнтэй хэмээн тодорхойлсон юм.

Хэлэлцээрт орсон улсуудас Парисын гэрээнд хүрэхэд АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама тус улсын нүүрсээр ажилладаг эрчим хүчний станцуудын хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах зорилготой АНУ-ын анхны цаг уурын

өөрчлөлтийн талаарх бодлогыг баталсан нь ихээр нөлөөлсөн гэж хэлж байсан юм. Үүний зэрэгцээ, Хятад улсын агаарын бохирдлын хэмжээх сүүлийн жилүүдэд бууруушаах хүмүүс олон болсонтой холбогдуулан Ерөнхийлөгч Ши Жиньпин дотоодын нүүрсний хэрэглээг багасгах бодлогыг дагах болсон билээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама шинэхэн батлагдсан Парисын уур амьсгалын талаарх гэрээг “Эх дэлхийгээ аврах бидэнд байгаа хамгийн том боломж” хэмээн сайшаажээ. Тэрээр хэлэхдээ уг гэрээ дэлхийн хувьд эргэх цэг мөн түүний засгийн газрын хувьд тодорхойлох мөч байж болох юм гэж уг түүхэн гэрээнд хүрсний дараагаар мэдэгдсэн аж.

Францын Ерөнхийлөгч Франсуа Олланд “Зуун зууны туршид Парист маш олон хувьсгал гарч байсан. Харин өнөөдрийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хувьсгал нь хамгийн ▶



► гайхамшигтай бөгөөд хамгийн тайван хувьсгал боллоо” хэмээн хэлсэн юм.

Обама хэлэхдээ “Америкийн ард түмэн өөрсдөөрөө бахархаж болно. Яагаад гэвэл энэхүү түүхэн гэрээнд АНУ-ын тэргүүлэх оролцоо маш их байсан. Сүүлийн долоон жилийн туршид АНУ дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг гол тэмцэгч болж чадсан юм” гэжээ.

Арванхоёрдугаар сарын 12-ны бямба гаригийн орой дэлхийн үндэстнүүдийн багалсан уг гэрээ хамгийн том, бэрх төдийгүй зуу зуун тэрбум ам.доллар шаардах аж.

Хорин жилийн турш сунжирсан энэхүү хэлэлцээрт цэг тавьснаар түүхэн дэх байгаль орчны хамгийн далайцтай хэлэлцээрт хүрч байгаа юм. Ингэснээр дэлхийн дулаарлын зөвшөөрөгдсөн хэмжээ болох 2 градус Цельсийг 1.5 градус болгож уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг огцом багасгах боломжтой болж байна.

Дэлхийн дулаарлын шинэ хэмжээг тогтоох Парисын гэрээнд бусад арга хэмжээнүүд ч багтжээ. Үүнд дэлхийн хамгийн баян орнууд 2020 оноос эхлэн хөгжиж буй орнуудад үер, ган, шуурга гэх мэт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх гамшигаас урьдчилан сэргийлэхэд туслах зорилготой дор хаяж 100 тэрбум ам.долларыг зарцуулна гэсэн амлалт өгсөн

байна.

Мөн буурай орнуудад дэлхийн дулаарлаас үүдэлтэй бүх төрлийн асуудлуудад туслах зорилгоор мөнгөн тусламж үзүүлэх юм, учир нь далайн шуурга, үер зэрэг гамшигууд огцом нэмэгдэх болсноор зарим газар нутагт амьдрах боломжгүй болж байгаа юм.

Франц улсын Гадаад хэргийн сайд Лоран Фабиус гэрээг баталсныг зарлахад 200 гаруй орны төлөөлөгчид босч алга ташин шүгэлдэж байлаа. Лоран Фабиус энэхүү гэрээг маш ихийг зорьсон, тогтвортой гэрээ гэж хэлээд хэт дулаарсан манай гаригийг боломжит гамшигаас урьдчилан сэргийлэх зорилгод “эргэх цэг” боллоо гэж хэлжээ.

Харин ОУВС-гийн тэргүүн Кристин Лагард дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг шийдэхэд нэг алхам урагшиллаа гэж хэлсэн бөгөөд түүний гол хэлхийг хүсэж буй санаа нь “нүүрстөрөгчийн ашиглалтад үнэ тавих юм” гэв.

Уг гэрээгээр дэлхийн улс орнууд таван жил бүр нүүрс хүчлийн ялгаруулалтаа бууруулж байх үүрэг хүлээсэн байна. Зорилтот 1.5 С-д хүрэхийн тулд цаашид хийн ялгаралтыг улам бууруулах ёстой бөгөөд Парисын гэрээг хийгдэхээс өмнө 170 гаруй орон дэлхийн дулаарлын

өсөлтийг 2.7-3 градус Цельсэд барих боломжтой гэж үзэж байсан юм.

Үүнээс гадна шинэ гэрээнд маш чухал ург хугацааны зорилт бий. Энэ зорилт нь энэ зууны хоёрдугаар хагас гэхэд нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бүрэн зогсоох аж. Тодруулбал, 2050 болон 2100 оны хооронд дэлхийн нүүрстөрөгчийн ялгаруулалтыг тэг хэмжээнд хүргэх зорилт юм. Ингэснээр CO2-ийн ялгаруулалтыг газар дээр нь илрүүлж газар доогуурх хоолой руу ялгаруулах эсвэл илүү олон мод тарих шаардлагатай болно гэсэн үг.

Харин мэргэжилтнүүд хэлэхдээ бидний дэлхийн дулааралтай тэмцэх нэг бүлэгт цэг тавигдаж баагаа ч одоо дахин шинэ бөгөөд илүү хүнд бүлэг эхэлж байна, учир нь энэхүү өндөр зорилтот гэрээг хэрэгжүүлэхэд маш их зүйлийг давж гарах хэрэгтэй болно гэжээ.

Хэдийгээр 1.5 градус Цельсэд хүргэх уг гэрээг олон нийт маш их дэмжиж байгаа ч эрдэмтэд үүнийг хэрэгжүүлж ажил болгож чадах эсэхд эргэлзэж байгаа юм. Өнгөрсөн сард шинэ судалгаагаар дэлхий үйлдвэрлэлийн өмнөх үеэс 1 градус Цельсээр дулаарсан нь тогтоогдсон бөгөөд энэ нь бидэнд цаг маш бага байгааг илтгэж байна. ■

Business Summit

Б.Лакшми: Хөрөнгө оруулагчдад эдийн засаг муу байх нь хамаагүй тогтвортой байх нь л чухал

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Эдийн засгийн форумын захирал, Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтын ерөнхий зохион байгуулагч Б.Лакшмитай ярилцлаа. Тэрбээр Холбооны бүгд найрамдах Герман улсын Берлин хот дахь Эдийн засаг, техникийн их сургуулийг Олон улсын менежмент, санхүүгийн чиглэлээр төгсчээ.

-Энэ жилийн бизнесийн дээд хэмжээний “Бизнес саммит 2015” чуулган өнгөрсөн жилийнхээс юугаар онцлог вэ?

-Монголын бизнесийн дээд хэмжээний уулзалтыг өнгөрсөн оны зургадугаар сард анх удаа зохион байгуулсан. Монголын эдийн засгийн форумгаар бид дотоод асуудлаа ярилцдаг. Харин хөрөнгө оруулалт татахад тусдаа үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгтэй гэж үзсэн. Лондон, Хонконгод болдог Монголын хөрөнгө оруулалтын чуулганд гадаадын хөрөнгө оруулагчид очиж байгаа юм чинь Монголыг сонирхож байна гэсэн үг. Тэгэхээр тэнд харилцаа холбоо тогтоосон хүмүүсээ Монголд урьж хөрөнгө оруулалт татах, бизнесийхэнтэйгээ уулзуулах, бүтээн байгуулалтын ажлуудаа бодитоор танилцуулахын тулд энэхүү арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ жилийн хувьд эдийн засаг сайнгүй, хөрөнгө оруулагчдын итгэл суларсан үе л дээ.

Ийм үед хөрөнгө оруулалт татах янз бүрийн оролдлогууд хийх хэрэгтэй. Гаднын орнуудад Монгол Улсын талаарх мэдээлэл хангалтгүй байна. Мэдээллийн хэрэгслүүдээр Оюутолгой гэж юу вэ гэдэг мэдээллийг л авч байгаа болохоос яг бодит байдал дээр ямар ч мэдээлэл алга. Дээрх нөхцөл байдлаас үүдэн чуулганыг зохион байгуулж байна.

-Төр, хувийн хэвшлийнхэнд хөрөнгө оруулалт татах ямар боломжууд байна вэ. Өнгөрсөн жилийн чуулганы үр дүн юу байв?

-Чуулган төр, хувийн хэвшлийн

томоохон бүтээн байгуулалтын ажлуудын талаар хөрөнгө оруулагчдад танилцуулах, дэд бүтцийн томоохон гэрээүүдэд гарын үсэг зурах, нэгдмэл байр сууртайгаар бизнесийн орчноо дэмжих зорилготой. Өнгөрсөн жил цахилгаан станцуудын төсөлд гарын үсэг зурсан. Тухайлбал, Тавантолгойн

цахилгаан станцад хөрөнгө оруулах сонирхолтой байгаа хүмүүст төслийг танилцуулахын зэрэгцээ оролцогчдод бодит байдлыг тайлагнасан. Төслийн хувьд бүх зүйл бэлэн. Харин гацааж байгаа нь Оюутолгойгоос баталгаа авах. Мөн Тавдугаар цахилгаан станцыг барих Концессийн гэрээнд ▶



Фотог Б.Бямба-Очир

► гарын үсэг зурсан. Хөрөнгө оруулагчид нь шалгарсан. Энэ бүхэн хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж байна.

-Энэ жилийн чуулганы үеэр ямар сэдвүүдийг онцолж байгаа вэ. Томоохон бүтээн байгуулалтын төслөө танилцуулж хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах ямар төлөвлөгөө байна вэ?

-“Эрдэнэт” үйлдвэр үйлдвэрлэлээ өргөжүүлж үйл ажиллагааныхаа хүчин чадлыг 25 хувиар нэмэгдүүлж байна. Мөн дампуурлын ирмэгт ирээд байсан Шарын голын уурхай хувийн өмчид шилжиж гаднын хөрөнгө оруулалт татсанаар одоо ямар түвшинд ажиллаж байгааг бид мэднэ. Түүнчлэн хаягдал усыг дахин боловсруулах, “АСЕМ 2016” эдийн засагт ямар үр дүн үзүүлэхийг хэлэлцэнэ.

Уламжлал ёсоор мега төслүүд ба хөгжлийн явц гэсэн сэдэв бий. Монгол Улс асар их нөөцтэй орон гэж ярьж байгаа хэдий ч бид өнөөг хүртэл Тавдугаар цахилгаан станцын төслөө хэрэгжүүлж эхлээгүй байна. Энэ төсөл одоо эхлэхгүй бол 2020 он гэхэд улаанбаатарчууд цахилгаан, дулаангүй болно. Бид засвар үйлчилгээ гэдэг зүйлдээ анхаарч чаддаггүй. Гэнэт л болохоо байлаа гэдэг. Цэвэрлэх байгууламж ажиллахгүй бохироо Туул гол руу цутгаж байгаатай л адилхан. Цахилгаан станц барихад хэр хугацаа орох билээ. Үүнийгээ ч тооцоолохгүй байнга шийдвэрээ өөрчлөөд байвал хэн бидэнд итгэх билээ. Мөн манай улсын үл хөдлөх хөрөнгө, төмөр зам, дэд бүтэц, хөрөнгийн зах зээлийн талаар салбар хуралдаанууд болно. Ерөнхийдөө эдийн засгийн чухал салбаруудаа хэрхэн мөнгөжүүлэх талаар хэлэлцэх юм.

-Тэгвэл хүлээж байгаа үр дүнг хэрхэн харж байна вэ?

-Тавдугаар цахилгаан станцын эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зурж эцэслэх төлөвлөгөөтэй байна. Мөн Шарын голоос Солонгос руу нүүрс экспортлох гэрээ хийнэ. Үр дүнгээ өгөх хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг хэлэлцэнэ.

Эдийн засгийн байдал хүнд байж болно. Гэхдээ энэ нь боломж байхгүй гэсэн үг биш. Боломжоо хайж эрэлхийлэх хэрэгтэй. Аливаа зүйлийг хийж, бүтээж байж ашиг, үр дүн гарна шүү дээ. Чуулганы үеэр томоохон байгууллагуудаар танилцах аялал хийнэ. Өнгөрсөн жилийн хувьд

Оюутолгой, Тавантолгой, МАК, АПУ, “Говь” компанитай танилцах аялал зохион байгуулсан. Энэ удаа “Эрдэнэт” үйлдвэр, “Эрдэнэт” хивс, бусад үйлдвэртэй танилцах аялал зохион байгуулахаар төлөвлөсөн. Учир нь зөвхөн Улаанбаатар хотод гэлтгүй хөдөө орон нутагт хөрөнгө оруулалт татах зорилготой. Эдийн засгаа төрөлжүүлэе, төвлөрлөө сааруулъя гэвэл бусад хот, аймагт хөрөнгө оруулалт татах нь бодит арга хэмжээ болох юм. Бид хөрөнгө оруул гээд уриалаад байдаг. Хамгийн гол нь тэр хүмүүст Монголд ирээд хаана, яаж хөрөнгө оруулах, мэдээллээ яаж авах зэрэг асуудал болдог. Түүнчлэн гадаадад байгаа Элчин сайдын яамдуудтайгаа уялдаа холбоо муу ажиллаж байна гэдэг.

Элчин сайдуудыг Монгол руу хөрөнгө оруулалт татсанаар нь ажлын үнэлгээг нь дүгнэх тухай ярьж байна. Энэ нь зөв. Хөрөнгө оруулагчдаа яг яаж холбох, хэрхэн уялдаа холбоотой ажиллах талаар хэлэлцэх угтаараа хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт илүү үр дүнтэй юм.

-Оюутолгойн гүний уурхайн санхүүжилтийн төлөвлөгөөнд гарын үсэг зурлаа. Хөрөнгө оруулагчдын хандлага сэргэнэ гэх хүлээлт байна. Зөвхөн уул уурхай бус өөр ямар салбарт хөрөнгө оруулах боломж бий вэ?

-Дараагийн томоохон мега төслүүдийг ажил хэрэг болгох боломж бидэнд бий. Хамгийн гол нь төслүүдийг улстөржүүлж байгаа нь асуудлыг улам дордуулдаг. Сонгууль болж өөр нам гарч ирэхээр өмнөх засгийн хийсэн ажлыг үгүйсгээд эхэлдэг. Том төслүүд ТЭЗҮ-ээ боловсруулахад их хугацаа зарцуулдаг. Үүний дараа хөрөнгө оруулалт татаад бүтээн байгуулалтын ажлаа эхлэх гэхээр өөр нам гарч ирээд орвонгоор нь эргүүлчихдэг. Миний харж байгаагаар үр өгөөжгүй зардал их гаргаж байна. Тавантолгойн уурхайд хичнээн ч тендер зарлав. Оролцогч компаниудын хувьд ч хөрөнгө мөнгө зарцуулж байгаа. “Seimens” компанийн төлөөлөгч “Бид дөрвөн удаа тендерт оролцсон. Ямар ч шийдэлд хүрээгүй” гэж байсан. Тэгэхээр дахиад оролцох эсэхдээ тэд эргэлзэж байх жишээтэй. Дэлхийн томоохон уул уурхайн компаниудын салбар Монголд байсан. Гэтэл одоо бүгдийг нь үргээсэн байна. Өөх ч биш булчирхай ч биш байхаар тэд залхаад явсан. Энэ жил гэхэд “Пийбоди”

салбараа татлаа.

Одоо цөөн хэдэн компани үлдэж. Тэднийг авч үлдэх, төслүүдийг нь урагшлуулах тал дээр анхаарах хэрэгтэй. Манай улс хөгжихөд тийм хүнд биш. Бодлогоо зөв тодорхойлоод нэгдэхэд хөрөнгө оруулагчид бол бэлэн байна.

-Хөрөнгө оруулалтын чуулганд хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийнхний хамрах хүрээ хэр байна вэ?

-Хувийн хэвшлийнхний оролцоо идэвхтэй байгаа. Төслүүдээ танилцуулна. Хөрөнгө оруулагчдын хувьд 30 гаруй компани ирж байна. Эдгээрийн дийлэнх нь Америк байгаа бол Сингапур, Хонконг, Солонгос зэрэг улсаас мөн сонирхон ирж байна.

Хамгийн гол нь хөрөнгө оруулагчдад эдийн засаг муу байх нь хамаагүй. Тогтвортой байх нь л чухал. Засгийн газраас дахин бонд гаргах асуудал ярьж байна. Өрийг өрөөр дарж байгаа л нэг арга. Бид таван жилийн өртэй байсан бол арван жил болж байна гэсэн үг. Бид санхүүгийн бусад арга хэрэгсэл болох хөрөнгийн зах зээл бусад салбараа хөгжүүлэх боломтой. Амар хялбар аргаар биш дотоод орчноо сайжруулж, зээлжих зэрэглэлээ нэмэгдүүлж, зээлийн хүүгээ бууруулах орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна. Дэлхийд мөнгө хангалттай их байна. Тэр мөнгийг татах боломж манайд бүрэн бий.

-Та жил бүрийн Эдийн засгийн чуулганыг зохион байгуулдаг. Энэхүү арга хэмжээний үр дүнгийн талаар тодруулбал?

-Монголын эдийн засгийн форумын үр дүнгийн талаар хүмүүс их асуудаг. Шуудутгаараа үр дүн гардаг гэж хэлэхгүй. Харин тус чуулганаар тулгамдсан зүйлээ ярилцаж нэгдсэн ойлголттой больё гэсэн давхар зорилго агуулдаг. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшил, иргэний нийгмийнхний дуу хоолойг сонсох суурь нь юм. Шинэ санаа дэвшүүлэх, хүмүүстэй уулзаж ярилцах боломж. Олон улсын байгууллагуудын зүгээс Монгол Улс бол жинхэнэ ардчилсан орон гэдэг. Сайд, дарга нар нь суугаад хүмүүс нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж байна. Мөн Монгол Улс харьцангуй нээлттэй орон учраас асуудлыг ярьж, сонсож, хэлэлцүүлж байна. Энэ нь л форумын бас нэг онцлог юм. ■



Компанийн засаглал

Б.Бямбасайхан: Компанийг компани шиг л ажиллуулах хэрэгтэй

Төрийн өмчийн компаниудын өнөөдрийн байдал, цаашдын өөрчлөлт шинэчлэлийн талаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхантай ярилцлаа.

-Төрийн өмчийн компаниудын засаглалыг өөрчлөх чиглэлээр та нэлээд ажиллаж байгаа. Явц ямар байна вэ?

-Бид шинээр дугуй зохион бүтээхгүй. Монголд хэдийнэ нэвтэрсэн тэр системийг л төрийн өмчийн компаниудад мөрдүүлэх зорилготой. Маш энгийнээр тайлбарлавал, эзэн хэн байх нь хамаагүй, компанийг компани шиг ажиллуулья гэж байгаа юм. Төрийн өмчит компаниудын эзэн нь Монгол Улсын иргэд. Гэтэл бидний өмч болсон компаниудын тухай ямар ойлголт нийгэмд явдаг билээ. Бүгд мэднэ.

Төрийн тодотголтой компаниудын ихэнх нь өнөөдөр ашиггүй ажиллаж байна. Эдгээр компани явал ашигтай ажиллах вэ гэвэл компани шиг ажилласан цагт л гэж би хэлнэ. Компанийн гол зорилго эзэндээ ашиг авчрах шүү дээ. Яагаад төрийн компаниуд ашиггүй

ажиллаж, хувийнхан ашигтай, сайн менежменттэй байна вэ. Хувийн хэвшлийнхэн улсын эдийн засгийн 80 хувийг үйлдвэрлэж байна. Тэд компани шиг л ажилласан учраас улсынхаа хөгжлийг нуруундаа үүрээд явж байна. Харин төрийн өмчийн компаниуд яагаад ашиггүй ажилладаг вэ гэвэл компани мөртлөө компани шиг ажиллаж чадахгүй байгаад л учир байна. Монголын хувийн компаниуд амжилттай ажиллаж болдог юм байна гэсэн компанийн хөгжлийн сайн загварууд манайд олон бий.

Тиймээс бид төрийн өмчийн компаниудыг ийм зарчмаар ажиллуулах зорилготой бэлтгэл ажлуудыг хийж байна. Үүний тулд эхлээд хаана яваагаа тодорхойлох, тухайлбал, санхүүгийн тайлан тооцоо олон улсын шаардлагын дагуу байна уу, стандартад хэр нийцсэн байна гэдэгт анхаарал хандуулж байна. Дэлхийн хамгийн том аудитын компаниудын нэгээр аудит хийлгэж байна. Үүгээр манай компаниудын санхүүгийн тайлан тооцооны байдал, хөгжил, дутагдал гарч ирж, хаана яваагаа тодорхойлох болно. Компани

шиг хөгжихийн төлөө бүгд зорьж байна. Манайд маш сайн боловсруулсан Компанийн тухай хууль мөрдөгддөг. Хууль, эрх зүйн сайн орчин бүрдсэн гэсэн үг. Орчиндоо зохицож ажиллах ёстой. Хандлагын өөрчлөлт гарна. Компани ашигтай ажиллаад ирэхээр ажилтнууд ч эрч хүчтэй, зорилготой урамтай ажиллах нөхцөл бүрдэх юм.

-Манай төрийн компаниуд олон улсын хэмжээний компаниар санхүүгийн аудитаа хийлгэх нь ямар ач холбогдолтой вэ?

-Санхүүгийн аудит хийлгэх нь маш чухал. Олон улсын зах зээлээс хөрөнгө босгоход хамгийн түрүүнд сүүлийн гурван жилийн нолон улсын санхүүгийн аудитын компаниар хийлгэсэн санхүүгийн аудитын тайлан заавал шаардлагатай болдог. Энэхүү тайлангаас олон улсын санхүү бүртгэлийн стандартын дагуу санхүүгийн менежментүүдийг хэр явуулдгийг хардаг. Нөгөө талаас бид мөнгө босгохгүйгээр компаниудын үйл ажиллагааг томруулах, шинэ менежмент нэвтрүүлэх боломжгүй.

Төрийн өмчийн компаниуд хууль, эрх зүйн хязгаарлагдмал орчинд үйл ажиллагаа явуулдаг. Асуудал шийдэх, томоохон үйл ажиллагаа явуулахад олон хууль, дүрэм, журмын хүрээнд ажиллах шаардлагатай учраас цаг хугацаа алдаж, зардал ч их гардаг юм байна. Зарим хууль, дүрэм нь хоорондоо уялдаа холбоогүй, зөрчилтэй. Тэр зөрчилтэй орчны дундуур хэрхэн яаж гарах вэ гэж ажилласаар байтал цаг хугацаа яваад өгдөг. Үүнийг өөрийн биеэр мэдэрч байна. Өнөөгийн бизнес бол цаг хугацаатай уралддаг, мөн маш их өрсөлдөөнт орчин шүү дээ. Гэтэл төрийн компаниуд нэг талаас өрсөлдөөнт орчинд, нөгөө талаас хязгаарлагдмал нөхцөлд ажиллаж байна. Бид энэ байдлыг хуулийн хүрээнд, өөрчлөх бэлтгэл ажлуудыг хийгээд явж байна.

Манай улс нэгэнт зах зээлийн эдийн засгийг сонгосон, үүгээр замнаад явж байгаа, тэрхүү зах зээл нь олон улсынхтай холбогдчихсон компани олон зуун жилд хөгжин дэвшсээр өнөөдөр хамгийн боловсронгуй хэлбэртэй ороод явж байгаа тул бид түүнийг нь аваад цааш хөгжье. Энэ тохиолдолд зардал хэмнэнэ, цаг хугацааг хожно, ашигтай ажиллана. Компани бол эдийн засгийн гол суурь хөгжил юм. Хувийн хэвшлийнхэн эдийн засгийн 80 хувийг үйлдвэрлэнэ гэдгийн цаана компани л байгаа шүү дээ.

-УИХ төрийн өмчийн компаниудын засаглалыг шинэчлэх сайжруулах

► **хуулийн төслийг удахгүй хэлэлцэхээр байгаа. Хэдийд хэлэлцэх вэ?**

-Энэхүү процессийг эрчимжүүлэх дэмжих төрөөс эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох хүлээлт байна. УИХ-аар удахгүй хэлэлцэж багтах байх аа.

Олон шатанд шинэчлэл хийх хэрэгтэй болно. Хамгийн эхлээд системээ шинэчлэх, мөн эрх зүйн орчноо боловсронгуй болгох, улс төрийн нөлөөллөөс ангид байх гэх мэт.

-Сингапурын Темасекийн загвараар Монголын төрийн компаниудыг хөгжүүлэхээр зорьж байгаа юу?

-Темасек бол компани компани шиг ажилласнаар амжилт авчирдагийн үлгэр загвар. Өмнө нь Сингапурын төрийн компаниуд мөн л ашиггүй ажилладаг, систем нь буруу явж, эзэндээ ашгаа өгдөггүй, төр нь ийм компаниудаа өөр нүдээр хардаг байсан байгаа юм. Харин засаг нь төрийн оролцоотой компаниудаа компани шиг ажиллуулах зорилго тавьж, төрийн өмчит компаниудын статусыг нь авч хаяснаар өнөөгийн хөгжлийн түвшинд хүрч. Мэдээж нэг сар, нэг жилийн дотор хийдэг процесс биш. Сингапур орны туршлагаар гараад ирсэн энэ загварыг л Монголынхоо хөрсөнд буулгаж, хөгжүүлэхийг зорьж байгаа. Түүнээс Темасекийг тэр чигээр нь хуулна гэсэн үг биш. Ер нь дэлхийд алдартай энэхүү загварын гол нууц нь боловсон хүчин, хүндээ байна гэдэг. Тухайн салбар, тухайн ажилд дэлхийн хамгийн чадварлаг хүмүүсийг авч ажиллуулж хөрөнгийн менежмент хийлгэдэг учир Темасек ашигтай, амжилттай ажиллаж, эзэн нь болох Сингапурын иргэдэд ашиг авчирдаг байна.

-Таны удирддаг компаниудад энэ жишгээр хамгийн сайн менежер, ажилтнуудыг ажиллуулах боломжгүй юу?

-Байхгүй. Гэхдээ хүсвэл болно. Үнэнийг хэлэхэд хязгаарлагдмал орчинд чадварлаг менежерүүдийг авчирч, хангалттай цалин, урамшуулал болон компанийг ашигтай ажиллуулах хэмжээний бүрэн эрхийг нь өгөөд явахад боломж өнөөдөр хомс.

-Төрийн компаниудын удирдлагуудыг байсхийгээд л өөрчилдөг. Захирлуудыг солилоо гээд том өөрчлөлт гардаггүй. Таны ярьснаар засаглалыг сайжруулж, системээр нь өөрчлөхгүй бол хэчнээн дарга солиод дорвитой үр дүн харагдахгүй байна шүү дээ?

-Өнөөдөр төрийн өмчийн компаниудын захирлыг улстөрчид томилдог. Тухайлбал, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирлыг Засгийн газраас томилдог. Үүнийг л өөрчилж шинэчлэе гэж байгаа. Уг нь компанийн эзэн ТУЗ-өөр дамжуулан үйл ажиллагааг удирддаг байх ёстой. Компанийн тухай хуулиар аливаа компанийн гүйцэтгэх захирал ТУЗ-тэй гэрээ хийж, хариуцлагаа ч хүлээж, компанийг ашигтай ажиллуулахын төлөө ажиллах ёстой. Манай хувийн компаниуд сүүлийн 25 жил хөгжлийн олон шаг дамжлагаар яваад ирлээ. Тэд ийм л зарчмаар удирдлагаа сонгож, гүйцэтгэх захирал ТУЗ-ийн өмнө ажлаа тайлагнаж ирсэн. Төрийн компаниудын удирдлагуудыг ТУЗ томилж, ажлын хариуцлага тооцдог системийг л нэвтрүүлэхээр бид ажиллаж байна.

-Уг нь бол таныг Ерөнхий сайд биш ТУЗ дуудаж уулзах ёстой. Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн, сайд дарга нар таныг дуудах ёсгүй ийм л систем бол Темасек. Манайх болохоор эсрэгээр байна.

-Тиймээ.

-Таны хувьд дэлхийн стандартыг Монголд мөрдөж байж улс хөгжих тухай их ярьдаг хүн.

-Яагаад олон улсын стандарт шаардлагатай байна вэ? Өнөөдөр зөвхөн Монгол дотроо ажилладаг явдал өнгөрсөн байна. Манай эдийн засгийн өсөлт дэлхий дээр юу болж буйтай уялджихсан байна шүү дээ. Тухайлбал, дэлхийн эдийн засаг яаж байна, АНУ-ын Төвбанк ямар шийдвэр гаргав, Хятадын үйлдвэрлэл өсөв үү, буурав уу гэдэг нь бидэнд маш их хамаатай болж. Даяаршсан эдийн засгийн орчинд ажиллаж, амьдарч буй хүмүүс гэдгээ бид сайтар ойлгох хэрэгтэй. Ийм нөхцөлд зөвхөн дотоодын, өөрсдийн мэддэг стандартаа мөрдөөд яваад байж болохгүй биз дээ. Бусад орон олон улсын нэгдсэн ойлголт бүхий стандарт дүрмээр тоглож, дэлхийн зах зээлээс мөнгө босгож, үйл ажиллагаагаа тэлээд хөгжөөд байдаг, гэтэл бид дотроо л өөрсдийн дүрмээр яваад байвал яаж хөгжих вэ.

Тиймээс олон улсын стандартыг нэвтрүүлж мөрдөх шаардлагатай. Энэхүү стандартыг мөн дахин зохиох хэрэггүй. Хувийн компаниудын хувьд энэ дүрмийг аль дээрээс ойлгож ухаараад санхүүгийн тайлан балансаа олон улсын стандартын компаниудаар хийлгэж ирсэн. Олон улсын зах зээлээс хөрөнгө босгох болоход

энэхүү тайлан баланс бэлэн байдаг. Үүнийг л төрийн өмчтэй компаниудад нэвтрүүлэхийг зорьж байгаа юм. Дэлхийн стандарт нь тийм хэцүү зүйл биш. Түүнийг авч хэрэглэхийн тулд бид ажлын арга барил, ойлголт, үйл ажиллагаагаа сайжруулах, шинэчлэл хийх ёстой.

-Сүүлийн үед төр ачааллаа хувийн хэвшил рүү шилжүүлэх бус харин төрийн өмчтэй компаниудын тоог нэмээд байгаа. Та энэ шийдвэрийг хэрхэн харж байна вэ?

-Буруу. Эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байгаа гол зүйлүүдийн нэг нь төр, засгаас бизнес рүү хэт орж байгаа явдал гэдэг нь ойлгомжтой. Өнөөдөр бизнес хийхэд хууль, дүрэм журам болоод өөр бусад зүйлс ойлгомжгүй, тодорхойгүй байх юм бол бизнесмэнүүд бизнесээ урт хугацаанд төлөвлөж чадахгүй. Урт хугацаанд бизнесээ төлөвлөх нь нь бизнесийн өрсөлдөх чадварын гол үзүүлэлт. Би 5,10 жилийн дараа компани тийм хэмжээнд хүргэнэ гээд орлого, зарлагаа тооцно. Гэтэл орчин тогтворгүй өөрчлөгдөөд байвал урт хугацааны төлөвлөлт байхгүй болно. Өрсөлдөх чадвараар дээгүүр ордог орнуудад хууль, журам нь тогтчихсон, огт өөрчлөгддөггүйгээрээ хурдацтай хөгжлийг бий болгосон байдаг. Тус орнуудын. Энэ нь хувийн ч, төрийн ч компаниудад ялгаагүй мөрдөгддөг. Холыг харж бизнес хийх нь улсын хөгжилд тустай. Ойрын зайны тоглолт байнга хийхээр маргааш, дараа жил юу болохыг мэдэхгүй. Мөн компани чадавхжихгүй, хөгжихгүй.

-“Эрдэнэс Монгол” компанийн ажил өнөөдөр ямар явж байна вэ?

-Бидний гол зорилго үйл ажиллагаагаа олон улсын компанийн санхүүгийн менежментийн дагуу явуулахаар ажиллаж байна. Манай эдийн засагт том төслүүдийн үүрэг их учраас тэдгээр төслийг явуулах нь чухал байна. Оюутолгойн гүний уурхайн төсөл урагшилчихлаа. Багануур, Шивээ-Овоо компаниудын олон улсын зах зээлээс хөрөнгө босгох ажлыг удирдаад явж байна. Тавантолгой төслийг яаж ашигтай ажиллуулах вэ гэсэн хувилбар дээр ажиллаж байна. Олон ажил байгаа ч холдинг компанийнхаа хувьд стратегиа баримталж, зангидан гол ажлууд дээрээ төлөвлөгөөтэйгээр төвлөрч ажиллахыг хичээж байна. Бид том өөрчлөлтийн эхэнд байна гэж хэлж болно. ■



Тавантолгой

Эргүүлэг

Ард түмний гархиар наадаж, олон талд талцуулж буй Тавантолгойн асуудал өдгөө наашаа ч үгүй, цаашаа ч үгүй ацан шалаанд орчихов. Гэхдээ хэний гарт өгч, хэдэн төгрөг авах вэ гэдэг маргаан Тавантолгойг тойгослоор сунжирч байна. Зарим нэг нь яарах хэрэгтэй гэж байхад нөгөө хэсэг нь яарах хэрэггүй гэж иргэдийн толгойг яах учраа олохгүй болтол эргүүлж буй. С.Ганбаатар гишүүн “Ард иргэдэд тодорхой мэдээлэл өгөхгүйгээр нүүрс үнс боллоо гэх мэтээр яаруулж, Тавантолгойг явуулах гэж байна” гэж үзэж байна.

Тавантолгойн нийт нөөцийн дөрвөн хувийг эзэмшдэг “Энержи Ресурс” компани Хятадын Шинхуа, Японы Сүмитомо компанитай хамтран консорциум байгуулан Засгийн газраас зарласан тендэрт ялсан. Товчхондоо, “Энержи Ресурс”-ийн хувьд Шинхуа нь төмөр замтай түнш, Сумитото нь маркетингийн түнш. Энэхүү консорциумтай Монгол Улсын Засгийн газар Хамтын ажиллагаа, Хөрөнгө оруулалт, Төмөр зам гэсэн гурван төрлийн гэрээ байгуулах ёстой байсан ч УИХ-ын дарга З.Энхболд түгшүүр төрүүлэм мэдэгдэл хийж, УИХ-аар хэлэлцүүлэхээр болсон. Тус гэрээг дөрвөн удаа зүсээ хувиргаж орж ирсэн нь “но”-г нь илтгэж буй нэг

жишээ гэж үзэж буй хэсэг бий. “Эхнийх дээр Засгийн газар гарын үсэг зурсан бол гэмт хэрэг болох байлаа” гэж УИХ-ын даргын хуулийн бодлогын зөвлөх А.Гансүх хэлсэн.

Ингээд л гэнэт нойрноосоо сэрсэн мэт УИХ-н гишүүн бүр санал бодлоо хэлж, тоож эхэллээ, Тавантолгойг. УИХ-ын дарга З.Энхболд “Байгуулахаар төлөвлөж байгаа эдгээр гэрээ, хэлэлцээрийн төслийг харахад Монгол Улсын үндэсний эрх ашгийг хангаж чадаагүй. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын үүрэг тодорхой хугацаатай байгаа бол нөгөө талын үүрэг нь хугацаагүй, зорилтын шинж чанартай, зорилт биелэгдээгүй тохиолдолд хүлээх хариуцлага байхгүй байна” гэсэн.

Тавантолгойн ордын Хөрөнгө оруулалтын гэрээг УИХ-ын чуулганаар оруулж хэлэлцүүлэх эсэх дүгнэлтийг гаргах зорилготой ажлын хэсэг хүртэл байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг “Өнгөрсөн гурван жилийн хугацаанд Тавантолгойн асуудал УИХ-руу нэг ч удаа орж ирээгүй. Өнөөдрийн миний ахлаж байгаа ажлын хэсгийнхэн 15 хоногийн өмнө Тавантолгойн талаарх эхний материалаа авсан. 76 гишүүнээс хамгийн их мэдээлэлтэй байгаа нь би

болоод байна. Бусад гишүүнд мэдэхгүй зүйл нэлээд байгаа. Тиймээс энэ гэрээ энэ чигтээ явах боломжгүй” гэж эхний дүгнэлтээ гаргасны дараа хэлсэн. Гэхдээ нэг асуулт байна. Монголын гурван сая иргэнийг төлөөлөн суугаа УИХ-н гишүүд энэ орны хувь заяатай холбоотой асуудлын талаар сайн мэдэхгүй, мэдээгүй, сонирхож үзээгүй өдий хүрсэн нь хэний буруу вэ.

Зөвлөх А.Гансүх хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл гэрээ сунгагдах боломжтой нь энэ гэрээ хязгааргүй хугацаатай ч байх боломжтойг харуулж байна гэсэн. Үүнийг хамгийн ноцтой гэрээний заалт гээд байгаа. Мөн Засгийн газар гэрээг цуцалбал, консорциумд гэрээний үлдсэн хугацаанд хийсэн хөрөнгө оруулалт дээр олох байсан ашгийн 20 хувийн өгөөжийг жил бүрээр тооцож өгнө гэсэн нөхцөл байгааг хэлсэн. Энэ тал дээр MCS группын ерөнхийлөгч Ж.Оджаргал “Хөрөнгө оруулагч дөрвөн тэрбум ам.доллар оруулаад дуустал гэнэт нэг сайд нь гарч ирээд гэрээг цуцална гэвэл бид яах вэ” гэсэн юм. Оюутолгойн гэрээг жишээлбэл, гэрээг цуцалсан тохиолдолд олох байсан ашгийн 29 хувийг манай Засгийн газар төлнө. Ийм заалт гэрээнд тусгагдахгүй бол Монголд хэн ч хөрөнгө оруулахгүй. ▶



► Учир нь иймэрхүү заалтыг хөгжиж буй манайд байтугай, хөгжингүй орнуудад ч түгээмэл хэрэглэдэг.

Үүний зэрэгцээ консорциумын Монгол талын оролцогч “Энержи Ресурс” компанийг нийтдээ нэг тэрбум 23 сая ам.долларын өртэй гэх асуудлыг хурцаар тавьж, сөхөн ярилцаж буй. Харин энэ тухайд Ж.Оджаргал “Хөрөнгө босгох үүднээс гадаадад бүртгүүлсэн “Mongolian Mining Corporation” компани олон улсад бонд хэлбэрээр гаргасан 600 сая ам.доллар тус компани дээр үлдэх өр. “ММС” өөрөө төлнө. “Энержи Ресурс”-тай хамаагүй гэсэн. Тэрбээр мөн хэлэхдээ “Бид больчихож болно. Бидэнд хохиролтой л доо. Гэхдээ улсад л илүү хохиролтой” гэж буй.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн 14.1 зүйлд татварын дөрвөн төрлийг тогтворжуулсан заалт байгаа. Үүнд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Агаарын бохирдлын хураамж, Гаалийн хураамж, Аж ахуй нэгжийн орлогын албан татвар орж буй. Нүүрсний үнийг 80 ам.доллар байлаа гэж тооцоход, дээрх дөрвөн төрлийн татвар болон бусад төрлийн татвар хэлбэрээр улсын төсөвт доод тал нь жилдээ 202 сая ам.доллар төвлөрөхөөр байгаа аж. Энержи

Ресурсын хувилбараар бол улс ямар нэг эрсдэл үүрэхгүйгээр хил дээр борлуулж байгаа үнээс татвар авна. Гэхдээ гэрээ ёсоор менежментийг консорциум бүрэн хариуцахаар байгаа. Үүнийг нөгөө талаас төрийн оролцоог хааж, хамаг эрх мэдлээ консорциум өөр дээрээ төвлөрүүлэх гэж байна гэж харж байна. С.Ганбаатар гишүүн энэ талаар “Өөрөө ухна, өөрөө зөөнө, өөрийнхөө үйлдвэрт өгөх гэж байна” гэж тайлбарлаж буй. Тэгвэл Тавантолгойн ордод хувь эзэмшлээ гэж бодоё. Оюутолгой шиг 34 хувь эзэмшлээ гэхэд тэр хэмжээгээр бид хөрөнгө оруулалт босгож, хөрөнгө оруулагч талтай зардлаа хуваах болно. Өдгөө Оюутолгой дээр үүнээс үүдэлтэй асуудлууд гарчихаад л гацаад байгаа. “Монгол улсын хуулинд байгаа бүх татвар, хамтран ажилласны төлбөр авна. Бид Оюутолгойн гэрээг яг ийм л байсан бол гэж өчнөөн жил харамсч ярьсан. Одоо тэгвэл тэр мөрөөдлийн гэрээг Тавантолгой дээр хийчихлээ” хэмээн Ард санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг хэлж байгаа

Хэн нь чадах вэ

Тавантолгойг 2010 оноос эдийн засгийн эргэлтэд оруулах ажил эхэлсэн. Эл орд дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Австралийн ЖОРК стандартаар үнэлбэл 7.4 тэрбум тонн коксжих нүүрсийн нөөцтэй. Нүүрсний үнийг хамгийн багадаа 50 ам.доллар гэж тооцоолбол 250 тэрбум ам.долларын борлуулалтыг ирэх 50 жилд хийхээр байна гэж Д.Жаргалсайхан эдийн засагч саяхан нэгэн нийтлэлдээ бичсэн. Харин Л.Эрдэнэчимэг гишүүний хэлж байгаагаар одоогийн хувилбараар гэрээг батлаад явбал бүх ашгаа нийлүүлээд Тавантолгойгоос 20 хувийг авахтай үгүйтэй байгаа аж. Харин МУ-ын сайд М.Энхсайхан тэргүүтэй төслийг хариуцаж буй хүмүүсийн тооцооллоор нүүрсний үнийг 70 ам.доллараар бодоход Засгийн газар, хөрөнгө оруулагч хоёр 78:22 гэсэн харьцаагаар орлогоо хувааж байгааг саяхан олонд тайлагнасан.

Яг одоо УИХ дээр Тавантолгойн ордыг “Энержи Ресурс” тэргүүтэй консорциумд өгөхөөс илүүтэй “Эрдэнэс Тавантолгой”-гоор удирдуулбал илүү өгөөжтэй гэх хувилбар ч нэлээд газар авч байгаа. Дахиад тэндэр ч зарлах юм шиг санал явж буй. УИХ-ын гишүүн Х.Баттулга “Энержи ресурсын хувилбараар явбал 20 гэр бүл тасартлаа

баяжина. Эрдэнэс Тавантолгойн хувилбараар явбал 20 жилийн дотор Монгол хөгжинө” гэж дүгнэсэн. УИХ гишүүн Л.Эрдэнэчимэг “Өөр өөрөөр тайлбарлаад толгой эргүүлээд байгаа болохоос яг харьцуулаад харвал “Эрдэнэс Тавантолгой” уг төсөлд орж ажилласан нөхцөлд л ашигтай байгаа. Одоогийн зурагдах гэж байгаа гэрээ бол Монголыг худалдах гэж байгаа нь шууд харагдана” гэсэн юм.

Төрийн хувь эзэмшлийг амжилттай удирдаж буй компаниуд бусад улсад байдаг. Тухайлбал, Сингапурт Тимасек, Хятадад Хөрөнгө оруулалтын корпораци зэрэг төрийн өмчит, зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаг хүчирхэг компаниуд бий. Гэхдээ тэд бүгд улс төрөөс хараат бусаар үйл ажиллагаагаа зохиомжилсон байдаг. Манайх шиг улс төрийн ертөнцөөс хамааралгүй явж чаддаггүй орны хувьд “Эрдэнэс Тавантолгой” компани уг төслийг хэрэгжүүлдэг дээрээ тулбал, ахиад л улс төржүүлээд, олон ашиг сонирхол зөрчилдөхгүй гэсэн баталгаа байхгүй. Сайхан санаа гэхдээ төр өөрийнхөө гарыг өөрөө ардаа хүлж, баглаагүй цагт бүтэхгүй хувилбар. Яагаад “Шинхуа” “Эрдэнэс Тавантолгой”-той хамтрах тухай ярьж байсан атлаа Энержи Ресурсын үүдийг тогшиж орж ирсэн бэ. Учир нь Эрдэнэс Тавантолгой төр хэмээх муу менежертэй.

“УИХ, Тавантолгой дээр ямар нэг хувийн шалтгаан байхгүй. Том төслийг явуулахын тулд энэ чиглэлээр УИХ-ын даргатай уулзаж, ярилцаж байгаа. Цаашдаа асуудлыг шийднэ” хэмээн Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэлсэн. Гэхдээ л Тавантолгойн асуудлыг хэзээ УИХ хэлэлцэх нь тодорхойгүй байсаар л байна. Төрийн оролцоог хэт хазаарласан гэрээ учир сайжруулаад батлая гэсэн хэсэг бүлгээс илүүтэй бүр унагаа гэсэн хэсэг давамгайлж байгаа нь ажиглагдаж буй. Монголын эдийн засгийн талтай тэнцэх асар их мөнгөний тухай Та бид ярьж байна. Нүүрс үнс болдоггүй юм аа гэхэд, бид Тавантолгойн асуудлаа хурдан шийдэхгүй аваас олон улсад эзлэх байр суурь жижгэрч, Хятадыг гаталж, гурав дахь зах зээлд гарах мөрөөдөл биднээс алсарсаар байх нь дамжиггүй. Ядуу байх хэцүү. Баян байх бүүр хэцүү юм. ■

Бүтээн байгуулалт

Гүний уурхайн гүн ухаан

Том нэрс зүүлгэж, тоймгүй олон тэгээр үргэлжлэх тодорхой тооны зээлийг Монгол Улс

асар богино хугацаанд өрийн дансандаа нэмж бичүүлсэн. Ингээд олсон хамгаараа иргэдээ “халамжилж”, хотоо цэцэгжүүлэхийн хажуугаар “888” хэмээн төсөл нэртэй цаас цуглуулсан бүхнийг эрхлүүлээд дуусахад эдийн засаг бас л дагаад “дуусав”.

Хоёр чихнээсээ хагацах дээрээ тултлаа

хоосорсон монголчууд өрийн дарамтад орж дампуурах тухай бодож суутал Ойрхи Дорнодын баянбүрд гэгдэг тэртээх Дубай хотоос таатай мэдээ дуулдах нь тэр. Гэрээ биш төлөвлөгөө, нууц байгаагүй ил тод мэдээлсэн гэх мэтээр өдгөө маргасаар байгаа ч олон улсын хөрөнгө оруулалтын тавцанд навс унаад байсан Монголын нэр хүндийг хэдэн алхам өөд ахиулав. “Discovery Channel”, “National Geographic” тэргүүтэй олон улсын томоохон сувгууд Монголын тухай нэвтрүүлгүүдээ ээлж дараалан цацаж эхэлсэн нь манай орон бусдын анхаарлыг ахин татаж эхэлсний хамгийн энгийн жишээ.

Амь тавихад ойр ирээд байсан Монголын эдийн засаг “Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-р сэхэл авсан гэж болох. Орж ирэх “ногоон”-ы сургаар зарцуулалт хийх жагсаалт ч гараад амжсан. Гэвч “Оюутны 70” гэх мэтээр бас л үрээд дуусах вий гэсэн болгоомжлол бий.

Монголын эдийн засгийн өсөлтөд хүчилтөрөгч болохуйц бүтээн байгуулалт Оюутолгой нэрээр олны танил болоод өдгөө зургаан жилийг үджээ. Хүний насаар бол бага ангийн “сурагч” болох нь. Гэтэл монголчууд энэхүү хүүхдээ сургана, сургахгүй хэмээн талцаж, чангаасаар байгаа нь шалдаа буусаар буй Монголын нэр хүндийг эргээд шаварт хутгаж мэдэх юм.

Ийм учраас улстөржих бус асуудлын гүн юу болохыг сийрүүлэхийг оролдлоо.



Төлөвлөгөөнд юу тусгав

Тус орд газартай холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ анх 2009 онд хүчин төгөлдөржсөнөөс хойш ил уурхайн бүтээн байгуулалт, үйл ажиллагаа чамлахааргүй их өгөөжийг Монгол Улсад өгсөн гэдэг. Гэвч Оюутолгойн уурхайн баялгийн 80 хувь нь буюу “алтан авдар” нь газрын гүнд оршиж буй. Гүний уурхайн бүтээн байгуулалт, цаашлаад үйл ажиллагааг эхлүүлснээр манай улсын эдийн засаг хэрхэн сэргэх талаар дотоод, гадаадын эдийн засаг, судалгааны байгууллагууд дүгнэлт, анализ гаргасаар байгаа. Түүнчлэн “Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд “Гүний уурхайн техник, эдийн засгийн үндэслэлд /ТЭЗҮ/ дурьдсанаар Оюутолгой төслийн эдийн засгийн үр ашгийн хуваарилалт нь 2010 оны ТЭЗҮ-д тооцсон тооцоололтой нийцэж байгаа ба үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар Оюутолгой төсөл хэрэгжих хугацаанд төслийн нийт үр ашгийн 53 гаруй хувийг татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг хэлбэрээр авахыг цохон тэмдэглэж байна” гэжээ. Түүнчлэн гүний уурхайн үе шатны бүтээн байгуулалт, үйл ажиллагааны зардал, Монгол Улсын Засгийн газарт төлөх төлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт зарцуулагдах зардлын тооцоо, бүтээн

байгуулалтын ажлын болон зардлын төлөвлөгөөг тоймлон гаргажээ.

Төлөвлөгөө юу авчрах вэ

Гүний уурхайн бүтээн байгуулалт зөвхөн мөнгөний хүүдий биш. Амьдралын шинэ стандарт, шинэ туршлагыг Монголд нэвтрүүлэх шинэлэг өөрчлөлт хэмээн төсөл хэрэгжүүлэгч талаас хэлж буй. Тус уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөнөөс эшлэн дурьдвал ““Оюу Толгой” ХХК Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, тэр дундаа Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгож, тэдний нийлүүлж буй бараа, үйлчилгээг болон Монгол Улсад үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэргийг цаг хугацаа, тоо хэмжээ, чанарын хувьд өрсөлдөхүйц байх нөхцөлтэйгөөр тэргүүн ээлжинд худалдаж авна” гэжээ. Үүнээс үзэхэд, Оюутолгойн төслийг дагаад үндэсний ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа идэвхжих, улмаар ажлын байр шинээр бий болох гээд олон давуу тал ундрахаар байгааг онцлох нь чухал. Гэвч эдгээр боломж, бололцоо зохих шаардлагуудыг хангасан нөхцөлд хөрөнд буух боломжтой аж. Тодруулбал, “Оюу Толгой” ХХК гүний уурхайн үе шат (гүний уурхайн ТЭЗҮ-д заасны дагуу Хойд Хьюго ордыг ашиглах гүний уурхайн нэгдүгээр давхрын бүтээн байгуулалтын ажил, далд уурхайгаас олборлох хүдрийг боловсруулах зорилгоор баяжуулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцэд хийх өөрчлөлтийг ойлгоно)-ыг санхүүжүүлэх гуравдагч этгээдийн төслийн санхүүжилтийг авах шаардлагуудыг хангахын зэрэгцээ оролцогч талуудын ТУЗ тус бүрээр багтлуулсан байхаар заажээ. Биеллээ олох ээлжээ “хүлээж” буй мега төслүүдийн нэг Оюутолгой дээрх мэтээр өгөөжөө хүртээх учиртай. Гэвч ордын 34 хувийг эзэмшиж буйн хувьд Засгийн газар өөрийн зүгээс хийх ёстойгоо хийх нь бизнест оролцох тэргүүний зарчим. Тэгвэл үүний илрэл гэж болох эхний алхам бол гацаах биш урагшлуулах. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайханы хэлснээр Оюутолгойн орд дэлхийд өрсөлдөхүйц томоохон уурхай болоход гүний уурхайн бүтээн байгуулалт тун чухал үүрэгтэй төдийгүй өнөөгийн үнэ цэнээр тооцвол гүний уурхайн бүтээн байгуулалтаас 50 орчим тэрбум ам.долларын өгөөж хүртэх ▶

► боломжтой аж. Бизнесийн ийм зарчмаар явах учиртай энэ төслийг “эрүүлээр” үргэлжлүүлбэл Монгол Улсад шинэ хөрөнгө оруулалт татах, эдийн засаг сайжрах гээд эерэг нөлөө их гэдгийг тэрбээр хэлсэн юм. Тэгвэл “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Да.Ганболдын үзэж буйгаар гүний уурхайн үйл ажиллагаа эхлэхтэй уялдан гаднын дэвшилт технологи Монголд нэвтрэх боломж бүрдэх аж. Түүний онцолсноор монголчууд хоёр хөршөөсөө хоол горьдож суух биш дэлхийн бусад томоохон гүрэнтэй бизнес түншлэл бий болгох гарц үүснэ.

Монголын эдийн засгийг сэхээн амьдруулах төлөвлөгөө гарсан нь сайн. Хэрэгжвэл бүр ч сайн. Гэвч цаасанд буулгаснаа амьдрал дээр хэрэгжүүлэхэд хэдэн хүний гарын үсэг хангалтгүй. Тоглоомын дүрмээ маш тодорхой болгох нь эхний алхам. Энэхүү шаардлагыг ч хангасан, нэг мөр ойлголцсон гэдгийг “Эрдэнэс Оюутолгой” болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагууд хэлсэн. Удаах алхам долоо орчим жил үргэлжлэх бүтээн байгуулалтын ажил. Үүнд уурхайн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан уул уурхайн “диваажинг” бий болгох асуудал багтаж буй. Гүний уурхайн бүтээн байгуулалтын чухал хэсэг болох туннел барихдаа нэг сумаар хоёр туулай буудах төлөвлөгөөтэй байгаа аж. Энэ нь туннел ухахын зэрэгцээ тодорхой хэмжээний олборлолт хийнэ гэсэн үг. Хэдийгээр төлөвлөсөн хугацаанаас хавьгүй олон жил шаардлагатай байж болох ч ирэх долоон жилийн дотор гүйцээх зорилго тээн жигд олборлолтыг эхлүүлэхээр “Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд тусгажээ.

Мөнгө хөөсөн хүн мөнгө хөөсөөр үхдэг гэдэг үг бий. Иймд Оюутолгойн гүний уурхайг зоосон нүхээр харах нь учир дутагдалтай. Эл ордыг тойрсон асуудалд мөнгө гэсэн нэг талыг хэт барьж, мэдээлж, тайлбарлаж буй нь тус ордыг мөнгөний гахай мэтээр ойлгоход хүргэж байгаа юм.

Гэвч эл орд зөвхөн байгалийн баялгийн уурхай биш дэлхийн стандартад стандарт тогтоох бүтээн байгуулалтын асар том “соёл” гэдгийг ойлгох цаг нэгэнт болжээ. ■

2015 оны 06 сар. №092

Оюу толгойн хоёр дахь шатны санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурлаа



Оюу толгойн гүний уурхайн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурах ёслол 2015.12.16-нд “Шангри-Ла” зочид буудлын хурлын танхимд боллоо. Нийт 4.4 тэрбум ам.долларын санхүүжилтийг дэлхийн 20 гаруй банк, санхүүгийн байгууллагаас авч байгаа юм.

Ёслолд Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Уул уурхайн сайд Р.Жигжид, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Ганболд болон “Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Батсүх, “Оюу Толгой” ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Эндрийо Вүдлэй, Рио Тинтогийн Зэс-нүүрс хариуцсан Гүйцэтгэх захирал Жан Себастьян Жак нар оролцлоо.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг ёслолын үеэр хэлсэн үгэндээ энэ өдрийг удаан хүлээснээ онцлоод “Өнөөдрөөс эхлээд Оюу толгой ямар нэгэн улс төр, Засгийн газрын асуудал биш цэвэр бизнесийн төсөл болж байна. Одоо Монголын хувийн хэвшлийнхэн хөрөнгөө оруулах, өөрсдийнхөө түншийг олж авах, зээл авах үүд хаалга нь нээгдэж байна. Монголчууд бизнестээ буцан ирлээ” гэсэн юм.

Харин “Рио Тинто” группын Зэс-нүүрс хариуцсан Гүйцэтгэх захирал Жан Себастьян Жак хэлэхдээ “Төслийн хувьд Оюутолгой уурхайг дэлхийн чансааны ач холбогдолтой болгох гэрээнд гарын үсэг зурж

байна. Энэ санхүүжилтээр Монгол Улсад асар их эерэг нөлөөллийг бий болгох бүтээн байгуулалтын ажил хийнэ” хэмээн онцолжээ. Мөн тэрээр Монгол Улсын Засгийн газар энэ ажилд түүчээлэн оролцож буй болон хөрөнгө оруулж буй банкуудад талархлаа илэрхийлээд “Ийнхүү итгэл үзүүлэн санхүүжилт өгч буй нь энэ төслийн чансааг харуулж байна” хэмээсэн юм.

Харин Оюу Толгой ХХК-ийн Монголын талын хувь эзэмшигч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан “Оюу толгой бол Монголын компани, Монгол бизнес, Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварын суурь юм. Өнөөдөр төслийн санхүүжилтийг авснаараа санхүүжилтийн өртгийг багасгаж байна. Ийнхүү зардлаа багасгаснаар ирээдүйд олох ашгаа нэмэгдүүлж, ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлж өглөө” гэлээ. Тэрээр үгийнхээ төгсгөлд Оюу толгой төсөл Монголын эдийн засагт эерэг дохио өгч байгааг дурьдаад “Монгол компаниуд ойрын гурван жилд олох орлогоо тооцоолох боломжтой болж байна” гэжээ.

Оюутолгойн гүний уурхай ажиллаж эхэлснээр ордын нийт баялгийн 80 хувийг олборлох боломжтой болох юм. Төслийн эхний шагна хөрөнгө оруулалт 2011 онд хийгдэж ил уурхайн олборлолтыг 2013 онд эхлүүлснээс хойш 1.5 сая тонн зэсийн баяжмал үйлдвэрлээд байна. ■

Элчин сайд

Япон, Монголын шинэ түншлэл ба боломж

Монгол Улс Японы хувьд экспортоор 74 дүгээр байрыг эзэлж байгаа бол импортоор 126-д ордог орон. Гэхдээ хоёр орны хоорон дахь Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр /ЭЗТХ/-ийн хүрээнд олгогдож буй боломжуудыг Монгол сайн ашиглаж чадвал энэхүү байр сууриа өндөрсгөх боломжтой гэж Монгол Улсад суугаа Японы Элчин сайд Шимизү Такэнори хэлж байна. Тэрбээр Япон улс Монголыг хөгжиж чадна гэж итгэж буй учир ЭЗТХ байгуулсан хэмээн хэлсэн юм. Шимизү Такэнори нь Монголтой ажил амьдралаа холбоод 40 жил болж байгаа хүн. Түүний үндсэн боловсрол, мэргэжлийн чиглэл нь хууль эрх зүй, гадаад бодлого хэдий ч Монгол хэлийг сонирхон судалж, 1977-1978 онд МУИС-ийн монгол хэлний тусгай ангид суралцаж төгсжээ. Тэрбээр өдгөө Монгол хэлээр чөлөөтэй ярьдаг. Мөн Шимизү Такэнори сайд Монголын талаар олон тооны бүтээл нийтлэлийг туурвиж япон болон монгол хэл дээр хэвлүүлж байжээ. Манай сэтгүүл энэ удаад түүнтэй ЭЗТХ эцэслэгдсэнтэй холбоотойгоор яриа өрнүүлсэн юм.

-Монгол улс Япон улстай харилцаж ирсэн эдийн засгийн харилцаа ямар түвшинд явж ирэв. Хоёр орны эдийн засгийн харилцаанд сүүлийн жилүүдэд ямар дэвшил гарсан бэ?

-Тэртээ 1990-ээд оноос хойш Япон улс Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд Монголын тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжсээр ирсэн. Өнөөг хүртэл Япон улсаас үзүүлсэн буцалтгүй тусламж, иенийн хөнгөлөлттэй зээл, техникийн хамтын ажиллагааны нийт дүн ойролцоогоор 250 тэрбум иен буюу 2.3 тэрбум ам. долларт хүрч, Монголын зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбараас гадна эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан зэрэг нийгмийн салбаруудыг өргөнөөр хамарсан. Монгол Улс, ялангуяа газрын баялгаа ашиглан эдийн засгаа үсрэнгүй хөгжүүлэх болсон цагаас хойш Япон улсын хөгжлийн албан ёсны тусламжид



суурилсан нэг талт эдийн засгийн харилцаа бус, хоёр талт эдийн засгийн харилцаа тогтоохыг зорих нь зүйн хэрэг болсон юм.

Японы компаниудын Монголыг сонирхох сонирхол нэмэгдэж байгаа бөгөөд ялангуяа 2013 оны гуравдугаар сард Ерөнхий сайд Шинзо Абэгийн Монгол Улсад хийсэн айлчлалын дараагаас улам эрчимжин, Монголд орж ирэх компанийн тоо ч өссөн. Цаашид манай хоёр орны хувийн хэвшлийнхэн

нөөц боломжоо бүрэн дүүрэн ашиглан, эдийн засгийн харилцаагаа улам бүр хөгжүүлэх нь чухал. Үүнд гурван жилийн турш хэлэлцсэний эцэст энэ оны хоёрдугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” нь дээрх харилцааг хөгжүүлэх чухал хүчин зүйл болох юм.

-Өнгөрсөн хугацаанд гэрээ байгуулах хүрээнд ямар бүтээгдэхүүнүүд дээр голчлон онцолж тохиролцоонд хүрсэн бэ? ▶

► -Япон, Монгол хоёр улс нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрт ЭЗТХ-ийн үндсэн үзэл баримтлалыг нийцүүлэх үүднээс, гаалийн татварын тухайд “гадаад худалдааны нийт дүнгийн 90 буюу түүнээс дээш хувийг 10 жилийн дотор бүрэн тэглэх” гол зарчмыг баримтална. Үүний тулд эхлээд Япон улсаас Монголд нийлүүлэх нийт экспортын дүнгийн 70 орчим хувийг эзлэх автомашин болон машины сэлбэгийг гаалийн татвараас бүрэн чөлөөлөхгүйгээр ЭЗТХ-ийн үндсэн зарчмыг хангаж чадахгүй юм. Япон улс хуучин автомашины гаалийн татварыг тэглүүлэн, хуучин автомашины экспортыг дэмжиж байна гэсэн буруу ташаа ойлголт гарсан байж болзошгүй ч Япон улсын хувьд ийм сонирхол огтхон ч байхгүй. Хэлэлцээний дүнд гол хэрэглээ болох цилиндрин багтаамж нь 4500 см куб хүртэлх бүрэн угсарсан автомашиныг (үйлдвэрлэснээс хойш 0-3 жил болсон) ЭЗТХ хүчин төгөлдөр болмогц гаалийн татвараас шууд чөлөөлнө. Машин механизмын тухайд гэвэл, гол нэр төрлийн барилгын машин механизм (бульдозер зэрэг)-ын гаалийн татварыг шууд тэглэх, бусад машин механизмыг 10 жилийн дотор үе шаттайгаар чөлөөлөхөөр санал нэгдсэн. Харин үйлдвэрлэснээс хойш 10 ба түүнээс дээш жил болсон хуучин автомашиныг гаалийн татвараас чөлөөлөхгүй гэж тохиролцсон. Мөн гэрээ хүчин төгөлдөр болсноос хойшхи тав дахь жилдээ зах зээлд нэвтрэх нөхцөлийг сайжруулах болон бусад асуудлуудын талаар хэлэлцээ хийхээр заасан болно.

-Тэгвэл Монголын талаас түншлэлийн хүрээнд Японд хэдэн нэр төрлийн бараа нийлүүлэх вэ?

-Монголын талаас хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүнийг Японы гаалийн татвараас чөлөөлөх хүсэлтийг тавьсан ч уг барааг Японд эмзэг бараанд тооцдог. Хэлэлцээний дүнд чацарганы дарс зэрэг зарим чацарганы гаралтай бүтээгдэхүүн, тэжээвэр амьтны тэжээлийг татвараас шууд чөлөөлөхөөс гадна зарим боловсруулсан үхрийн махан бүтээгдэхүүн, жишээ нь “beef jerky” (хатааж боловсруулсан үхрийн мах), “corned beef” (нөөшилсөн үхрийн мах) зэрэгт гаалийн татварын квот тогтоохоор болсон. Одоогийн байдлаар үхрийн махны хувьд шүлхий өвчин зэрэг асуудлаас болоод түүхий мах экспортлох боломжгүйг анхааран үзээд, мал, амьтны эрүүл мэнд болон мал эмнэлгийн үйлчилгээ, сүү, сүүн бүтээгдэхүүн, үхрийн мах, органик

хүнс, үр тариа болон хүнсний ногооны үйлдвэрлэл зэрэг хөдөө болон мал аж ахуйн салбарт хамтран ажиллахаар тогтсон нь ч ЭЗТХ-ийн онцлог бөгөөд хоёр талын хэлэлцээний үр дүнд гарсан амжилт юм.

-Ирэх жилүүдэд Японы хөрөнгө оруулагчид Монголын зах зээл рүү идэвхтэй орж ирж, монголчуудтай хамтарч ажиллана гэж харж байгаа. Тэгвэл Япон компани болон хөрөнгө оруулагчид Монголд орж ирэхэд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр ямар давуу хөнгөлөлт боломжуудыг олгож байгаа вэ?

-Хөрөнгө оруулалтын хувьд, өмнө нь байгуулсан “Монгол Улс, Япон Улс хоорондын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр”-тэй харьцуулахад, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах тал дээр илүү ахиц гарсан, өөрөөр хэлбэл хувийн хэвшлийнхэн харилцагч орныхоо хөрөнгө оруулалтын зах зээлд гарсны дараа төдийгүй хөрөнгө оруулалтын зөвшөөрөл авах үе шат хүртлээ үндэсний нөхцөл, нэн тааламжтай үндэстний нөхцлийг эдлэх боломжтой. Жишээлбэл, Японы компани Монголд хөрөнгө оруулахад Монголын компанитай нэгэн адил нөхцөл, эсвэл дор хаяж Монгол гуравдагч оронд үзүүлдэг нэн тааламжтай нөхцөлийн аль нэгийг эдлэх боломжтой болно.

Үүнийг мэдээж зөвхөн Японоос Монголд төдийгүй, Монголоос Японд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд ч адил мөрдөнө. Монголын компаниуд Японд идэвхтэй хөрөнгө оруулалт хийх нь Монголын эдийн засагт эерэгээр нөлөөлөх нь гарцаагүй.

-Японы хөрөнгө оруулагчид Монголд орж ирэхэд одоо ямар хүндрэл бэрхшээл тулгарч байна гэж харж байгаа вэ?

-Японы Элчин сайдын яам нь Япон улсын Засгийн газрыг төлөөлөх байгууллагын хувьд Японы компаниудад тулгарч буй бүхий л асуудлын талаар шаардлагатай тусламж, зөвлөгөө өгдөг. Тэдний тавьж буй асуудлуудыг нэгтгэн үзвэл, нэгдүгээрт, Монголын хууль эрх зүйн орчин гэнэт өөрчлөгддөг, хоёдугаарт, хуулийн тайлбар нэгдсэн байдлаар тогтоогүй тул хариуцаж буй хүнээсээ хамааран харилцан адилгүй байх, гуравдугаарт, зөвшөөрөл, лиценз олгох журмыг хуулинд заасны дагуу хэрэгжүүлдэггүй, мөн хууль тогтоомж, дүрэм, гэрээг мөрдөх ёстой гэдэг ойлголт хэвшээгүй зэрэг асуудлууд голдуу гардаг.

ЭЗТХ хүчин төгөлдөр болсноор хөрөнгө оруулалтын болоод бизнесийн орчин сайжран, дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх арга зам, сайжруулах механизм бий болж эдгээр саад учруулж буй хүчин зүйлс буурна гэж найдаж байна.

-Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг ашиглан, Монголын барааг Японд экспортлоход шаардлагатай бичиг баримт бүрдүүлэлтийн талаар товчхон сонирхож болох уу?

-Монголын тал бүтээгдэхүүн экспортлоходоо ЭЗТХ-ийн тусгай хөнгөлөлттэй тарифын хэмжээг хэрэглэх хүсэлтэй бол хэлэлцээрт заасан гарал үүслийн дүрэмд үндэслэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас Монголын зохих гарал үүсэлтэй барааны шаардлага хангасан болохыг нотолсон гэрчилгээг авч, бусад заасан бичиг баримтын хамт гаалийн бүрдүүлэлтээ хийх шаардлагатай. Түүнчлэн, гаалийн татварын квотыг хэрэглэх үед, Монголын талд квотын шалгуурт нийцэж буй эсэхэд хяналт шалгалт хийн, энэ хүрээнд Японы гаалийн татварын квотын гэрчилгээг олгоход шаардлагатай бичиг баримтуудыг (экспортлох тоо хэмжээг тусгасан байх) экспортлогч этгээдийн мэдүүлэгт үндэслэн Монголын талын эрх бүхий төрийн байгууллага олгоно.

-ЭЗТХ-ийн бодит үр дүн хэзээнээс хэрхэн гарч ирэх бол. Ойрын үед гарах үр дүн нь аль салбарт ямар байх бол?

Худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал нь эдийн засгийн байдал, ханшийн өөрчлөлт зэргээс ихээхэн хамаардаг тул ЭЗТХ хүчин төгөлдөр болсноор ямар үр дүн гарахыг урьдчилан таамаглахад хэцүү хэдий ч хүчин төгөлдөр болмогц гаалийн татваргүй болох олон байгаа тул юуны өмнө бараа бүтээгдэхүүний худалдааны салбарт тодорхой үр дүн гарах болов уу. Өмнө нь ЭЗТХ-ийг байгуулсан улсуудын жишээг харахад импорт, экспортоос гадна хөрөнгө оруулалт ч мөн нэмэгдсэн байдгийг дурдах нь зүйтэй.

-Сүүлийн үед Монголын хөрөнгө оруулалтын орчин муудсантай холбоотой цөөнгүй гаднын компани Монгол дахь үйл ажиллагаагаа хумилаа. Тэгвэл Японы компаниудын хувьд байдал ямар байна вэ?

-Монголд ажиллаж буй япон компаниудын тоо эсрэгээрээ нэмэгдэх хандлагатай байгаа. Учир нь тэд байдал одоо хэцүү байгаа ч Монголын ирээдүйд итгэлтэй байна. Хэрэв байгалийн баялгаа зохистой ашиглаж чадвал хөрөнгө оруулалт сэргэж, эдийн ►

засаг сайжирна. Мөн хүндрэлтэй энэ үед ирж үйл ажиллагаа эхлүүлбэл ирээдүйд илүү амжилт олж мэдэх юм гэдэг яриа манай компаниудын дунд өрнөж байна. Өнгөрсөн онд гэхэд Японы хөрөнгө оруулалттай компаниудын тоо өмнөх жилтэй харьцуулахад 11-ээр нэмэгдсэн.

-Монголын хувийн хэвшил болон төр энэхүү эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг ашиглахын тулд ямар бэлтгэлүүд хийх шаардлагатай вэ?

-Мэдээжийн хэрэг, ЭЗТХ хүчин төгөлдөр болмогч хэлэлцээрийн агуулга бүгд нэг бүрчлэн хэрэгжиж эхэлнэ. Өөрөөр хэлбэл, ЭЗТХ-ийн бүх заалтуудыг хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоог бий болгохгүй аваас хүчин төгөлдөр болж чадахгүй. Иймд Монголын тал энэ нөхцөлийг яаралтай хангахын төлөө шуурхай ажиллах шаардлагатай байна. Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр хамтарсан хороо байгуулан, үйл ажиллагааны журам болон холбогдох дэд хороодыг байгуулах зэрэг хэлэлцээрт заасан олон зүйлийг шийдвэрлэнэ. Мөн хүчин төгөлдөр болсон өдөртөө гарал үүслийн гэрчилгээг олгох зэрэг ажил эхэлнэ.

Монголын хувьд анх удаа байгуулж буй ЭЗТХ учраас Монголын Засгийн газрын холбогдох байгууллагуудын ажилтнуудын сургалтаас эхлээд хэлэлцээрийг хэрэгжүүлэх тогтолцоог баттай бүрдүүлэх, нөгөөтэйгүүр хувь хүн, хувийн хэвшлийнхний ЭЗТХ-ийг ашиглахыг дэмжих үүднээс олон нийтийн сургалчилгаа, тайлбар зэргийг хийх нь чухал болов уу. Хувийн хэвшлийнхэн ч мөн өөрсдөөс шаардагдах бичиг баримтуудыг бүрдүүлснээр анх ЭЗТХ-ийн ашигтай тарифыг хэрэглэж болохыг ойлгож, ЭЗТХ-ийн бүтцийг сайтар судлаасай гэж зөвлөмөөр байна.

-Япон улс ЭЗТХ байгуулсантай холбоотойгоор Монгол руу өгөх Засгийн газрын буцалтгүй тусламж дэмжлэгээ тэглэж байгаа юу?

-Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4000 ам.доллар хүрэх гэж буй улс буцалтгүй тусламж авах статуст хамаарахгүй болдог. Тиймээс цаашид Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг зөв зохистой ашиглах нь Монгол Улсад хэрэгтэй болов уу. Жишээлбэл, шинэ онгоцны буудал барих хүрээнд өгсөн хөнгөлөлттэй зээлийн хүү ердөө жилийн 0.2 хувь байх жишээтэй. Ийм хөнгөлөлттэй зээлүүдийг ашиглаж болно. Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн Засгийн газар харин энэ чиглэлд илүүтэй анхаарч байгаад талархалтай байна.

10 жилийн дараах Монгол Японы эдийн засгийн харилцаа ямар түвшинд гарсан байна гэж Та төсөөлж байна вэ?

-Би хувьдаа нэгэн хүсэл мөрөөдлийг тээж явдаг. Улс төр, соёлын харилцаатай харьцуулахад удааршралтай хөгжиж буй Япон, Монгол хоёр улсын эдийн засгийн харилцаа нь ЭЗТХ-ийн бүхий л хүчин чадлыг ашиглан өргөжин хөгжөөсэй. Цаашид хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалт, худалдаа эргэлт улам нэмэгдэн, харилцан ашигтай, бие биенээ нөхсөн

эдийн засгийн харилцаа тогтож улмаар Япон, Монгол хоёр улс өөр хэн нэгнээр орлуулшгүй “Стратегийн түншүүд” болоосой хэмээн хүсдэг.

Монголоос Японд хөрөнгө оруулсан компаниудын дундаас Сүмогийн Их аварга шиг амжилт гаргах компани төрөн гарч, цаашлаад Монголын олон брэнд бүтээгдэхүүн Японы дэлгүүрүүдийн лангууг дүүргэсэн байх сайхан ирээдүйг төсөөлөн боддог. ■

2015.04 сар №086, 087

Өр

“Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч өртөмтгий байна”

*Биатрис Вэдер Ди Мауро
2001 оноос хойш Майнцын Иоханс Гутенбергийн их сургуулийн Олон улсын макро эдийн засгийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. Тэрбээр 2004-2012 онд Германы эдийн засгийн шинжээчдийн хорооны гишүүнээр, 2002-2004 онд Швейцарийн эдийн засгийн зөвлөхүүдийн хороонд ажиллаж байсан бөгөөд Австри улсын Дэд Канцлерын зөвлөх хийж байсан. Түүнчлэн 1994-1996 онд Олон улсын валютын санд эдийн засагч, тус байгууллагын судалгааны хэлтэст эрдэм шинжилгээний ажилтнаар уригдаж байсан удаатай.*

Тэрбээр манай улсад дөрвөн өдөр саатсан бөгөөд “UB Impulse: Чанартай өсөлт” цуврал лекцид уригдан “Улсын өрийн зохицуулалт: Европын холбооны туршилага” сэдвээр илтгэсэн. Энэ хүрээнд манай сэтгүүл түүнтэй Монгол Улсын өрийн асуудлаар ярилцсан юм.

-Грек, Аргентин хоёр орныг дэлхийн эдийн засгийн “нүдэнд орсон шороо” нь гэх болсон. Монгол Улсыг ч мөн дээрх орнуудтай харьцуулах болж. Та үүнтэй санал нэгдэх үү?

-Монгол Улсын хувьд өрийн хэмжээгээ бууруулж чадахгүй байгаа нь



Хуримтлал үүсгэж байж төсвийн алдагдлыг бууруулж, өрөөс мултарна

сэтгэл зовних нэг үндэслэл яах аргагүй мөн. Гэвч өрийн хэмжээг Грек тэргүүтэй орнуудтай харьцуулвал тийм ч өндөр санагдахгүй байна. Гэхдээ Монгол евро бүсийн улс биш. Ийм учраас Монголын ард, Грекийн адил Европын Төвбанк зогсохгүй. Европын Төвбанк Грекийн ▶

арыг дааж байгаагүй бол өнөөдөр тэд тэр хэмжээний өрөнд дарагдахгүй байсан. Тэгэхээр, дангаараа гэж болох Монгол шиг орнууд өр дааж даважгүй хэмжээнд асар хурдан хүрэх магадлалтай. Учир нь зээлдэгчид ажиглалтын байдалд шилжсэнээр зээлийн хүү өсөх аюултай. Иймд Монгол Улс өрийн хэмжээгээ бууруулахад анхаарах шаардлагатай. Үүнтэй холбоотой хууль, дүрмүүд байна. Гэхдээ хэрэгжүүлэх хэрэгтэй.

-Өрийн хэмжээг аль болох бага хэмжээнд барих хэрэгтэй гэлээ. Тэгвэл Монгол Улсын Засгийн газар өрийн асуудалдаа хэрхэн хандах ёстой юм бол?

-Өрийг бууруулах хэдхэн арга байдаг. Хэрэв инфляци бага, өсөлт бодит бол өрөөс мултрах арай хялбар болно. Хоёрдугаарт, бүтцийн өөрчлөлт. Гэхдээ улс орнууд бүтцийн өөрчлөлт хийх хүсэлгүй байдаг нь зээлдэгчдэд энэ нь таалагддаггүйтэй холбоотой. Гуравдугаарт, евро бүсийн орнуудын хэрэгжүүлж буй төсвийн таналт. Ингэснээр төр мөнгөний бодогоо чангалж, өрийн хэмжээгээ бууруулах боломж бүрдэнэ. Олон улсын валютын сангийн сүүлийн мэдээллээс харахад Монгол Улс бодлогоо чангагтаж, алхам алхамаар өрийн хэмжээгээ бууруулахыг зөвлөсөн байсан.

-Монгол Улсын Засгийн газар олон улсын зах зээл дээр бонд гаргасан. Харамсалтай нь, босгосон мөнгөө үрэн таран хийчихлээ гэсэн шүүмжлэлд нэлээдгүй өртөж байгаа. Харин одоо өмнөх бондын өрийг дарахын тулд ахин бонд гаргах тухай ярьж эхэлсэн нь ухаалаг алхам байж болох уу?

-Тийм ч оновчтой арга гэж хэлэхгүй. Хэрэв инфляци болон өр өссөөр байвал түүнийг санхүүжүүлэх хүндрэлтэй болно. Иймд мөнгөний хатуу бодлого барих хэрэгтэй. Ийм зүйлс байгалийн баялагт суурилсан эдийн засагтай орнуудад түгээмэл тохиолддог. Газар доорх баялагаа барьцаалах хэлбэрээр зээл аваад байдаг. Ингэх нь газар дор байгаа хөрөнгөө баялаг болохоос нь өмнө үрчихэж байгаа гэсэн үг. Өрийг өрөөр дарна гэдэг ухаалаг алхам биш. Яг ийм замаар Грек явсан. Өр, зээл асуудал дэгдээх хэмжээнд хүрч эхэлмэгц бууруулах арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай. Урд хормойгоороо хойд хормойгоо нөхөх замаар улам их өр тавиад байж болохгүй. Гадаад өр, валютын өр зэрэг нь ахархан хугацаанд асар өндөр болж орхидог. Тийм учраас тухайн улс ийм төрлийн хямралд

өртөхгүй байх асуудалд тун няхууртай хандаж байх хэрэгтэй. Монголын санхүүгийн үзүүлэлтүүдээс анзаарахад байдал тун муу харагдаж байгаа юм. Хямрал тохиохын өмнө эдийн засгийн үзүүлэлтүүд гэрэл, гэгээтэй харагдаж болох ч тэдгээрийн цаана оршиж буй бодит байдал хүндэрсэн болохыг хожуу олж харах нь түгээмэл байдаг.

-Тоонд хуургаж байна гэсэн үг байх нь?

-Тийм. Тухайлбал, Европын хямралын өмнөхөн банкуудын мөнгөн хөрөнгийн дүн боломжийн харагдаж байлаа. Гэвч мөнгөн хөрөнгө болоод эрсдэлийн тонн үзүүлэлт буруу болох нь багтагдсан шүү дээ. Аюул дэгдсэний дараа “ийм юм болно гэж мэдсэн юм” гэж хэлэх амархан байдаг. Харамсалтай нь, өмнө нь бүгд хэтэрхий тайван байсаар алдаж орхидог.

-Тэгвэл манай улсын хувьд бид өрийн дарамтад орохгүйн тулд юу хийх ёстой вэ, Монголын Засгийн газар өрийн таазаа ДНБ-ий 58 хувиас хэтрэхгүй байхаар тогтсон. Үүн дээр таны бодол?

-Тун энгийн. Хуримтлал үүсгэх хэрэгтэй. Тэгж байж төсвийн алдагдлыг бууруулж, өрөөс мултарна. Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн өнгөрсөн оны тогтвортой байдлын судалгаагаар Монгол Улсын өрийн эрсдлийг “тогтвортой, өрийн хэмжээ өсөх эрсдэл өндөр” гэсэн байсан. Энэ нь Монгол өрийн хямралд орох магадлалтай гэсэн үг. Дээрх судалгаанд тухайн улсын засаглалын, тухайлбал, улс төрийн, татварын болон хүнд суртлын зэрэг тогтвортой байдалтай хамаарах зүйлсийг харгалзан үздэг. Харин Монгол засаглалын хувьд тийм ч тогтвортой биш байна. Тэгэхээр Монгол Улс хямралд өртөх бүсэд нэвтэрсэн гэж үзвэл өссөөр буй өрийн хэмжээгээ сайтар хянах хэрэгтэй.

-Өнөөгийн өрийн хэмжээг авч үзвэл манай улс хяналт тогтоож чадах болов уу. Эсвэл Монгол Улс Грек, Аргентинийн араас орж мэдэхээр байна уу?

-Грек, Аргентинийн араас шууд орохгүй байх л даа. Хэдий тийм ч цаг алдах тусам байдал улам хүндрэх нь ойлгомжтой. Хасах динамик руу орсон л бол түүнийг залруулах хэцүү болно. Засгийн газрууд хэтэрхий удаан хүлээгээд байдаг. Тэд асуудлыг огоорч явсаар байдал хэтэрхий хүндэрсний дараа арга хэмжээ авч эхэлдэг. Зах зээл үймээд ирвэл итгэлээ алдана.

Тийм ч учраас эрсдэлийн зэрэг тогтоох хэрэгтэй. Монгол Улсын хувьд дампуурлаа зарлах хэмжээнд очих эсвэл тэр зүгт явах хүсэлгүй байгаа нь мэдээж. Тэгэхээр хөрөнгө оруулагчдын итгэлийг олох хууль, дүрэм бий болгох хэрэгтэй. Гэхдээ хамгийн чухал нь тэдгээр хуулиа чандлан мөрдөх. Ингэж байж хөрөнгө оруулагчдын итгэлийг алхам алхмаар олж авна. Хууль байгаад хэрэгжихгүй бол нэмэргүй. Нэр хүндийг асар их хөдөлмөрийн үр дүнд олж авдаг ч алдахаа хүрвэл тун амархан.

-Монголын Засгийн газар хаа хүрээд аюул нүүрлэлээ, буцах хэрэгтэй гэх ёстой юм бол?

-Одоогийн замналаасаа буцах цаг хэдийнэ ирчихсэн байна. Валютын нөөц багассан, өрийн эргэн төлөлт ойртсон, мөнгөн тэмдэгтийн ханш суларч байгаа нь валютын өрөө эргэн төлөхөд хүндрэл учруулна. Тэгэхээр төсөв, мөнгөний бодлогоо чангаруулах хэрэгтэй болж байна. Үүний зэрэгцээ илүүдэл зардлаа танах шаардлагатай. Түүнчлэн үүсээд буй нөхцөл байдалд хэнээс, хаанаас тусламж авах боломжтой тухайгаа бодох хэрэгтэй.

-Грек евро бүсийн нэг хэсэг биш гэж бодъё. Ийм өнцөгөөс авч үзвэл Монгол дараагийн Грек үү?

-Грект бүсийн нэг орон гэдэг утгаараа олон давуу тал байсан. Тэр хэмжээгээрээ ч өрийн ийм өндөр үзүүлэлттэй болсон. Тус улс Европын холбооны орон байгаагүй байсан бол тэр их хэмжээний өр хуримтлуулахгүй байсан шүү дээ. Монголын тухайд гэвэл, Грек шиг өрийн хямралд өртсөн нөхцлүүдтэй нүүр тулж байгаа нь үнэн. Жишээлбэл, санхүүгийн салбарын сул хөгжил, ашигт малтмалд суурилсан эдийн засагтай гэх мэт.

Үүн дээр нэмээд мөнгөн валютын хямралд өртөх эрсдэлтэй. Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч Грекийн адил өртөмтгий байна. Хямрал дангаараа ирдэггүй. Нэг нь нөгөөгөө бий болгож байдаг. Яг л нэг тийшээ харж байхад нөгөө талаас цохих мэт. Банкны салбар хамгийн хүнд байна гээд бодож байхад валютын эсвэл өрийн хямрал угтаж байх жишээтэй. Иймд Грек шиг болохгүйн тулд тэдний алдаанаас харж, суралцах хэрэгтэй. ■



Статистик

Ядуурал буурсан уу?

Нийслэлийн Засаг дарга

Э.Бат-Үүл:

Ядуурал буураагүй. Бүр өсөж, эгзэгтэй түвшинд очоод байна. Манай хөдөлмөрийн газрын судалгаагаар ядуурал 40 хувьд хүрчээ. Нийгмийн айл өрхийн ядуурал 40 хувьд хүрэх нь тухайн орны улс төр, эдийн засгийн дампуурлын үндсэн шалтгаан болдог. Наад зах нь ядуурал ихсэхээр бизнес дампуурдаг. Төлбөрийн чадваргүй иргэд худалдан авалт хийж чадахгүй шүү дээ...


Улаанбаатар хотын удирдлага ийн ядуурал өссөн тухай ярьсан бол Үндэсний статистикийн хорооноос өгч буй мэдээгээр жил ирэх тусам ядуурал буурч буй аж. Тус хорооноос ядууралтай холбогдох судалгааны мэдээллийг 2012 оноос хойш нийтэд мэдээлээгүй байгаа юм.





Ядуурал буурсан гэдгийг өмнөх тоо баримт харуулж буй ч Үндэсний нийт хэрэглээнд эзлэх хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний эзлэх хувь хэмжээ буураагүй. Харин ч 2008 оноос өмнөх жилүүдтэй харьцуулахад нэмэгдсэн болох нь харагдаж байна.

Нэг хүнд ногдох сарын хэрэглээний судалгаагаар баян ба ядуугийн ялгаа жил ирэх тусам улам нэмэгдэж буйг харуулж байна.



(Эх сурвалж: ҮСХ)